

# Лиахона



**Санваар:**  
**Бурханлиг хүч**  
**х. 14, 16, 19**

**Боловсрол: Ядуурлаас**  
**ангигирсан минь х. 42**

**Интернетэд тавигдсан**  
**мэдээлэлд болгоомжтой**  
**хандахыг хүүхдэд**  
**заах нь х. 64**

**Бие даах чадвар**  
**ба үйлчлэлийн 75**  
**жилийн ой х. 81**



### Ариун Сасквиеханна гол Глен С.Хопкинсон

1829 оны 5-р сарын 15-нд Пеннсилъваний Хармонид Иохан Баптист Иосеф Смит, Оливер Каудери нар дээр ирсэн билээ. Тэрбээр эртний Төлөөлөгчид Петр, Иаков, Иохан нарын удирдлага дор Иосеф, Оливер хоёрын толгой дээр гараа тавьж Аароны санваар олгосон юм.

Мөн Сасквиеханна голд Оливерыг Иосефт, Иосефыг

Оливерт баптисм хүртээхийг зааварласан. Тэд бие биедээ Аароны санваар олгосон билээ. (Иосеф Смит—Түүх 1:68–72; С ба Г 13:1-ийг үз.)

Хэдэн долоо хоногийн дараа Петр, Иаков, Иохан гурав Хармоний ойролцоо Иосеф, Оливер нар дээр хүрэмцэн ирж, тэр хоёрт ариун Мелкизедек санваар олгож, Төлөөлөгчөөр томилжээ (С ба Г 27:12; 128:20-ыг үз).



2011 оны зургадугаар сарын Лиакхона

**ЗАХИАСУУД**

- 4** Тэргүүн Зөвлөлийн захиас бичиг: Аравны нэгийн адислалууд  
Ерөнхийлөгч Хенри Б.Айринг
- 7** Айлчлагч багшийн захиас бичиг: Бие даах чадвараар дамжуулан гэр бүлүүдийг бэхжүүлэх нь

**ОНЦЛОГ ӨГҮҮЛЛҮҮД**

- 16** Санваарын адислалууд: Бурханд итгэж сурахуй  
Марк Л.Гровер
- 24** Би муу зуршлаасаа салахыг маш ихээр хүсэж байлаа  
Нэрийг нууцлав  
*Порнографтай урт удаан тэмцсэний эцэст би хэрхэн ялснаа өгүүлэхүй.*
- 28** Аз жаргалд хүргэх үнэний зам  
Ахлагч Квинтин Л.Кук  
*Аз жаргалд Висахапатнам*

- 34** Гэртээ аюулгүйгээр хөвж хүрэх нь  
Ричард М.Ромни  
*Энэтхэгийн Висахапатнам дахь залуус гэр орноо аюулгүй байлгасан нь*


- 81** Сүмийн халамжийн төлөвлөгөө

**ХЭСГҮҮД**

- 8** Өчүүхэн бөгөөд энгийн зүйлс
- 11** Сүмд үйлчилсэн нь: Зөвлөлөөр адислагдсан нь  
Ахлагч М.Рассел Баллард
- 12** Бид Христийн тухай ярьж байна: Тэрбээр миний уй гашууг үүрсэн  
Жейн Блек
- 14** Бид юунд итгэдэг вэ?: Санваар бол Бурханы нэрээр үйлдэх эрх мэдэл

- 19** Бидний гэр орон, гэр бүл: Зөв шударга үлгэр жишээний хүч  
Жерри Стрингам
- 20** Сайн мэдээний сонгомол бүтээл: Гэрлэлтийн талаарх Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн үзэл баримтлал  
Ерөнхийлөгч Хью Б.Браун
- 38** Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн дуу хоолой
- 74** Сүмийн мэдээ
- 79** Гэр бүлийн үдшийн санаанууд
- 80** Биднийг дахин уулзтал: Бат бөх суурин дээр барих нь  
Жошуа Ж.Перки

**ХАВТСАН ДЭЭР**  
Нүүрэн дээр: *Мелкизедек санваарыг сэргээсэн нь* Уолтер Рейн. Ар талд: гэрэл зураг чимэглэлийг Маттью Рейпер



42

## 42 Боловсролын хүч

Сюзи Тагги Коелхо  
Калдас Нелсен

*Ээж надад “ядуурлаас гаргах нэг арга байна” гэж хэлэв.*



*Энэ дугаарт  
нуусан Лиахо-  
наг олоорой.*

*Санаа:  
Николоос  
асуугаарай.*

## 46 Асуулт, хариулт

*“Хүнд сорилтууд намайг  
илүү сайн болоход туслахаар  
өгөгдсөн үү эсвэл буруу замд  
орсныг минь анхааруулж  
байгаа Тэнгэрлэг Эцэгийн  
сануулга уу гэдгийг би хэрхэн  
ялгаж таних вэ?”*

## 48 Таны үлгэр жишээ чухал

Ахлагч Жозеф В.Ситати  
*Африкийн Кени улсын залуу-  
чууд сайн мэдээгээр амьдрах  
нь тэднийг болон бусад хү-  
мүүсийг хүчирхэгжүүлдгийг  
мэджээ.*

## 51 Шат шатаар: Сургаал ба Гэрээ 121:41–43

## 52 Үзүүлэн: Ариун ойн цоорхой

## 53 Номлолын талбараас: Сүнсний тэмдгүүд

Педро Оваллес

## 54 Загасчлахыг хүмүүнд заа



Адам К.Өүлсон  
*Аав минь өөд болсон хүнд  
хэцүү үед Тэнгэрлэг Эцэг минь  
надад тусалж билээ.*

## 58 Усан сэлэлтээс би юу сурав?

Марисса Томпсон  
*Үе тэнгийнхэн  
бүгдээрээ муу нөлөө  
үзүүлдэггүй.*



54



68

## 60 Их Эзэнд итгэ

Элайн С.Далтон

*Аав минь юуны учир хорвоог  
орхих ёстой болсон юм бол?  
Хуучин Гэрээний нэг судар  
надад хариултыг өгсөн юм.*

## 61 Тусгай гэрч: Бид сэргээгдсэн Сүмээр дамжуулан ямар адислалууд хүлээн авдаг вэ?

Ахлагч Л.Том Перри

## 62 Хүүхдийн Хэсгийг гэртээ авчрах нь: Сайн мэдээний анхдагч зарчмууд болон ёслолууд нь намайг Бур- хантай дахин амьдрах боломжтой болгодог

Ана Мариа Кобурн,  
Кристина Франко нар

## 64 Компьютероо унтраагаад надад хэл

Даниел Кеннигтон

*Хэрэв таагүй вэбсайт гарч  
ирвэл Коннор юу хийх ёстой-  
гоо мэддэг болжээ.*

## 67 Бидний хуудас

## 68 Миний гаргасан чухал шийдвэр

Ребека Шоо

*Николе баптисм хүртэж  
болох эсэхээ мэдэхийн тулд  
залбирчээ.*

## 70 Бага насны хүүхдүүдэд зориулав

**2011 ОНЫ ЗУРГАДУГААР САРЫН ДУГААР**  
**ЛИАХОНА 09686 363**

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн  
Сүмийн олон улсын албан ёсны сэтгүүл

**Тэргүүн Зөвлөл:** Томас С.Монсон, Хенри Б.Айринг,  
Диетер Ф.Угдорф

**Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга:** Боид К.Пакер,  
Л.Том Перри, Рассел М.Нелсон, Даллин Х.Өүкс,  
М.Рассел Баллард, Ричард Г.Скотт, Роберт Д.Хейлс,  
Жеффри Р.Холланд, Давид А.Беднар, Квинтин Л.Кук,  
Д.Тодд Кристофферсон, Нийл Л.Андерсен

**Эрхлэгч:** Пол Б.Пайпер

**Зөвлөхүүд:** Станли Ж.Эллис, Кристоффел Голден Бага.,  
Ёшико Кикучи

**Гүйцэтгэх захирал:** Давид Л.Фричнхт

**Редакцийн захирал:** Винсент А. Вон

**Зургийн дарга:** Аллан Р.Лоиборг

**Гүйцэтгэх редактор:** Р.Вал Жонсон

**Гүйцэтгэх туслах редактор:** Женифер Л.Грийнвүүд,  
Адам К.Өүлсон

**Туслах редактор:** Раян Карр

**Редакторын туслах:** Сюзан Баррет

**редакцийн ажилтнууд:** Давид А.Эдвардс, Маттью  
Д.Флиттон, Лаврина Портер Гаунт, Ларри Хиллер, Карри  
Кастен, Женифер Мэдди, Меллиса Меррил, Майкл  
Р.Моррис, Салли Ж.Одекерк, Жошуа Ж.Перки, Чад  
И.Фарес, Жан Пинбург, Ричард М.Ромни, Жанет Томас,  
Паул Ванденберг, Меллиса Зентено

**Гүйцэтгэх Зургийн захирал:** Ж.Скотт Нудсен

**Зургийн захирал:** Скот Ван Кампен

**Уран бүтээлийн менежер:** Жейн Анн Петерс

**Ахлах дизайнерууд:** К. Кимбалл Ботт, Томас С.Чайльд,  
Коллеен Хинкли, Эрик П.Жонсен, Скотт М.Моёо

**Уран бүтээлийн ажилтнууд:** Кали Р.Аррово, Коллетте  
Небекер Ауне, Ховард Ж.Браун, Жули Бёрдетт, Ренигальд  
Ж.Крисченсен, Ким Фенстермейкер, Катлийн Ховард,  
Деннис Кербай, Гинни Ж.Нилсон

**Хэвлэлийн эх бэлтгэгч:** Жефф Л.Мартин

**Хэвлэлийн захирал:** Крейг К.Седвик

**Хуваарилалт хариуцсан захирал:** Эван Ларсен

Нэгдсэн Улс, Канадаас бусад орнууд дахь захиалга болон  
үнийн талаар орон нутгийн Сүмийн хангамжийн төв болон  
тойрог, салбарынхаа удирдагчтай холбоо барина уу.

**Гар бичмэл болон асуултаа Liahona, Rm. 2420,  
50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150-0024,  
USA хаягаар; эсвэл электрон шуудангийн:**  
[liahona@ldschurch.org](mailto:liahona@ldschurch.org) хаягаар ирүүлнэ үү.

*Лиахона нь (Мормоны Номон дахь утгаараа бол "луужин"  
буюу "залагч") албани, англи, армен, бислам, болгар,  
вьетнам, гаити, герман, грек, дани, индонез, ирланд,  
испани, итали, камбож, кирибати, латви, литва, малагаш,  
маршалл, монгол, нидерланд, норвеги, орос, польш,  
португали, румын, самоа, себуано, солонгос, тагалаг, таи,  
тахити, тонга, украин, унгар, урду, фижи, фин, франц,  
хорват, хятад, чех, швед, эстони, япон хэлээр нийтлэгддэг.  
(Жилд нийтлэгдэх дугаарын тоо улс бүрд өөр байна.)*

© 2011 by Intellectual Reserve, Inc. Бүх эрх хамгаалагдсан.  
Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв.

*Лиахона дахь сэдэв, үзүүлэн, материалуудыг онцгой  
тохиолдолд арилжааны бус зорилгоор сүм болон гэрт  
ашиглахын тулд хувилж болно. Урлагийн бүтээлийг  
хуулбарлахыг хориглосон бол үзүүлэнг хувиан олшруулж  
болохгүй. Зохиогчийн эрхийн талаарх асуултаа Intellectual  
Property Office, 50 E. North Temple St., Salt Lake City,  
UT 84150, USA хаягаар; эсвэл электрон шуудангийн:  
[cor-intellectualproperty@ldschurch.org](mailto:cor-intellectualproperty@ldschurch.org) хаягаар ирүүлнэ үү.*

**For Readers in the United States and Canada:**

June 2011 Vol. 12 No. 3. LIAHONA (USPS 311-480)  
Mongolian (ISSN 1525-7584) is published six times a year  
(January, April, June, July, October, and December)  
by The Church of Jesus Christ of Latter-day Saints,  
50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150. USA  
subscription price is \$5.00 per year; Canada, \$6.00 plus  
applicable taxes. Periodicals Postage Paid at Salt Lake City,  
Utah. Sixty days' notice required for change of address.  
Include address label from a recent issue; old and new  
address *must* be included. Send USA and Canadian  
subscriptions to Salt Lake Distribution Center at address  
below. Subscription help line: 1-800-537-5971. Credit card  
orders (Visa, MasterCard, American Express) may be taken by  
phone. (Canada Poste Information: Publication Agreement  
#40017431)

POSTMASTER: Send address changes to Salt Lake Distribution  
Center, Church Magazines, PO Box 26368, Salt Lake City, UT  
84126-0368.

# Дэлгэрэнгүй мэдээллийг онлайнаас үзэж болно

[Liahona.lds.org](http://Liahona.lds.org)

## НАСАНД ХҮРЭГЧДЭД ЗОРИУЛАВ

**“Би муу зуршлаасаа салахыг маш ихээр  
хүсэж байлаа”** (х. 24) өгүүлэлд нэг хүн  
порнографт донтсоноо хэрхэн даван туулсан  
тухайгаа өгүүлжээ. Бид энэ сэдэвтэй холбоо-  
той өгүүлүүдийг [www.liahona.lds.org](http://www.liahona.lds.org) хаягт  
байршуулаад байна.



## ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛАВ



**Энэтхэгийн Висахапатнам  
дахь залуус** гэр бүлээсээ хүч  
чадлыг олж чаджээ (хуудас 34-  
ийг үз). Эдгээр залуусын гэрэл  
зургуудыг [www.liahona.lds](http://www.liahona.lds.org)  
.org-аас үзнэ үү.

## ХҮҮХДЭД ЗОРИУЛАВ



Зарим вэбсайт аюултай  
мэдээллийг агуулдаг  
(хуудас 64-ийг үз). Ха-  
рин [www.liahona.lds](http://www.liahona.lds.org)  
.org-аас **тоглоом, үйл  
ажиллагаануудыг  
үзэж болно.**

## ТӨРӨЛХ ХЭЛЭЭРЭЭ

Лиахона болон Сүмийн бусад материалуудыг олон хэлээр  
[www.languages.lds.org](http://www.languages.lds.org) –оос олж үзэж болно.

## ЭНЭ ДУГААР ДАХЬ СЭДВҮҮД

*Тоонууд нь өгүүллийн эхний хуудсыг зааж байгаа болно.*

**Аз жаргал, 20, 28**

**Адислалууд, 16, 38**  
39, 41

**Аравны нэг, 4**

**Ариун Сүнс, 62,**  
64, 68

**Баптисм, 62, 68, 73**

**Бие даах чадвар,**  
7, 81

**Боловсрол, 42**

**Болзоо, 19**

**Бэрхшээл, 12, 16,**  
39, 46

**Гэр бүл, 19, 20, 28,**  
34, 54, 70

**Гэрлэлт, 20**

**Гэрчлэл, 53, 80**

**Донтолт, 24**

**Есүс Христ, 12**

**Жишгүүд, 28, 48,**  
58, 64

**Залбирал, 67, 68**

**Итгэл, 60, 62**

**Итгэл, итгэл**  
хүлээх, 60

**Наманчлал, 19,**  
62, 64

**Нийгмийн Халам-**

**жийн Бүлэг, 7**

**Нинжин сэтгэл, 70**

**Номлолын ажил,**  
53

**Нөхөрлөл, 34, 58**

**Порнограф, 24**

**Санваар, 14, 16, 19,**  
38, 39, 41, 48, 51

**Судар судлах, 34**

**Сүнслэг нөлөө, 40**

**Сэргээлт, 52, 61**

**Уй гашуу, 12**

**Халамж, 81**

**Хэвлэл мэдээл-**  
**лийн хэрэгсэл, 64**

**Эцэг эх болох**  
**нь, 20**

**Үлгэр дууриал, 19,**  
28, 48, 54

**Үхэл, 12, 54, 60**

Ерөнхийлөгч  
Хенри Б.Айринг  
Тэргүүн Зөвлөлийн  
нэгдүгээр зөвлөх



# Аравны нэгийн адислалууд

**Б**идэнд өгдөг Бурханы зарлигуудын зорилго нь биднийг адислахын төлөө юм. Тэрбээр Өөрийн бэлгүүдээс хамгийн агуу нь болох мөнх амьдралыг бидэнд өгөхийг хүсдэг (С ба Г 14:7-г үз). Бид Түүнтэй хамт селестиел хаант улсад гэр бүлтэйгээ үүрд мөнх амьдрах бэлгийг хүлээн авахын тулд тэрхүү хаант улсын хуулиудаар амьдрах чадвартай байх ёстой (С ба Г 88:22-ыг үз).

Уг чадварыг хөгжүүлэхэд бидэнд туслахын тулд Тэрбээр энэ амьдралд бидэнд зарлигуудыг өгдөг билээ. Аравны нэгийн хууль бол биднийг бэлтгэх зарлигуудын нэг мөн. Бид энэ хуулиар бүх орлогынхоо аравны нэгийг Их Эзэнд өргөл болгох ёстой. Энэ нь бүр хүүхэд ч ойлгох энгийн хууль юм. Олсон бутархай мөнгөнийхөө аравны нэгийг хийсэн дугтуйг бишоптоо гардуулж байгаа олон хүүхдийг би харсан.

Аравны нэгээ бүрэн төлснөөс ирдэг олон адислалын нэг нь илүү өндөр шаардлагатай хуулиар амьдрах итгэлийг бий болгон хөгжүүлдэг явдал мөн. Бид селестиел хаант улсад амьдрахын тулд өргөлийн хуулиар амьдрах ёстой. Энэ



хуулиар бид өөрсдөдөө байдаг бүхнийг Бурханых гэж бодох ёстой.

Бид мөнх амьдралын бэлгийг хүлээн авахад энэ амьдралд юу хэрэгтэйг болон биднийг үүнд юу бэлтгэдгийг *ойлгохын* төлөө аравны нэгийг бүрэн төлөх доод тал нь гурван арга зам байдаг.

**Нэгдүгээрт:** Биднийг Сүмд аравны нэгээ төлөхөд Тэнгэр дэх Эцэг бидэн дээр адислалуудыг юүддэг. Аравны нэгээ үргэлж бүрэн төлдөг хүмүүс үүнийг үнэн гэдгийг мэднэ. Эдгээр адислалууд заримдаа сүнслэг заримдаа материаллаг байдаг. Адислалууд нь Их Эзэний тогтоосон цагт болон бидний хувьд чухам юу хамгийн сайн болохыг мэдсэний үндсэн дээр ирдэг.

Адислал ирсэн үед Бурхан бол амьдралд байдаг сайн сайхан бүхний эх сурвалж мөн гэдэгт итгэх итгэл маань өсөн нэмэгддэг. Бурханы бүх бүтээл бол Түүнийх юм гэдэг үнэнийг өргөлийн ачаар хүлээн зөвшөөрдгийг ойлгох нь төвөггүй юм. Тэр бидэнд өгсөн бүх зүйлсийнхээ дөнгөж 10-хан хувийг л эргүүлж өгөхийг хүсдэгт бид Түүнд хариу *талархдаг*. Өргөлийг биднээс хүссэн үед бид өргөлийн хуулиар амьдрахад илүү сайн бэлтгэгдэж чадна.

**Хоёрдугаарт:** Бид бүгд аравны нэгээ үргэлж бүрэн төлдөг байх юм бол өөрсдөдөө болон гэр бүлдээ хэрэгтэй байгаа зүйлсээ Бурханаас гуйхад нүүр бардам *байдаг*. Бид аравны нэгээ төлөх гэрээндээ үнэнч итгэлтэй байвал Тэрбээр адислалуудыг хальтал юүднэ гэж бидэнд амласан (Малахи 3:10-ыг үз). Иймээс аравны нэгээс ирдэг агуу адислалуудын нэг нь ирээдүйдээ итгэх бат итгэл юм. Нөхцөл байдал ямар ч

байсан бидний сайн сайхны төлөө юмс үйлчлэх болно. Бид амлалтаа биелүүлбэл Тэрбээр мөн амлалтаа биелүүлнэ. Аравны нэгээ бүрэн төлөхөөс ирдэг агуу адислалуудын нэг бол амар амгалангийн мэдрэмж юм. Аравны нэгийн зарлигийг сахидаг хүмүүс амар амгалангийн адислал үнэн бодитой, үнэ цэнэтэйг гэрчилж чадна.

**Гуравдугаарт:** Аравны нэгээ төлснөөр Бурханыг болон Түүний бүх хүүхдүүдийг илүү ихээр *хайрладаг*. Бидний өгдөг аравны нэгийг Тэнгэрлэг Эцэг дэлхийн хүмүүсийг үүрд мөнхөд адислахын тулд хэрхэн ашигладгийг ойлгосноор энэхүү хайр өсөн нэмэгддэг билээ.

Тэрбээр эрх олгогдсон үйлчлэгчдээрээ дамжуулан аравны нэгийг ариг гамтайгаар зарцуулдаг. Аравны нэгийг төлөгчид нь гэр бүлүүд үүрд мөнхөд лацдан холбогддог ариун сүмүүд барихад Их Эзэнд тусалдаг. Аравны нэгийг төлөгчид газар бүрийн хүмүүст сайн мэдээг түгээхэд Түүнд тусалдаг. Аравны нэгийг төлөгчид Түүнд өлссөн, өвчилж зовсон хүмүүсийг үйлчлэгчдээрээ дамжуулан Өөрийн замаар эдгээхэд тусалдаг. Аравны нэгийг хүмүүсийг адислахад зориулдаг учраас үүний үр дүнд хайр өсөн нэмэгддэгийг үйлчлэгчид гэрчилж чадна. Мөн аравны нэгээ итгэлтэй төлөгч үүнийг хэлж чадна.

Хэдэн сарын дараа аравны нэгийн ярилцлага болно. Аравны нэгээ бүрэн төлдөг хүмүүст хүртээдэг Бурханы адислалуудад тэнцэхээр та болон таны гэр бүл одооноос төлөвлөн бэлтгээсэй хэмээн би залбирч байна. ■

## ЭНЭ ЗАХИАСААС ЗААХ НЬ

- Зарим үед тодорхой зарчмүүдийг заах хамгийн сайн арга зам бол тухайн юмыг үзүүлэх явдал байдаг (*Teaching, No Greater Call* [1999], 164-ийг үз). Аравны нэг юу болохыг харуулахыг гэр бүлийн нэг гишүүнээс хүсч болно. Жишээ нь: Тэр 10 юмнаас нэгийг авч тусад нь тавих замаар үүнийг харуулж болно. Эцэст нь гэр бүлийн нэг гишүүнээс аравны нэгийн хуудсыг бөглөж үзүүлэхийг хүс.
- “Зааж байгаа хүмүүс тань бие биеэсээ суралцах болно” (*Teaching, No Greater Call*, 63). Ерөнхийлөгч Айрингийн “мөнх амьдралын бэлгийг хүлээн авахад юу хэрэгтэйг *ойлгохын тулд*” гэсэн үгс юуг илэрхийлж байгааг ойлгосноо хуваалцахад гэр бүлийн гишүүдийг урь. Бурханы адислалуудыг хүлээн авах хэрэгцээгээ ухааран ойлгоход аравны нэг биднийг бэлтгэдэг гурван арга замын тухай ярилцахаар төлөвлө.

## ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛАВ

### Хангалттай мөнгө

Фабиано дос Сантос да Сильва

**Б**и 17-той байхдаа номлогчидтой уулзсан. Тэр үед би том ахтайгаа хамт амьдардаг байлаа. Урьд жил нь ээж маань өөд болж, амьдрал хүнд байлаа. Номлогчдоос хичээл авч эхэлснээр энэ Сүм бол миний хайж байсан сүм мөн болохыг мэдэрч байсан ч найз нарын маань нөлөө ням гараг бүр сүмд явахад саад болж байв.

Нэг удаа долоо хоногийн дундуур зохиогдсон Сүмийн үйл ажиллагаанд очлоо. Залуус инээлдэж, хамтдаа тоглож байсан нь надад агуу баяр баяслыг авчирч билээ. Номлогчид залуустай хамт надад сайн мэдээний хичээлийг заасан юм. Хичээл надад их сайхан санагдаж, ингээд би баптисм хүртэхээр шийдлээ.

Гэвч Сүмд нэгдсэний дараа ч би сорилт бэрхшээлүүдтэй тулгарч байлаа. Би тэр хавьдаа цорын ганц Сүмийн гишүүн байснаас гадна цуглааны байраас хол амьдардаг байлаа. Гишүүн бус найз нар маань надтай найзлахаа болилоо. Тэгээд ганцаардсан үедээ залбирч, Их Эзэний хайрыг мэдэрч билээ.

Би ээжийнхээ үлдээсэн мөнгөнөөс өөрт ноогдох багахан хувийг сар бүр авдаг байв. Тийм бага мөнгөөр амь зууна гэдэг хэцүү байлаа. Гэвч би дуулгавартай байхаар шийдсэн юм. Аравны нэгээ төлдөг байснаас гадна семинар, ням гарагийн цуглаануудад явахад унааны зардлаа бас төлнө. Яагаад гэдгийг мэдээгүй ч сарын эцэс гэхэд энэ бүхэнд хүрэлцэх хангалттай мөнгө байдаг байлаа.

Аравны нэгээ төлснөөр адислагдсанаа би мэднэ. Энэ зарлигт дуулгавартай байсан нь илүү бат бөх гэрчлэлтэй болж, номлолд үйлчлэн, адислалуудаа таньж мэдэхэд тусалснаар би сорилт бэрхшээлтэй тулгарч байсан шинэ гишүүдийг хүчирхэгжүүлж чадахаар болсон билээ.

## ХҮҮХДЭД ЗОРИУЛАВ

### Би аравны нэгээ төлж чадна

**А**равны нэгийг төлнө гэдэг нь бид орлогынхоо **10 хувийг** Их Эзэнд өгнө гэсэн үг юм. Ажил хийж байгаа энэ гурван хүүхдийг хар л даа. Зураг бүрийн эхний хоосон зайд энэ гурван хүүхэд тус бүр хийсэн ажлынхаа хөлсөнд ямар хэмжээний мөнгө авна гэж бодож байгааг бич. Хоёр дахь шугаманд тэдний төлөх аравны нэг нь хэд байхыг бич.




---



---




---



---




---



---

**Шагналт асуулт:** Эдгээр аравны нэгээ төлөгчдөөс хэн нь хамгийн их адислал хүлээж авах вэ? (Санаа өгөх: Ерөнхийлөгч Айрингийн захиасын сүүлчийн догол мөрийг үз.)







## Бие даах чадвараар дамжуулан гэр бүлүүдийг бэхжүүлэх нь

**Б**ие даах чадвараа хөгжүүлэн — өөрсдийгөө болон гэр бүлээ асран халамжлах нь — эгч бүрийн үүрэг хариуцлага билээ. Бид ажил хөдөлмөрт шимтэж, өөрсдийн хэрэгцээг хангахаар гэр бүлийн гишүүдтэйгээ хамтран ажиллах шилдэг арга замуудыг эрэлхийлснээр бие даах чадварыг олж авдаг.

Бид бие даах чадвартай байвал адислал, нөөц боломжуудаа аливаа асуудлуудаас гарах болон эдгээрээс зайлсхийхдээ ашигладаг. Мөн тулгаран ирэх аливаа саад бэрхшээлүүдийг итгэлээр даван туулах хүч зоригийн төлөө залбирахад бидний бие даах чадвар илүү өсдөг байна. Энэхүү бие даах чадвар маань бусдыг асран халамжлах гэрээгээ сахих боломжийг бидэнд олгодог.

Нийгмийн Халамжийн Бүлэгт бид бие даах чадварын зарчмууд болон арга барилуудаас суралцдаг. Эгч нар санхүүгээ төлөвлөх, өр зээлнээс ангижрах, ажил эрхлэх ур чадварууд, судрууд болон сайн мэдээ, бусдад унших бичихийг заах, биеийн эрүүл мэнд, фитнес, донтолоос ангижрах болон зайлсхийх, нийгмийн болон сэтгэл зүйн эрүүл мэнд, өвчнөөс урьдчилан сэргийлэх, цэцэг ногоо тарих, хүнсний үйлдвэрлэл болон нөөц, зайлшгүй тохиолдолд бэлэн байх зэрэг биднийг бие даах чадвартай байхад туслах олон зүйлд суралцдаг.<sup>1</sup>

Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхий ерөнхийлөгч Жюли Б.Бек тайлбарлахдаа, “өөрсдийгөө болон бусдыг тэтгэх нь биднийг Их Эзэн Есүс Христийн шавь гэдгийг нотолдог юм. . . Манай [хадам ээж] өнгөрсөн жил нас барахад нь түүний бие даасан амьдралаар амьдарч байсан нотолгоо үлдсэн билээ. Тэр ариун сүмийн хүчинтэй эрхийн бичигтэй мөн хуучирч элэгдтэл нь хэрэглэсэн судар болон сайн мэдээний суралцах гарын авлагуудтай байв. Түүний олон жил хэрэглэсэн хуучин сав суулга, хайруулын таваг, аяга шанагыг бид дуртайяа хувааж авсан. Хуучин хувцсаар зүйж хийсэн хөнжлүүдийг тэр бидэнд үлдээсэн байлаа. Тэр “Хэрэглэж дуусга, өмсөж элээ, юм ханаар юм хий” гэсэн хуучны хэлц үгэнд итгэж, үүнийг хэрэглүүлдэг байв. Бид түүний тарьж ургуулж, бэлдэж нөөцөлсөн хүнсний нөөцийг харсан билээ. Түүний олон жилийн туршид орлого зарлагаа хичээнгүйлэн тэмдэглэдэг байсан санхүүгийн дэвтрүүд нь байв. Тэр арвиг хямгач амьдарч байсан бөгөөд зайлшгүй тохиолдолд хэрэглэхээр мөнгө хадгалсан байв. Мөн тэр ямар ч өр төлбөргүй байлаа. Хамгийн чухал нь тэрээр амьдралынхаа туршид олж авсан мэдлэг, ур чадваруудаасаа бусад хүмүүст зааж, тэдэнд нөлөөлсөн юм.<sup>2</sup>

*Энэ материалыг судалж, гэрээр нь очиж заадаг эгч нартай аль болох тохиромжтой арга замаар ярилц. Эгч нарыг бэхжүүлэх болон Нийгмийн Халамжийн Бүлэг амьдралд нь идэвхтэй үүрэг гүйцэтгэхэд туслах асуултуудыг асуу.*

### Би юу хийж чадах вэ?

1. Би эгч нар болон гэр бүлийнхэнд нь бие даасан байдлаа хөгжүүлэхэд нь хэрхэн тусалж чадах вэ?
2. Би өөрийнхөө бие даасан байдлыг хэрхэн хөгжүүлэх вэ?

Нэмэлт мэдээллийг [www.reliefsocietylds.org](http://www.reliefsocietylds.org) ооc үз

### ЭШЛЭЛ

1. *Handbook 2: Administering the Church* (2010), 9.4.2-г үз.
2. Жюли Б.Бек, “The Welfare Responsibilities of the Relief Society President,” *Basic Principles of Welfare and Self-Reliance* (2009), б.
3. (*Teachings of Presidents of the Church: Brigham Young* [1997], 231.)

### Бидний түүхээс

Нийгмийн Халамжийн Бүлгийн эгч нар бодгалиудыг материаллаг болон сүнслэгээр аврах ажилд байнга оролцсоор ирсэн. Науву дахь Эмэгтэйчүүдийн Нийгмийн Халамжийн бүлэг долоо хоног бүр цуглан тусламж шаардлагатай хүмүүсийн талаар ярилцаж, ажлаа тайлагнадаг байлаа. Тэд мөнгө, бараа таваар, авьяас чадвар, цаг заваа тусламж хэрэгтэй хүмүүсийг халамжлахад зориулж байв. Хэцүү, зовлонт байдлаас ангижруулах энэхүү үндсэн ажил нь үеэс үед Нийгмийн Халамжийн Бүлгийн ажил болон үргэлжилсэн юм.

Гэгээнтнүүд Солт Лейкийн хөндийд ирэх үед Ерөнхийлөгч Бригам Янг (1801–1877) эгч нарт өөрсдийн амьдралаа авч явахад туслахуйц сайн ур чадваруудыг эзэмшин, тусалцаа хэрэгтэй нэгнээ дэмжин туслахыг зөвлөж байв. Тэрбээр хэлэхдээ, “Өөрсдийгөө сайн сайхан авч явахад суралц мөн үр тариа гурил нөөцөл, хүнд хэцүү өдөр ирэхэд хэрэглэхээр хадгал” гэжээ.<sup>3</sup> Санваарын удирдлаган дор Нийгмийн Халамжийн Бүлэг нь бие даах чадварт сургах, гэр бүлээ хамгаалан бэхжүүлэх, хувийн зохиистой байдал болон Христийн цэвэр хайр, энэрлээр үйлчлэхийг зоригжуулан дэмждэг.

### Судраас

Иохан 13:34–35; Иаков 1:27; Мозая 4:26; Сургаал ба Гэрээ 29:34–35; 38:30; 44:6



# Өчүүхэн бөгөөд энгийн зүйлс

“Агуу болох тэрхүү зүйл жижиг зүйлүүдээс гарч ирдэг” (С ба Г 64:33).


## СҮМИЙН ТҮҮХ ДЭЛХИЙ ДАХИНАА

### Герман

Германд номлолын ажил 1840-1851 он хүртэл энд ердөө хоёрхон хүн л анхны хөрвөгчид болж, баптисм хүртсэн бололтой. Мөн тэр жил Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ерөнхийлөгч асан Жон Тейлор Мормоны Номын герман хэлний орчуулгыг хянах ажилд туслахаар Гамбургт иржээ. 1852 онд Гамбургт нэг салбар зохион байгуулагдсан ч анхны хөрвөгчдийн ихэнх нь хавчлагын улмаас Ютад цагаачлан ирсэн аж. Хожим нь Ютагийн Прово дахь Бригам Янгийн Академийн ерөнхийлөгч болсон Карл Г.Маезер тэдний дунд байжээ.


Дэлхийн I Дайны дараа ялангуяа 1921-1925 оны хооронд Германы Сүмд хөрвөгчдийн тоо эрс өссөн байна. Германы Номлол, Герман-Австрийн болон Герман-Швейцарийн Номлол болж хоёр хуваагдав. 1937 онд Германы Зүүн Номлол байгуулагджээ. Дэлхийн II Дайны үед номлогчдыг Германаас гаргасан юм. Тэднийг 1947 онд буцаж ирэхэд энэ орон Зүүн,

Баруун Герман болж хоёр хуваагдсан байлаа. Гэвч номлолын ажил үргэлжилж, 1985 оны 6-р сарын 19-нд Германы Фрайбергийн Ариун сүм Зүүн Германд коммунист орон дахь анхны ариун сүм болон онцгойлон адислагджээ. Хоёр жилийн дараа Баруун Германы Франкфуртэд ариун сүм онцгойлон адислагдав. Герман улс 1990 онд нэгдлээ.




Карл Г.Маезер төрөлх эх орон Германаас цагаачлан 1860 онд Ютад иржээ.

Германы Фрайбергийн Ариун сүм 1985 онд онцгойлон адислагдсан ажээ.



Дээд талд: Германы Мюнхен хотын байдал. Доод талд: Германы Франкфуртын Ариун сүм 1987 онд онцгойлон адислагджээ.



## Сайн мэдээ юм бүхний түрүүнд

**Н**омлогчид Самоад байдаг миний элэнц өвөөг олж, түүнд заасан юм. Өвөг эцэг маань Сүмд нэгдсэн учраас өөрийн зарим уламжлалт итгэл бишрэл, шашны зан үйлүүдийг хаях шаардлагатай болсон билээ. Манай гэрийнхэн Самоагийн өв уламжлалаар бахархдаг байсан ч өвөөгийнхөө үлгэр жишээний улмаас сайн мэдээг бүхний түрүүнд тавьж сурсан юм.

Намайг залуу байхад аав маань бүх нийтийн дунд түгээмэл байсан овгийн уламжлалт шивээс болон Сүмийн сургаалуудад нийцэхгүй хоол хүнсний тухай надад ярьж билээ. “Эдгээр зүйлст бүү оролц. Өмнө нь чи Самоа хүн, арлын залуу байсан харин одоо чи бол Бурханы хүүхэд мөн” гэж аав маань хэлсэн билээ. Үүнийг би үргэлж санаж явдаг.

Одоо эхнэр бид хоёр Коста Рикад амьдарч байна. Аль ч газар байдагтай адил энд ч гэсэн Сүмийн заадаг зүйлстэй үл нийцэх уламжилж ирсэн соёл заншил, ёс журам байдаг. Бид заримдаа эдгээр ёс заншлуудаас татгалзаж, Есүс Христийн сайн мэдээний сургаалуудаар амьдрахын тулд зориг гаргах шаардлагатай болдог.

Морган Са Матаалий, Коста Рика

## Mormon.org-д өөрийн танилцуулах хуудсыг нээ.

**Д**элхий даяарх Сүмийн гишүүд Mormon.org-т өөрийн танилцуулах хуудсыг нээж, сайн мэдээг хуваалцаж болно. Энэ сайтыг үзэгчид эдгээр танилцуулах хуудсаас Сүмийн тухай гишүүдээс нь шууд мэдэж болно. Танилцуулах хуудсаа нээж, дараах алхмуудаар гэрчлэлээ хуваалц:

1. **Mormon.org-г орж**, танилцуулах хуудас нээ. LDS account-аа (ХҮТ-ний бүртгэлээ) ашиглан Sign in-дээр дар. Хэрэв танд LDS account байхгүй бол гишүүнчлэлийн бүртгэлийн дугаар, төрсөн он сар өдрөө оруулаад хэрэглэгчийн нэр, нууц үгээ оруул. Гишүүнчлэлийн бүртгэлийн дугаараа ариун сүмийн зөвшөөрлийн бичиг дээрээсээ эсвэл тойргийнхоо буюу салбарынхаа бичиг хэргийн ажилтнаас ав.
2. Дараах хэсгүүдэд мэдээллээ оруул “About Me,” “Why I Am a Mormon,” “How I Live My Faith,” “Frequently Asked Questions,” “Personal Stories,” “Additional Information.”

3. Танилцуулах хуудсаа нээсэн үед та Сүмийн гишүүн бус хүмүүстэй харилцах болно гэдгээ сана. Тэдний мэдэхгүй байж болох үг, хэллэгээс зайлсхий. Жишээ нь: та “Би Нийгмийн Халамжийн бүлэгт хичээл зааж үйлчилдэг” гэхийн оронд “Би насанд хүрсэн эмэгтэйчүүдэд амьд бошиглогчдын үгсээс сард нэг удаа хичээл заадаг” гэж хэлж болно.
4. Өөрийн зураг, нэр, товч танилцуулгыг оруул. Хэдийгээр энэ шаардлагагүй ч та танилцуулах хуудсаа өөрийн блог, Facebook account эсвэл Twitter account-тай холбож болно. Овгийн нэр, оршин суудаг хот зэрэг хувийн тодорхой мэдээллийг оруулахаас зайлсхий.

Танилцуулах хуудас чинь дууссан бол зохицуулагчаар зөвшөөрүүлэхээр илгээх хэрэгтэй. Танилцуулах хуудас чинь зөвшөөрөгдсөн бол сайтад орж үзэгчид гэрчлэлийг чинь уншиж, Сүмийн тухай дэлгэрэнгүй мэдээлэл авахын тулд тантай холбоо барих боломжтой болно.



# Сүмийн ерөнхийлөгчдийн таавар

**Д**оорх бэлэг дурсгалын зүйл бүрийг Сүмийн аль ерөнхийлөгчийнх болохыг тааруул.



**1.** Нарны шил. Энэ нарны шилийг Сүмийн Ерөнхийлөгч Ютагийн нутаг дэвсгэр дэх амьдралтай танилцахаар явахдаа зүүж байжээ.

**2.** Бүрх малгай. Энэ малгай бошиглогчийн нийтээр мэдэх ганган төрх байдал, сайхан зангийн илэрхийлэл байлаа.



**3.** Онцгой үйлчлэлийн медаль. Сүмийн энэ Ерөнхийлөгч Нэгдсэн Улсын ерөнхийлөгч Двайт Д.Эйзенхаурын кабинетэд Хөдөө Аж Ахуйн Нарийн бичгийн даргаар ажиллаж байхдаа энэ шагналаар шагнагджээ.

**4.** Халамжийн тусламжийн тэмдэг. Энэ Ерөнхийлөгч Эдийн засгийн их уналтын үед Сүмийн халамжийн хөтөлбөрийг санаачлан, удирдаж байв.



**5.** Эмээл. Энэ бошиглогч Сонни Бой гэдэг мориндоо хайртай байжээ.

**6.** Тэмдэглэл. Энэ бошиглогч Сүмийн түүхийг хойч үедээ хадгалж үлдээх шийдвэр төгс байсан бөгөөд түүний тэмдэглэлүүд Сүмийн түүхийн хамгийн үнэ цэнэтэй эх сурвалж болдог ажээ.



**7.** БЯИС-ийн Иерусалим Төвийн гэрэл зураг. Сүмийн энэ Ерөнхийлөгч уг төвийг барих газрыг Иерусалимд олж авах талаар хэлэлцээр хийжээ.

**А** Бага Иосеф Смит. (1805–1844)

**Б** Бригам Янг (1801–1877)

**В** Жон Тейлор (1808–1887)

**Г** Вилфорд Вудрафф (1807–1898)

**Д** Лорензо Снөү (1814–1901)

**Е** Жозеф Ф.Смит (1838–1918)

**Ё** Хебер Ж.Грант (1856–1945)

**Ж** Жорж Альберт Смит (1870–1951)

**З** Давид О.МкКей (1873–1970)

**И** Жозеф Фиелдинг Смит (1876–1972)

**Й** Харольд Б.Лий (1899–1973)

**К** Спенсер В.Кимбалл (1895–1985)

**Л** Эзра Тафт Бенсон (1899–1994)

**М** Ховард В.Хантер (1907–1995)

**Н** Гордон Б.Хинкли (1910–2008)

**О** Томас С.Монсон (1927–)

**8.** Бичил өсгөгч. Энэ Ерөнхийлөгч энэ багажийг нүдний шилэн дээрээ суурилуулан хэрэглэдэг байж. Учир нь хавдрыг нь эмчлэхийн тулд түүний хоолойд хийсэн хэдэн удаагийн мэс засал түүний дууны өнгөнд нөлөөлсөн аж.



**9.** Таяг. Энэ Ерөнхийлөгч амьдралынхаа сүүлчийн жилүүдэд энэ таягыг тулж мөн үүгээрээ даллан Хожмын Үеийн Гэгээнтнүүдтэй мэндчилдэг байжээ.

**10.** Аравны нэгийн хуудас. Энэ Ерөнхийлөгч аравны нэгийн талаарх Иосеф Смитийн сургаалд онцгой ач холбогдол өгдөг байв.

**11.** Дээвэр дээр суудаг хийлч.

Энэ Ерөнхийлөгч уран зохиолд дуртай бөгөөд сонгодог зохиолоос нэг биш удаа эш татдаг байжээ.



**12.** Бичгийн машин. Энэ Ерөнхийлөгч Сүмийн хамгийн олон бүтээл туурвисан зохиолчдын нэг байв.



**13.** Илд. Сүмийн энэ Ерөнхийлөгч Наувугийн Торгон цэргийн захирагчийн алба хашиж байв.

**14.** Хэлхээ цэцэг.

Энэ бошиглогч Хожмын Үеийн Гэгээнтэн анхны номлогчдын нэг болон 15 настайдаа Хавайд ирж байлаа.

**15.** Халаасны цаг. Энэ бошиглогч энэ цагийг Картейжийн Шоронд болсон алагын өдөр зүүсэн байжээ.



**16.** Скаутын Мөнгөн одос үхрийн шагнал. Энэ Ерөнхийлөгч Сүм дэх Скаутын хөдөлгөөний гол дэмжигч байв.

# Зөвлөлөөр АДИСЛАГДСАН НЬ

## Ахлагч М.Рассел Баллард

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын



**О**лон жилийн өмнө намайг бишопоор үйлчилж байхад манай тойргийн нэгэн айлын тэргүүн нь ажилгүй болж, тэднийх хүнд байдалд оров. Миний санаа зовж, Сүмийн

тусламжийг санал болгохоор тэднийд очлоо. Сонирхолтой нь материаллаг тусламж үзүүлэх гэсэн миний саналд дуртай биш байсан учир би уг асуудлыг тойргийн зөвлөлд оруулав. Би нууцыг хадгалж, гайхалтай энэ гэр бүлийн талаарх өөрийн санаа зовнилыг тэдэнтэй хуваалцан, бид тэднийг хэрхэн адисалж болох тухай санал хүсэлтийг нь асуув.

Манай Нийгмийн Халамжийн бүлгийн ерөнхийлөгч тэдний материаллаг хэрэгцээг тодорхойлж, тэдэнд хэрэгтэй байсан эд зүйлсийг олж авахын тулд эхнэртэй нь очиж уулзахаар шийдсэн юм. Сүмийн хөтөлбөрийн дагуу энэ нь түүний үүрэг байлаа. Тэр миний хийж чадахааргүй ажлыг хоёр гуравхан хоногт багтаан амжуулж, тэр гэр бүл тусламжийн бараа бүтээгдэхүүнийг даруухан бөгөөд талархалтайгаар хүлээн авсан билээ. Ахлагч нарын чуулгын ерөнхийлөгч тэр гэрийн эзэнтэй зөвлөж, ажил олох талаар хамтран ажилласан нь түүний эрх, үүрэг байлаа. Манай Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхийлөгч тэдний байшинг яаралтай будах хэрэгтэйг ажиглаж, байшинг будах ажлыг санваартнууд болон дээд пристүүдийн бүлгийн хамтарсан хүчээр зохион байгуулжээ.

Би эцэг эх хоёртой нь ярилцах явцдаа тэднийх их өртэй бөгөөд байрны зээлээ төлөөгүй удаж байгааг нь олж мэдэв.

### ТУСЛАМЖ ХЭРЭГТЭЙ ХҮМҮҮСИЙГ ХҮЧИРХЭГЖҮҮ- ЛЭХ НЬ

“Тойргийн зөвлөлийн гишүүд байгууллагынхаа гишүүдийн хэрэгцээ, сайн сайхан аж амьдрал, сүнслэг байдлын өсөлт хөгжилтийн талаар мэдээлэлтэй байхыг хичээдэг. Тэд бас онцгой сорилт бэрхшээлтэй тулгарч байгаа эсвэл амьдрал ахуйн нөхцөл байдал нь өөрчлөгдөж байгаа гишүүдийн талаар мэдээлэлтэй байдаг. Энэ мэдээлэл нь тэдний тусламж хамгийн их хэрэгтэй хүмүүсийг бэхжүүлэх боломжийг олгодог.”

*Гарын авлага 2: Сүмийг удирдах нь (2010), 4.5.1.*

*Гарын авлага 2, 2010 оны 11-р сар болон 2011 оны Дэлхий дахины удирдагчдын сургалтын нэвтрүүлэг LDS.org-т тавигдлаа. Эхлээд “Menu”-уруу орж дараа нь “Serving in the Church”-г сонгоно уу.*

Би батлагдсан халамжийн удирдамжийг баримтлан, тэднийхэнд туслах ойрын төрөл төрөгсдийнх нь чадвар боломжийн тухай асууж лавласан ч тун бага зүйл олж мэдлээ. Гэвч манай Нийгмийн Халамжийн бүлгийн ерөнхийлөгч гэрийн эзэгтэй нь чинээлэг ахтайг нь олж мэдсэн байлаа.

“Ахтай холбоо барих шалтгаан алга л даа. Бид түүнтэй ярьсангүй олон жил болжээ” гэж тэдний эхнэр хэлжээ.

Би түүний байдлыг ойлгосон ч Сүмийн дүрэм журмыг баримтлах нь чухал гэдгийг мэдэж байв. Тиймээс би түүнтэй зөвлөлдөж, эцэстээ алс холын хотод амьдардаг ахтай нь холбоо барих зөвшөөрлийг түүнээс авлаа. Тэгээд түүнтэй утсаар ярьж, эмэгтэй дүү нь хүнд байдалд ороод байгааг тайлбарлалаа. Тэр хүн гурван өдрийн дараа Солт Лейк хотод ирж, дүүгийнхээ санхүүгийн асуудлыг зохицуулахад туслав. Тэр хооронд манай ахлагч нарын чуулгын ерөнхийлөгч нөхөрт нь цалин сайтай, тогтвортой ажил олоход нь туслав.

Гэвч хамгийн чухал нь тэд улам ойр дотно, эв нэгдэлтэй гэр бүл болсон явдал юм. Олон жил уулзаагүй, хол хөндий байсан ах, дүү хоёрын учран золгосон тэрхүү сэтгэл уярам агшныг би хэзээ ч мартажгүй гэж боддог. Ах нь хэдийгээр Сүмээс хөндийрсөн ч тэдний хооронд тэр даруйд сүнслэг хэлхээ холбоо бий болжээ. Үүний ачаар ах нь Сүмд эргэж ирэн, бүрэн идэвхтэй болж, гэр бүлийнхэнтэйгээ харилцаагаа сэргээсэн аж.

Бурхан Өөрийн үйлчлэгчдээр дамжуулан хүүхдүүдээ зориулж бий болгосон хөтөлбөрийн дагуу итгэлтэйгээр ажилласан тойргийн зөвлөлийн сүнслэг нөлөө бүхий ажлын үр дүнд энэ бүхэн тохиосон билээ. ■

*Counseling with Our Councils—aac (1997), 15–17.*

# Тэрбээр миний уй гашууг үүрсэн



## БЭРХШЭЭЛ БУРХАН ӨӨД ХӨТӨЛЖ БОЛНО

“Гамшигтай тулгарахаараа түүнийг даван туулах боломжгүй зүйл юм шиг эсвэл өөрсдийнх нь хэлтгий заяанаас боллоо гэж боддог хүмүүс байдаг. Хэрэв тэгж бодохоо боливол тэдэнд тохиолдсон бэрхшээл ч сүнслэг байдлын хувьд тэднийг өргөх арга хэрэгсэл болж болно. Бэрхшээл нь Бурханаас холдуулдаггүй харин Түүн уруу болон сүнсний гэгээрэл өөд хөтөлж болно.”

Ерөнхийлөгч Давид О.МкКей (1873–1970), *Treasures of Life*, comp. Clare Middlemiss (1962), 107–108.

*“Гарцаагүй тэр бидний гашуудлыг хүлээн авч, мөн бидний харамслыг үүрсэн” (Мозая 14:4).*

### Жейн Блек

**Б**и 2009 оны зун, намрыг хэзээ ч мартахгүй. Аав минь оюун ухааны хомсдол өвчнөөр 10 гаруй жил зовж байгаад зургадугаар сарын 9-нд өөд болов. Зургадугаар сарын 25-нд 22 настай хүү маань зуурдаар нас бараад сар ч болоогүй байтал нэг үеэл маань хорвоог орхив. Наймдугаар сарын 13-нд 82 настай ээж минь удаан хугацаанд эдгэрэх зүрхний мэс засал хийлгэв. Аравдугаар сарын 18-нд 41 настай эрэгтэй дүү маань нас барлаа. Аравдугаар сарын 31-нд нөхөр минь зүрхний хурц шигдээс болж, найман минутын турш зүрх нь цохилохоо болисон ч, гал сөнөөгчид, түргэн тусламжийн эмч нар болон санваарын адислал нөхрийг минь бидэнд эргүүлж авчирсан юм.

Энэ бүхнийг яаж даван туулав аа гэж хүмүүс надаас байнга асуудаг байв. Би хэрэв бид Аврагчид хандвал Тэр бидний төлөө анхаарал халамж тавих болно хэмээн үргэлж хариулдаг байлаа. Тэд биднийг хүнд сорилтуудын үед орхиогүй юм. Тэнгэр надад үйлчилж, намайг дэмжиж байх шиг санагддаг байж билээ. Үнэхээр Тэр “[миний] гашуудлыг хүлээн авсан юм” (Мозая 14:4).

Бас гэр бүл, найз нөхөд, манай тойрог, гадасны гишүүд намайг тайтгааруулдаг байлаа. Тэд олон арга замаар биднийг хайр халамжаараа хүрээлсэн юм. 13 настай ач охин Кристал маань хүү Майклыг нас барсны дараа бидэнд

захидал бичиж ирүүлэв. Ач охин маань биднийг ганцаараа биш шүү гэдгийг сануулаад “Бурхан та нарт анхаарал тавьж байгаа” гэж бичсэн байв. Түүний захидал Сургаал ба Гэрээ 84:88-ын: “Би та нарын нүүрний өмнө явах болно. Би та нарын баруун гар талд мөн та нарын зүүнтээ байх болно, мөн миний Сүнс та нарын зүрх сэтгэлд, мөн миний тэнгэр элчүүд та нарыг дэмжихийн тулд та нарын эргэн тойронд байх болно” гэсэн судрын үгсийг надад сануулж билээ.

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Ричард Г.Скоттын “Их Эзэнд итгэ” гэсэн гарчигтай үгсийг уншсан нь надад хүч чадлыг өгөв. “Бүх юм сайхан байна гэж санагдсан үед олон янзын сорилт шил шилээ даран ирэх нь бий. Тэрхүү хүнд сорилтууд чиний дуулгаваргүй байдлын үр дагавар биш л бол Их Эзэн чамайг улам хатуужин өсч хөгжихөд чинь бэлтгэж байгаагийн нотолгоо мөн. Тиймээс Тэрбээр өөрт чинь үүрдийн ашиг тусыг авчрах өсөлт хөгжилт, ойлголт ба өрөвч сэтгэлийг хөхүүлэн дэмжих туршлагыг төлөвшүүлж байгаа юм. Тэрбээр чамайг байгаа төвшингөөс чинь Өөрийнхөө хүсдэг төвшинд хүртэл өсгөн хатуужуулахын тулд шаардлагатай бүхнийг хийдэг бөгөөд сэтгэл санааны зовлон, эмзэглэлийг чинь арилгадаг” (*Ensign*, 1995 оны 11-р сар, 16–17).



**Есүс Христ Гетсеманид “Хэрэв боломжтой бол Надаас энэ аягыг өнгөрүүлээч. Гэвч Миний хүслээр биш, харин Таны хүслээр болог” (Матай 26:39–44) гэж Эцэгээсээ гуйхдаа итгэлийн төгс жишээг харуулсан юм.**

“Энэ явдал яагаад надад тохиолдов? Юуны учир ингэж зовох үйлтэй хүн бэ” гэх асуулт нь биднийг мухардалд хүргэдэг юм” гэж тэр хэлжээ. Үүний оронд “Энэ явдлаас би ямар сургамж авах вэ?” “Хэнд туслах вэ?” “Хүнд сорилтын үед олон адислалаа хэрхэн санах ёстой вэ?” гэх зэрэг асуулт асуух хэрэгтэй гэж Ахлагч Скотт зөвлөжээ.

“Яагаад?” гэдэг асуулт асуух уруу таталтыг би эсэргүүцсэн. Үүний оронд би тохиолдсон хүнд сорилтуудыг даван туулах удирдамжийг Тэнгэрлэг Эцэгээс хүсдэг байлаа. Тэрбээр ирээдүйд итгэх итгэлээр

намайг адисалж, зүрх сэтгэлийг эдгээн, эргэн тойрныхоо сайхан зүйлсийг харж мэдрэхэд маань туслан, үйлчлэх боломжийг олгож, бусдад өрөвч нинжин сэтгэлээр хандахыг минь гүнзгийрүүлэн, гэр бүл, найз нөхдөө хайрлах хайрыг минь өсгөн нэмэгдүүлсэн юм.

Энэ бүхний үр дүнд тулгардаг бэрхшээл сорилт нь хүсэл бодлоо Тэнгэрлэг Эцэгт даатгах боломжийг бидэнд олгодог гэсэн гэрчлэл надад бий болсон юм. Ингэсэн тохиолдолд л бидэнд зориулан Түүний бэлтгэсэн арга замуудаар бид төгөлдөржиж чадна. ■

### Уй гашууг даван туулах нь

- Есүс Христ бол “уй гашууны хүн бөгөөд өвчин зовлонг мэдсэн” (Исаиа 53:3) учраас Лиахона гай зовлон тохиолдоход биднийг ганцааранг нь орхихгүй бөгөөд Цагаатгалын хэсэг болгон бидний уй гашууг үүрсэн юм.
- “Яагаад” гэдэг асуулт асуух уруу таталтыг эсэргүүцэхийн төлөө бид хичээн чармайх хэрэгтэй. Түүний оронд бид Их Эзэнээс удирдамж хүсч болно.
- Бид хүсэл бодлоо Тэнгэрлэг Эцэгт даатгаснаар сорилт бэрхшээлийг даван туулж чадна.

Энэ сэдвээр нэмэлт мэдээллийг Сургаалт Үгс 3:5–6, Жозеф В.Вертлин, “Sunday Will Come,” *Лиахона*, 2006 оны 11-р сар, 28–30-аас үзнэ үү.

### БИД ЯАГААД ИХ ЭЗЭНД ИТГЭЖ БОЛДОГ ВЭ?

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Ричард Г.Скотт ерөнхий чуулган дээр хэлсэн “Их Эзэнд итгэ” үгэндээ энэ асуултанд хариулахад бидэнд тусалсан юм (*Ensign*, 1995 оны 11-р сар, 16–18).

1. Бурхан юу хийж байгаагаа мэддэг. Бид Түүний зорилгуудыг санаж, тулгарсан хүнд сорилтуудыг угтвал Тэрбээр бидэнд тусална гэдэгт итгэж болно.
2. Бурханы төлөвлөгөө бол биднийг өргөмжлөх явдал тиймээс бид Түүнтэй хамт амьдрахаар буцаж очиж чадна.<sup>1</sup>
3. Сорилт бэрхшээлүүдийг даван туулах нь уг төлөвлөгөөний хэсэг юм. Бид бэрхшээлийг даван туулснаар хүч чадал, мэдлэг туршлага, итгэл бишрэл, Бурханд найдах найдлагатай болдог.<sup>2</sup>

Бэрхшээл сорилттой тэмцэж байгаа хэн нэгэнтэй Ахлагч Скоттын хэлсэн “Их Эзэнд итгэ” үгийг хуваалцаарай.

#### ЭШЛЭЛ

1. *Сайн мэдээний зарчмууд* (2009), 10–11-ийг үз.
2. *Сайн мэдээний зарчмууд*, 17–21-ийг үз.

# САНВААР

## БОЛ БУРХАНЫ НЭРЭЭР ҮЙЛДЭХ ЭРХ МЭДЭЛ

**Т**энгэр дэх бидний Эцэг газар, тэнгэрийг захирдаг. Энэхүү хүчээр орчлон төгс эмх цэгцтэйгээр оршин тогтнодог. Тэрбээр дэлхий дээрх Сүмээ удирдахын тулд Өөрийн хүч, эрх мэдлийн зарим хэсгийг зохистой Сүмийн гишүүн эрэгтэйчүүдэд итгэмжлэн олгосон юм. Энэхүү итгэмжлэн олгогдсон эрх мэдлийг санваар гэдэг. Есүс Христ Өөрийн төлөөлөгчдөд Түүний нэрээр үйлдэх эрх мэдлийг шилжүүлж өгсөн загварыг бид Шинэ Гэрээнээс мэддэг билээ (Матай 16:19-ийг үз).

Энэ бол Бурханы удирдлагын загвар. Энэ загвар өнөөдөр дэлхий дээр үйлчилж байна. Энэхүү санваарыг эзэмшигчдэд Түүний Сүмийг удирдах, авралд шаардлагатай ариун ёслолууд, тухайлбал: баптисм, гишүүний баталгаа, ариун ёслолыг адислах болон ариун сүмийн гэрлэлтийг гүйцэтгэхэд Бурханы нэрээр үйлдэх эрх мэдэл олгогдсон юм. Итгэлтэй Хожмын Уеийн Гэгээнтэн эрэгтэй, эмэгтэй, хүүхэд бүрд санваарын ёслолууд хэрэгтэй бөгөөд тэд эдгээр ёслолуудыг хүлээн авснаараа адислагддаг.

### Санваарын албан тушаалууд

Санваар нь Мелкизедек, Аароны гэж хоёр хуваагддаг. Мелкизедек санваар нь Аароны санваараас илүү эрх мэдэлтэй.

Энэ хоёр санваар өөр өөрийн албан тушаал, үүрэг хариуцлагуудтай. Аароны санваарын албан тушаалууд нь дикон, багш, прист, бишоп юм. Мелкизедек санваарын

албан тушаалууд нь ахлагч, дээд прист, патриарх, Дал, Төлөөлөгч юм. Эдгээр албан тушаалтай хүмүүс чуулга, бүлгүүд болон зохион байгуулагддаг. Албан тушаал бүр нь гүйцэтгэх үүргүүдтэй.


### Санваарын түлхүүрүүд

*Түлхүүр* гэдэг нэр томъёо нь Сүмийн нэгжүүд буюу эрх мэдлийн хүрээг тэргүүлэх эрх мэдлийг хэлдэг. Жишээ нь: Гадас, тойргуудад зөвхөн гадасны ерөнхийлөгч, бишоп, чуулгуудын ерөнхийлөгч л санваарын түлхүүрийг эзэмшдэг. Түлхүүрүүдийг олгох эрх мэдэл олгогдсон санваартан гар тавилтаар тэдгээрийг олгодог.

- Мелкизедек санваартны ерөнхийлөгчид ерөнхийлөгчийн зөвлөлийн болон сүнсний зүйлүүдийг гүйцэтгэх түлхүүрүүдийг хүлээн авдаг (С ба Г 107:10, 18–19-ийг үз).
- Аароны санваарын чуулгуудын ерөнхийлөгчид тэнгэр элчийн үйлчлэлийн болон баптисм, ариун ёслол зэргийг гүйцэтгэх түлхүүрүүдийг хүлээн авдаг (С ба Г 107:20-ийг үз).
- Сүмийн Ерөнхийлөгч нь нийт Сүмд шаардлагатай санваарын бүх түлхүүрийг эзэмшдэг (С ба Г 81:1–2-ыг үз).

### Мелкизедек санваарын албан тушаалууд ба зарим үүрэг:

1. Ахлагч нар “сүмд баптисм хүртэгчдийг судруудын дагуу галын баптисм болон Ариун Сүнсний тулд гар тавилтаар батлах нь болой” (С ба Г 20:41).



### Аароны санваарын албан тушаалууд ба зарим үүрэг:





2. Дээд пристүүд нь “сүнсний зүйлүүдэд үйлчилж” мөн ахлагч, прист, багш, диконы албан тушаалуудад “ажиллах эрхтэй” (С ба Г 107:12).




3. Патриархууд патриархын адислал өгдөг (С ба Г 107:53; 124:91–93-ыг үз).



4. Далууд сайн мэдээг номлодог бөгөөд Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын удирдлага дор үйлчилдэг Есүс Христийн тусгай гэрчүүд юм (С ба Г 107:25, 34).



5. Төлөөлөгчид нь “бүх дэлхийд Христийн нэрний тусгай гэрчүүд” (С ба Г 107:23) болж үйлчилдэг.




1. Диконууд ариун ёслолыг түгээдэг.



2. Багш нар “сүмийг ямагт харж хандан мөн тэдэнтэй хамт байж мөн бэхжүүлэх” (С ба Г 20:53) ёстой.



3. Пристүүд “заах, . . . баптисм хүртээх, мөн ариун ёслолыг гүйцэтгэх, гишүүн бүрийн гэрээр айлчилдаг” (С ба Г 20:46–47).



4. Бишопууд бол пристүүдийн чуулгын ерөнхийлөгч, дээд пристүүд бөгөөд тойрог дахь бүх гишүүнийг тэргүүлдэг (С ба Г 107:87–88-ыг үз). ■

“Үүний ёслолуудгүйгээр мөн санваарын эрх мэдэлгүйгээр бурханлиг чанарын хүч махан бодид хүмүүнд илэрхийлэгдэх нь үгүй бөлгөө” (С ба Г 84:21).

Бурханаас миний гуйсан юмыг Тэрбээр өгөөгүй тохиолдлыг би мэдэхгүй гэж миний гэргий Дебора хэлэв. Хэдийгээр эдгээр хариултаа хүлээн авах үед нь би түүнтэй хамт байсан ч түүний энэ үгс нь намайг өдий хүртэл гайхшруулдаг. Магадгүй энэ нь арьсны архаг сүрьеэгээр долоон жил шаналж, хөхний хавдартай хоёр жил тэмцэлдсэний эцэст 1990 оны 9-р сарын 19-нд нас барсан Дебораг минь таньдаг хүн бүхний гайхлыг төрүүлсэн биз ээ. Гэвч гайхсан тэр хүмүүс санваарын адислалууд болон тэдгээрийн бие-лэлтийг ойлгоогүй байж болох юм. Санваар эзэмших болон бусдыг адислахын тулд үүнийг ашиглах гэдэг нь юу гэсэн утгатайг ойлгох нь хэцүү зүйл болохыг би мэднэ.

Эцэг эх минь Сүмд идэвхтэй, Сүмийн үзэл баримтла-луудад итгэлтэй байсан ч санваар миний хүүхэд ахуйн амьдралд ямар нэгэн тодорхой сүнслэг нөлөө үзүүлс-нийг би санадаггүй. Адислал надад хэрэг болохоор тийм хүнд өвчилж байснаа болон санваарын адислалыг манай гэр бүлийн өөр хэн нэгэнд гүйцэтгэж байсныг би санадаггүй.

Ийнхүү санваарын адислалыг үнэлэн үзэх нь дутмаг байсан нь намайг өрх тусгаарлаж, эхнэр хүүхдүүдтэй болсон үед ч хэвээр байлаа. Хэрэв хэн нэгэн нь хүндээр өвчилсөн юм уу, мэс засал хийл-гэсэн бол би санваарын адислал өгдөг байсан. Мөн

байлаа. Адислал өгөх нь надад амар биш байсныг эхнэр минь мэддэг байсан бөгөөд өөрийн хүсч болох сүнслэг байдлын тусламжийг ховорхон гуйдаг байлаа.

1989 оны гуравдугаар сард эмч миний эхнэрийг хавдартай болсон байна гэж хэлэхэд бидний амьдрал өөрчлөгдсөн юм. Түүний хавдрын этгээд гаж байдал хоёр жилийн турш эмч нарын гайхлыг төрүүлсэн. Эцэст нь өвчний оношийг арай гэж тогтооход хавдар ихэд тархаж, эдгэрэх магадлал тун бага болсон байлаа. Бид тэр өвчнийг зөвхөн өөрсдийн хүчээр тэмцээд ба-рахгүй болохоо мэдээд амьдралаа сүнслий тусламжинд нээж өгсөн юм. Манай тойрог Деборагийн төлөө мацаг барьж, бид Нийгмийн Халамжийн бүлгийн анхаарал халамжийг талархан хүлээж авав. Түүний тэмцэл ингэж олны тэмцэл болов. Миний эхнэрийн хийлгэх химийн эмчилгээг өмнө нь хийлгэсэн найз минь энэ эмчилгээ-ний хамгийн хүнд үеийн тухай аминчлан ярьж, санваа-рын адислал авахыг хүссэн юм. Эмчилгээний үр дүнд нөлөөлөхийн тулд сүнслий тусламж авахыг тэр бидэнд зөвлөсөн билээ.

Химийн эмчилгээ хүнд байлаа. Эмчилгээний бүхий л үр дагавар эхнэрт минь илэрсэн. Химийн эмчилгээ-ний дараа хэд хоног бие нь дордов. Өдрийн ихэнхийг орондоо өнгөрөөж, хоол идэх нь түүнд маш их хэцүү болов. Гэвч тохиолдох бэрхшээл бүрийг хэрхэн угта-хыг бид бага багаар мэддэг болсон юм.

# Санваарын адислалууд

## БУРХАНД ИТГЭЖ СУРАХУЙ

эхнэрийнхээ сэтгэл санааг нь өргөхийн тулд санваа-рын адислал өгдөг байсан ч тийм шаардлага ховор тохиолддог байлаа.

Адислал өгөх нь миний хувьд ямагт нааштай сайн туршлага болдог байлаа. Гэвч ойлголт дутмаг, өөртөө итгэх итгэл тааруухан байсан нь санваарыг ашиглах боломжийг минь хязгаарладаг байв. Би ямар үг хэлэх вэ гэж толгойгоо гашилган, Бурханы хүссэн зүйл үнэхээр миний санаанд орж ирнэ гэдэгт бүрэн итгэж чаддаггүй байлаа.

Эхнэр минь арьсны архаг сүрьеэтэй болсноо мэд-сэн үед энэ байдал бага зэрэг өөрчлөгдсөн. Өвчнөөс болж туйлдталаа ядарч, сэтгэл санаа тавгүй байсантай тэмцэлдсэн тэр жилүүдэд зөвхөн хааяа нэг авдаг бай-сан санваарын адислал л байдлыг арай хөнгөвчилдөг

Эхнэр минь тэр хүнд үед найзынхаа зөвлөснөөр санваарын адислал өгөөч гэж надаас хүсэв. Химийн эмчилгээ хийлгэсэн эхний долоо хоногт эдэлсэн түү-ний сэтгэлийн зовлонг нь хөнгөвчлөхөөр би түүнд адислал өглөө. Мэс заслаас үүдэлтэй айдас санваарын адислалын үр дүнд бүрмөсөн арилаагүй ч нэлээд багассан юм. Намайг эхнэрийнхээ толгой дээр гараа тавьж адислал өгөхөд удаан хугацаагаар огьдог нь зогсож, хэдэн шөнө тайван унтлаа. Эдгээр адислал өвч-ний явц цаашид ямар байхыг харах боломж олгосны хамт тусламж, тайтгарлын амлалтыг бидэнд өгсөн билээ. Адислал нь бидний сэтгэлийг бүлээцүүлж, баяр баяслыг авчрав.

Тэр үед эхнэрээ адисласнаар адислал өгөх нь арай амархан болсон гэж хэлмээр байгаа ч үнэндээ тийм

*“Бид хамгийн  
их хүссэн зүй-  
лээ хүлээж  
аваагүй ч адис-  
лал бүр нь бие-  
лэгдсэн байдаг.*



биш байлаа. Эхнэрийнхээ хүссэн адислалуудыг өгдөг байсан ч, санваарын хүч чадлыг ашиглахад надад хэцүү санагддаг хэвээр байлаа. Би сэтгэл дундуур байгаагаа эхнэртээ огт цухуйлгадаггүй ч тэр миний сэтгэл дундуур байгааг мэдэрдэг байсан. Гэсэн ч хүнд сорилтууд тулгарсаар байлаа. Эхнэр минь тусламж авах боломжтойгоо мөн уг тусламжийг хүлээж авах суваг нь намайг гэдгийг мэдэж байсан юм. Тиймээс тусламж хэрэгтэй болсон үед тэр асуудаг байсан.

Адислал өгөхийнхөө өмнө эхнэрийнхээ тухайд хүсч байгаа зүйлээ, юунаас ч илүүгээр түүнийг



### ТҮҮНИЙ ХҮСЭЛД НИЙЦҮҮЛЭН

“Бид Бурханы санваарын хүчийг эргэлзээгүйгээр ашиглан мөн Тэр биднийг итгэлтэйгээр залбирах үед сонсож, хариулах болно хэмээсэн Түүний амлалтыг эрхэмлэн дээдэлвээс итгэл болон санваарын хүч нь Түүний хүслийн эсрэг үр дүнд хүргэнэ гэж байхгүй. Учир нь энэ санваар Түүнийх. Энэ зарчмыг өвчтөн дээр гар тавихад Сүмийн ахлагч нарт удирдамж өгсөн илчлэлтэд заасан байдаг. ‘Эдгэрэх итгэлтэй мөн үхэлд оноогдоогүй тэр нь эдгэрэх болно’ (С ба Г 42:48 онцлон тэмдэглэлт нэмэгдсэн)” хэмээн Их Эзэн амласан билээ. . . .

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Даллин Х.Өүкс,  
“Healing the Sick,” *Лиахона*, 2010 оны 5-р сар, 50.

эдгээхийн төлөө адислал өгөхийг хүсч байгаагаа мэддэг байлаа. Эхнэр минь ч мөн л үүнийг хүсдэг байсан. Гэвч хүссэн тэрхүү адислал ирээгүй юм. Хүнд өвчнийг зайлуулаагүй ч тайтгарлыг авчирсан адислал ирсэн бөгөөд энэ нь өвдөлтийг арай амар тэсч өнгөрүүлэхэд тусалсан юм.

Санваар болон санваарын адислал хэрхэн үйлчилдгийг би алгуураар илүү сайн ойлгодог болсон. Адислал өгөх нь хүссэн зүйлээ хүлээж авах арга хэрэгсэл биш харин хэрэгтэй тусламж авах арга зам юм. Юу хэрэгтэй гэж бодсоноо хийх биш харин Их Эзэн болон Түүний хүсэлд би итгэж сурсан. Миний толгойд орж ирсэн үгс бол чухамдаа Бурхан надаар хэлүүлэх гэсэн үгс мөн гэдэгт итгэх итгэл бий болсон билээ. Адислал өгөх нь надад хэзээ ч амар байгаагүй ч адислал өгч байгаа үед төрсөн мэдрэмждээ итгэж сурсан юм.

Дебораг эмчилгээгээ дуусгасны дараа эм нь ямар үр дүн өгөхийг хүлээх хүнд хэцүү үе эхлэв. Энэ үед эмч

нарын дүгнэлт, шинжилгээ, эмчилгээ зэргийг хийлгэхгүй нь бидэнд арай амар байлаа. Гэвч хортой эмээр устгагдсан хавдар дахин идэвхжих болзошгүй гэсэн айдас бидний санааны мухарт байсаар байлаа.

Эмчилгээ амжилтгүй болох вий гэсэн айдсыг минь баталсан шинж тэмдгүүд бага багаар илэрсээр байв. Эмч нар өөдрөг бодолтой байсан хэдий ч энэ нь одоо цаг хугацааны асуудал болжээ гэдгийг бид мэдэж байлаа.

Деборагийн амьдралын сүүлчийн зургаан сар ер бусын тайван байлаа. Сүүлчийн эмчилгээ нь үр дүнгүй болсны дараа бид эмчилгээг зогсоогоод үлдсэн хугацааг гэртээ өнгөрүүлэхээр шийдэв. Энэ хэдэн сар гайхалтай сайхан байсанд зарим хүмүүс итгэхгүй байж болох юм гэвч энэ нь миний амьдралын хамгийн сайхан үе байлаа.

Энэ үед санаа нь зовсон зарим найз нөхөд, гэр бүл эхнэрийн минь амийг аврахын төлөө Их эзэнд улам илүү итгэж найдах хэрэгтэй хэмээн бидэнд зөвлөдөг байв. Би санваартай учраас эхнэрээ эдгээхэд түүнийг ашиглах хэрэгтэй гэж тэд надад сануулдаг байлаа. Би тэдний санааг ойлгодог байсан ч найз нар маань бидэнд яг юу тохиолдож байгааг сайн ойлгоогүй байх. Деборагийн амийг аврах амлалтаас өөр юуг ч би хүсдэггүй байлаа. Гэтэл намайг адислал өгч байх үеэр ийм үгс санаанд огт орж ирдэггүй байв. Эхнэр минь эрүүл мэндийн адислал авахаас илүү зүйлийг хүсч байсан ч, өөрөө үүнийг гүйх ёсгүй гэж боддог байсан болов уу. Бид хоёул гайхамшигт итгэхийн зэрэгцээгээр мөнхийн төлөвлөгөөнд нийцэхийн хувьд бидний байдал хязгаарлагдмал болохыг ойлгож байлаа.

Гэтэл тохиолдсон зүйл агуу гайхамшиг байлаа. Адислалуудад түүний амь нас аврагдах болно гэсэн амлалт огт өгөгдөөгүй ч тохиолдсон зүйл нь Бурханы хүсэл юм гэдэгт итгэх маргашгүй баттай итгэл түүнд төрсөн. Амар амгалан түүнд амлагдаагүй ч хүнд үеийг даван туулахад нь тусалсан юм. Амьд үлдэж, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх боломж түүнд олдоогүй ч мөнхийн холбоо түүнд баттай болсон билээ. Тэр минь өвдөлт нь нэлээд намдсан, амар тайван байдалтайгаар халуун ам бүлээрээ хүрээлүүлэн талийгаач болсон билээ.

Бурхан байдаг бөгөөд бидний төлөө гүнээ санаа тавьдгийг би мэднэ. Бидэнд хүч чадал, ойлголт хэрэгтэй болсон үед Тэрбээр тайтгарал, тусламжаар хангадаг билээ. Амьдрал хэцүү байсан ч Их Эзэн хүнд сорилтуудаар дамжуулан бидэнд туслахаар амласан бөгөөд тусламж ирдэг нэг зам нь санваарын адислал юм. Эхнэр минь үүнийг мэддэг байсан учир “Бурханаас миний гуйсан юмыг Тэрбээр өгөөгүй тохиолдлыг би мэдэхгүй” гэж хэлсэн хэрэг. ■

# Зөв шударга үлгэр жишээний хүч

Жерри Стрингам

**Б**ид 1992 оны 4-р сард гэр бүлийнхээ хамт Ютагийн Провод амьдарч байлаа. Би Бригам Янгийн Их Сургуулийг инженерийн мэргэжлээр суралцаж төгсөхөөр Канадаас шилжиж ирсэн юм. 17 настай хүү Жейс минь Криста гэдэг бүсгүйтэй найз болжээ.

Ерөнхий чуулган болсон бямба гарагийн орой Жейс зочны өрөөнд орж ирээд Кристаг сүүтэй шэйк уулгахаар авч явъя, машинаа өгөөч гэв. Би түүнд түлхүүрээ шидэж өгөхөд Жейс гал тогооны өрөөнд орж, найз охин уруугаа утасдлаа. Түүнийг утсаар ярих нь:

“Сайн уу, Криста, би Жейс байна.

Сүүтэй шэйк уухаар гадагшаа гарах уу? гэж чамаас асуух гэсэн юм” **ГЭХ СОНСОГДЛОО.**

Тэгээд чимээгүй болов. “Санваартны хурлын дараа юу? За тэгье ээ, Би чам уруу тэр үеэр утасдъя. **Баяртай.”**

Жейс утсаа тавиад зочны өрөөнд эргэж ирэв.

“Чи түүнтэй хамт гадагшаа гарах нь уу?” гэж би асуулаа.

“Тэр явна гэнэ ээ, гэхдээ намайг санваартны хурлаа тараад утасдаарай гэлээ” гэж тэр хариулав. Нүүрэнд нь тунирхсан харц илрээд тэр өрөө уруугаа сэмхэн оров.

Намайг хүнд алхаар цохиод авах шиг санагдав. Би өмнөд Альбертад гадасны төвөөс 130 км зайтай газарт өссөн. Хэн ч гэсэн бүр манай салбарт удирдлагын албан тушаалтай эцэг эх минь ч намайг чуулганы хуралдаануудад түүний дотор санваартны хуралдаанд очих ёстой гэж боддоггүй байлаа. Харин одоо ингэж бодох хүн гарч иржээ.

Хүү маань өрөөндөө гунигтайхан харцтай буцаж орсонд би хэрхэн хариулах вэ? Миний шийдвэр ирээдүйн олон жилд баримтлах жишиг болох учиртайг би мэдэж байлаа.



Тэгээд сандлаасаа босч, Жейсийг болон диконноор шинэхэн томилогдсон хоёр дахь хүүгээ “Хувцсаа соль” хэмээн дуудав. Гадасны төвд болох санваартны хуралдаанд очиход бидэнд 10 минутын хугацаа байлаа.” Би тэр даруйд бэлэн болж, өрөөнөөсөө гарч ирэхэд хоёр хүү маань бас бэлэн болсон байлаа. Ингээд бид гурав машин уруугаа очив.

Ямар үгс хэлснийг би санахгүй байна, харин бид Сүнсийг мэдэрснээ л санадаг. Хөвгүүдтэйгээ санваартны хуралдаанд оролцсон нь сайхан санагдаж байлаа. Гэртээ буцаж ирэхэд Жейс сэтгэл өндөр байсан нь надад нөлөөлж би ч бас сэтгэгдэл өндөр байлаа. Тэр Криста уруу утасдаж, тэр хоёр сүүтэй шэйк уухаар явлаа.

Тэр өдрөөс хойш хорин жилийн турш манай гэр бүлийн санваартнууд ерөнхий чуулганы санваартны хуралдааныг ганц ч удаа таслаагүй. Зөв шударга тэр залуу эмэгтэй итгэл бишрэлийнхээ төлөө бат зогссоны улмаас манай гэр бүл өөрчлөгдөх боломжтой болсон бөгөөд бид ерөнхий чуулганы санваартны хуралдаан дээр хожмын үеийн бошиглогчдын үгсийг сонсож, Сүнсийг мэдэрсээр байгаа билээ. ■

# Гэрлэлтийн талаарх

## Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн үзэл баримтлал



Хью Б. Браун 1883 оны 10-р сарын 24-нд Ютагийн Гранжерт төржээ. Тэр 1958 онд Төлөөлөгчөөр томилогдож, Ерөнхийлөгч Давид О. МкКейн зөвлөхөөр найман жил үйлчилжээ. Дараах өгүүлэл бол түүний *You and Your Marriage (Та болон таны гэрлэлт)* номоос авсан хэсэг юм.

### Ерөнхийлөгч Хью Б. Браун (1883–1975)

Тэргүүн Зөвлөлийн нэгдүгээр зөвлөх

Гэрлэлт ариун зүйл бөгөөд ариун зан үйл байх ёстой. *Ариун зан үйл, ариун ёслол* гэдэг нэр томъёо Христэд итгэгчдийн хувьд олон өөр утгатай ч гол утга нь зохих эрх мэдэл бүхий хэн нэгэн хэрэгжүүлдэг шашны хүндэтгэлтэй зан үйл, ёслол юм. Энэ бол амлалт бас ариун гэрээ, гэрээ байгуулагч талуудын хоорондын эсвэл Бурхан болон тэдний хоорондын сүнслэг тэмдэг буюу харилцаа юм. Гэрлэлтийг ийнхүү Их Эзэн Өөрөө үндэслэж, ариусгасан бөгөөд энэ нь дараах эшлэлүүдэд харагддаг:

“ЭЗЭН Бурхан, хүн ганцаараа байх нь сайн биш учир Би түүнд тохирох туслагчийг бүтээе. . . .

Ийм учраас эр хүн эцэг эхээ орхиод, эхнэртэйгээ нийлэн, тэр хоёр нэгэн бие болох

ажгуу” (Эхлэл 2:18, 24).

Есүс Галилаас гарч, Иорданы цаадах Иудейн эрэгт үй олон хүн Түүнийг дагалдаж ирэхэд фарисайчууд гэр бүл саалтын тухай Түүнээс асуужээ.

“Тэр хариуд нь: Бүтээгч анхнаасаа тэднийг эр, эмээр нь бүтээснийг та нар уншаагүй гэж үү? гээд,

Тиймээс эр хүн эцэг эхээ орхин эхнэртэйгээ нийлж, хоёулаа нэг бие махбод болдог.

Тиймд тэд цаашид хоёр бус, харин нэг бие махбод юм. Иймээс Бурханы хамтад нь нийлүүлснийг хэн ч бүү салга гэж айлдав” (Матай 19:4–6).

### Гэрлэлт Бурханы зорилгыг гүйцэлдүүлдэг

Бурхан эрэгтэй, эмэгтэй хоёр хүнийг нэг байх ёстой

гэж үздэг нь тодорхой юм. Тэрбээр энэхүү анхны хуримыг Өөрөө санаачилж, гэрлэлтийг ариусгасан билээ. Гэрлэлт бол хэвийн, эрүүл саруул, хүсүүштэй байдал бөгөөд дэлхий дээр Бурханы зорилгыг гүйцэлдүүлэхийн тулд бий болсон.

Энэ бол гэр орон бий болгох үндсэн элемент юм. Гэрлэлт бол ёс заншил болон иргэний хуулиар чанд зохицуулагддаг хүмүүний байгууллагаас илүү эрхэм зүйл мөн. Ёс суртахууны хуулиар зохицуулагддаг гэрээнээс илүү эрхэм зүйл мөн. Энэ бол дэлхийг амьдралтай болгож, мөнх бус байдалд Түүний сүнсэн хүүхдүүдэд үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг тохиолгон авчрах Түүний зорилгыг хэрэгжүүлэхэд эрэгтэй, эмэгтэйчүүд Бурхантай хамтран ажиллах хүндтэй үүрэг хүлээдэг шашны ариун зан үйл мөн. Энэ зан үйл эгнэгт ариун нандин байх ёстой.

Бүхнээс эрхэм, хүслийн дээд оргил болсон амьдралд гэрлэлтийн гэрээнээс гадуур хүрч болно гэж үздэг хүмүүс байдаг. Өөрөөр хэлбэл тэд “адгуусныхтай адил бие махбодын харилцаагаар бохирдсоноор” хамгийн эрхэм дээд алдар сууг эрэлхийлдэг хүмүүст хориг тавихыг санаархдаг. Ийм сургаалыг



судруудад зөвтгөдөггүй. Сургаалт Үгсийн номонд “Эхнэрийг олдог хүн сайныг олж, ЭЗЭНээс тааллыг хүлээн авдаг” (Сургаалт Үгс 18:22) гэсэн байдаг. . . .

Сургаал ба Гэрээнд “Мөн дахин үнэнээр би та нарт хэлнэ, гэрлэхийг хориглодог хэн боловч Бурханаас томилогдоогүй болой, учир нь гэрлэлт нь Бурханаас хүмүүнд томилогдсон билээ” (С ба Г 49:15) хэмээсэн байдаг.

### **Ариун сүмийн гэрлэлт жинхэнэ аз жаргалыг авчирдаг**

Энэ дэлхийд болон ирэх дэлхийд амьдралын охь манлай, аз жаргалын дээдийг эдлэхийн тулд эрэгтэй, эмэгтэйчүүд ариун сүмд энэ амьдралд болон үүрд мөнхөд гэрлэх ёстой гэдэгт Хожмын үеийн Гэгээнтнүүд итгэдэг. Ариун сүмийн гэрлэлтийн лацдан холбох ёслолуудгүйгээр хүн бурханлиг байдлыг олж

бүрэн баяр баясгаланг эдэлж чадахгүй. . . .

Хожмын Үеийн Гэгээнтэн бүр бүрэн дүүрэн хүлээн зөвшөөрдөг цорын ганцхан гэрлэлт байдаг нь Сүмийн ариун сүмүүдэд гүйцэтгэгддэг ариун сүмийн буюу селестиел гэрлэлт юм. Ариун сүмүүдийг Их Эзэний ариун байдалд зориулан барьж, онцгойлон адисалдаг бөгөөд сүнсний болон үүрд мөнхийн ёслолуудыг гүйцэтгэдэг газар юм. Бид бусад сүмүүдийн болон хуулийн эрхзүйн бусад албан тушаалтнуудын гүйцэтгэсэн иргэний гэрлэлтүүдийг хүлээн зөвшөөрдөг хэдий ч энэ амьдралд болон үүрд мөнхөд хүчинтэй гэрлэлтийг зөвхөн Бурханы ариун сүмд гүйцэтгэх бөгөөд Христ Петрт “Чи газар дээр юуг холбоно, тэр нь тэнгэрт холбогдоно” (Матай 16:19) гэж хэлсэн ба эрх мэдэл бүхий хүнээр уг гэрлэлт гүйцэтгэгдэх ёстой гэдэгт бид итгэдэг.

Уг эрх мэдлийг судруудад “тэнгэрийн хаанчлалын түлхүүрүүд” (Матай 16:19) гэдэг бөгөөд селестиел гэрлэлтээр

эдгээр түлхүүрүүд хаант улсын үүд хаалгыг нээдэг.

### **Хэрэгцээг бүрэн хангах нь**

Хүн төрөлхтөнд ёс суртахууны, нийгмийн, биологийн, сүнсний хэрэгцээ байдаг бөгөөд эдгээр бүх хэрэгцээ Бурханы томилсон мөнхийн гэрлэлтэд бүрэн багтдаг.

Хүн энэ амьдралд болон ирэх дэлхийд элбэг дэлбэгээр амьдрахын

тулд бусдыг хайрлаж, бусдаар хайрлуулж, үйлчилж, золиослол хийн, Бурханаас соёрхсон бүтээгч хүчийг ашиглах

**Энэ дэлхийд болон ирэх дэлхийд амьдралын охь манлай, аз жаргалын дээдийг эдлэхийн тулд эрэгтэй, эмэгтэйчүүд ариун сүмд энэ амьдралд болон үүрд мөнхөд гэрлэх ёстой гэдэгт Хожмын үеийн Гэгээнтнүүд итгэдэг.**



чинь байх юм бол ашиг тус нь юунд байх билээ. Гэр бүл болон гэрлэлтийн харилцаа мөнх оршдог учир гэрлэлтийн гэрээ нь “энэ амьдралд болон бүх үүрд мөнхөд” *хүчин төгөлдөр* байх болно.

Бүх хүн үр хүүхдийнхээ өмнө хүлээсэн үүрэг хариуцлага болон тэдний талаар хийсэн гэрээнүүдийнхээ үүрэг хариуцлагаа ухамсарлан ойлгох ёстой. “Бид тэдэнгүйгээр төгс болгогдож чадах нь үгүй” (С ба Г 128:18) хэмээн Их Эзэн хэлэхдээ хүмүүсийн хэлхээ холбоо нь ирээдүй, өнгөрсөн үеийг холбодог тухай өгүүлсэн юм. Чухам иймээс энэ амьдралд бидэнд итгэл хүлээлгэн даалгасан хүмүүсийн төлөө бидний өвөг дээдэс биш харин бид шууд үүрэг хариуцлага хүлээх ёстой. Бид өвөг

дээдсийнхээ төлөө итгэмжлэл хүлээсэн үү, үгүй юу гэдгээс үл хамааран тэдний нүглийн төлөө хариуцлага хүлээх ёсгүй ч хойч үеийнхээ төлөө юу ч хийгээгүй бол тэдний өмнө хүлээсэн үүргээ биелүүлээгүйн нүгэл нь бидний толгой дээр ирэх болно гэдгийг Тэрбээр

талаар үүрэг хүлээх ёстой. “Би тэднийг амьтай, бялхсан амьтай байлгахын тулд ирсэн юм” (Иохан 10:10).

Гэвч гэрлэлтийн үнэ цэнэ нь хүн үүнээс ашиг тусыг олно гэсэн үг биш юм. Тэдний нэгдэн нийлэхийн зорилгыг Их Эзэн дараах зарлигтаа айлджээ: “Өсөн нэмэгдэж, өнөр өтгөн болж, газар дэлхийг дүүргэн, газрыг эзэмш” (Эхлэл 1:28). Гэрлэлт ном ёсоороо байгаа үед хүн өөрт нь заяамал байдаг бүтээгч болоод нөхөн үржихүйн хүчийг танин мэдэж, ашиглах боломжтой болдог. Энэ нь зөвхөн гэрлэлтийн харилцаанд, хүүхэд төрүүлж, өсгөн хүмүүжүүлэхэд бүрэн гүйцэлдэж, баяр баяслыг авчирдаг. Бидний хүүхдүүд бол мөн Бурханы хүүхэд гэдгийг эцэг эхчүүд санах ёстой. Бурхан бол тэдний сүнсэн биеийн Эцэг бөгөөд дэлхийн өмнөх оршихуйд Тэрбээр мөнхийн элемент, мөнхийн сүнс хоёр салшгүйгээр нэгдэж, бүрэн баяр баяслыг олох арга хэрэгслийг ухаалгаар бий болгосон билээ. Тиймээс Бурхан бол энэхүү харилцааны гурав дахь түнш бөгөөд энэхүү бурханлиг ариун гэрлэлтийн хүрээнд

дэлхийд хүүхэд төрүүлэх нь үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг хүмүүнд тохиолгон авчрах Түүний төлөвлөгөөний хэсэг мөн гэдэгт Хожмын Үеийн Гэгээнтнүүд итгэдэг.

### Гэрлэлтийн мөнхийн мөн чанар

Бурханыг болон хөршөө хайрлах хайр нь хоёр агуу зарлиг мөн гэж Их Эзэн Есүс Христ зааснаараа хайрыг алдаршуулсан юм. Үүгээрээ Бурхан бол хайр мөн гэдгийг бидэнд хэлсэн билээ. Тиймээс Бурхан мөнх учраас хайр мөнх байх ёстой, хайрын үр жимс болоод адислалууд нь ирээдүйд үүрд мөнх үргэлж байх болно. Гэвч мөнхийн хайрын давуу тал болон онцгой боломж эхнэр, нөхөр, эцэг эх, хүүхдүүдэд байгаа үед энэ харилцааг аливаа харилцаанаас илүү эрхэм сайхан болгож ариусгадаг ёслол нь зөвхөн “үхэх хүртэл өөрт

**Б**урхан бол энэ гурав дахь түнш бөгөөд энэхүү бурханлиг ариун гэрлэлтийн хүрээнд гэлхийг хүүхэд төрүүлэх нь үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг хүмүүнд тохиолгон авчрах Түүний төлөвлөгөөний хэсэг мөн гэдэгт Хожмын Үеийн Гэгээнтнүүд итгэдэг.





бидэнд анхааруулсан юм.

Селестиел хаант улсын хамгийн дээд зэрэглэлд очих хүмүүст ирэх адислалуудын дотор мөнхийн өсөлт хөгжилтийн адислал байдаг бөгөөд бүр үхлийн дараа ч үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг хүмүүнд тохиолгон авчрахад хүн Бурхантай хамтран ажилласаар байдаг.

### Мөнхийн хань болж өсөн хөгжих нь

Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн мөнхийн өсөлт хөгжилтийн тухай үзэл баримтлалд мэдлэг, хүч, оюун билэг, ухамсрын болон бурханлиг байдалд шаардлагатай зан төлөвийн бүхий л шинж чанар, чадварын мөнхийн өсөлт хөгжилт багтдаг. Гэвч хүн дутуу дулимаг байгаа буюу гэрлээгүй тохиолдолд Бурханы төлөвлөгөөгөөр энэхүү байнгын төгөлдөржилтөд хүрч чадахгүй. Өөрөөр хэлбэл хүн нөгөө хагастайгаа нэгдэн нийлсэн үед л өсөлт хөгжилт ирэх ёстой.

Гэрлэлтийн талаарх энэхүү үзэл баримтлал нь бурханлиг хэтийн төлөвийнхөө хамт гэрлэлтийг нэн чухал, өндөр хүндэтгэлтэй, сайн сайхан үйлс болгодог билээ. Хэрсүү ухаантай хүн гэрлэлтийн энэ үзэл баримтлалаар мөнхийн ханиа буурь суурьтайгаар сонгож чадна. Ийнхүү мөнхийн гэрээнд орохын өмнө эрэгтэй, эмэгтэй хүмүүс аль аль нь дотроо бодолтой, дороо суурьтай, даруухан байж, бурханлиг удирдамжийн төлөө залбирах ёстой.

Гэр бүлийн хос гэрлэхээсээ өмнө итгэл нэгтэй, адил зорилго, хүсэл эрмэлзэлтэй байх шаардлагатай байх ёстой бөгөөд энэ нь гэрлэлтийн харилцааны гагнан холбох хүчийг үлэмж өсөн нэмэгдүүлдэг. Зөвхөн зохистой хүмүүс л хүлээн авч ашиг тусыг нь хүртдэг ариун ёслолуудад бэлтгэж, тэдгээрийг хүлээн авахуйц зохистой байх ёстой. Тэд мөнхийн гэрлэлтээр заавар авч, гэрээнүүд хийн, тахилын ширээний дэргэд мөнхийн хайраар бие биеэ хайрлаж, хоёр биедээ чин үнэнч байхаа Бурхан ба тэнгэр

элчүүдийн дэргэд амладаг. Ийм үзэл баримтлал, дадал зуршлыг үүрэг хариуцлагатайгаар гэр орондоо байнгын хэвшил болгосон тохиолдолд гэрлэлт болон хүмүүний бодгалийн авралыг дуурсгалтай болгодог юм.



### БҮХ АДИСЛАЛ БОЛОМЖТОЙ

“Тэгвэл гэрлээгүй

Сүмийн олон идэр залууст юу тохиох вэ? тэдний өөрсдийнх нь буруугаас болоогүй ч тэд ганцаараа амьдралын бэрхшээлтэй тулгардаг. Их Эзний замаар болон цаг хугацаанд Түүний итгэлтэй Гэгээнтнүүдэд бүх адислал боломжтой гэдгийг санацгаая Хувь хүн бүрийн зүрх сэтгэлийн гүн дэх хүсэл болон хийсэн үйлээр нь Их Эзэн шүүж мөн шагнах болно.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын  
Ахлагч Рассел М.Нелсон *Liahona*  
2008 оны 11-р сар.

### Итгэлийн үйлдэл

Ийм гэрлэлт нь бурханлигаар томилогдсон хань ижилдээ хандах итгэлийн нэн чухал үйлдэл мөн. Бэрхшээл, хүнд сорилтууд тулгарч, урам хугарч цөхрөх, уй гашуу тохиолдох үед эдгээрийг даван туулах итгэлтэй бөгөөд эцсийг хүртэл тэвчих зоригтой байх ёстой.

Энэхүү үүрд мөнх ханилан амьдрах нөхцөл, үүрэг хариуцлагыг хүн өөр дээрээ авсан л бол аль нэг байдлаар бүтэлгүйтэх нь бүрмөсөн бүтэлгүйтэл болдгийг ойлгох ёстой. Хүн ажил төрөлдөө ямар ч амжилт гаргасан мөнхийн гэрээгээр ноогдсон үүргээ биелүүлээгүй бол гэрээ хийсэн хүнийхээ өмнө хүлээсэн үүргээ биелүүлээгүйн төлөө хүлээх хариуцлагын хамт шийтгэл нь селестиел алдар сууг алдахад хүргэнэ.

“Гэрлэлт нь Бурханаас хүмүүнд томилогдсон билээ.

Иймийн тул, хүн нэг эхнэртэй байх ёстой нь хууль ёсны юм, мөн хоёул нэг махбод байх болно, мөн энэ бүгд нь өөрийн бүтээлтийн зорилгыг

дэлхий хэрэгжүүлж болохын тулд юм;

Мөн ийнхүү дэлхий бий болгогдохоос өмнөх түүний бүтээлтийн дагуу энэ нь хүмүүний тоо хэмжээгээр дүүргэгдэх болно” (С ба Г 49:15–17). ■

*Дэд гарчгуудыг нэмж, цэг тэмдэг, том үсгээр бичихийг зөв бичгийн дүрмийн дагуу болгосон.*



БИ

# МУУ ЗУРШЛААСАА САЛАХЫГ

МАШ ИХЭЭР ХҮСЭЖ БАЙЛАА

## Нэрийг нууцлав

*Порнографт донтсоноо даван туулсан нь.*

**Н**амайг өсвөр насны залуу хөвгүүн байхад минь бусад хүн зохисгүй материалуудыг танилцуулсан ба энэ үеэс порнографтай тэмцэх миний тэмцэл эхэлсэн. Тэр үед сайн мэдээ миний амьдралын чухал хэсэг байгаагүй. Бага насандаа би Хүүхдийн Хэсэгт явдаг байсан ч намайг 13-14 нас хүрэх үед манай гэрийнхэн сүмд очихоо больсон юм. Тиймээс би аливаа юманд сайн мэдээний сургаалын дагуу шийдвэр гаргадаггүй байлаа.

Хөршүүд болон найз гэгдэгч тэр хүмүүс надад юу үзүүлснийг би аав, ээж хоёртоо ч ярьдаггүй байв. Харсан болон биеэр хийж үзсэн тэр зүйлийг ярилцахад дэндүү ичгэвэртэй байлаа. Тэгээд энэ талаар юу хийхээ мэдэхгүй байв. Хэдэн арван жил өнгөрсөн ч порнографт донтсон нь миний нууц хэвээр үлдсэн юм.

### Сайн мэдээний нөлөө

Ахлах сургууль төгсөхийн өмнөхөн миний амьдралыг өөрчилсөн нэгэн гайхамшигт явдал тохиолдов. Миний үйлдэл, сайн мэдээний жишгүүдийн хооронд маш их ялгаа байсан ч нэгэн ням гарагийн өглөө сүмдээ явж, аравны нэгээ төлбө гэсэн хүчтэй хүсэлдээ хөтлөгдөн Сүм уруу явлаа. Цуглааны байранд хүрч ирээнд таньдаг хүмүүсээ сураглаав. Би дикон байхдаа сүүлчийн удаа сүмд очиход минь байсан зарим нэг хүнийг болон тэр үеийн Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхийлөгчийг сураглалаа. Тэр тойргийн бишпоор үйлчилж байлаа.

Тэр сайн бишоп Сүмд эргэж ирэхэд надад тусалсан юм. Намайг нүглээ хүлээхэд тэр өсөлт хөгжилтийн төлөвлөгөөг минь надтай хамт гаргалаа. Би хэдэн сарын турш нүглээ наманчлав. Санваараа ахиулж, дуудлагатай болов. Дажгүй сайн байж, номлолд үйлчлэн, хэдэн жил донтолоо хянаж чадлаа.

### Интернетэд олзлуулсан нь

Номлолоосоо эргэж ирсэн үед порнографтай тэмцэх шаардлага байсангүй. Би түүнийг сонирхохоо больсон байв. Энэ байдал интернет өргөн дэлгэрсэн 1990-ээд оны сүүлчийг хүртэл үргэжилсэн юм. Нэг удаа санаандгүйгээр онлайн дахь порнографик зургуудыг олж хараад үүний дараа порнографын сайтуудад дахин дахин орж үзэх болов. Тэрхүү вэбсайт намайг ийнхүү урхихдах нь тэр.

Порнографтаас ангижрахад туслах хэн нэгэн олдоосой гэж бодовч энэ хэн байх, хэрхэн түүнийг олохоо мэдэхгүй байв. Энэ тухай аав, ээж хоёртоо яаж ярих билээ? Их ахиц дэвшил гаргасан хэрнээ ийм ёс суртахуунгүй авирт автагдсанаа больж чадахгүй байгаагаа бишоптоо хэрхэн тайлбарлах билээ? Би муу зуршлаасаа салахыг маш ихээр хүсч байсан ч сул дорой байдлаа хэн нэгэнд дэлгэн ярихаас ичиж, донтолоо нуусаар байлаа.

Тэр ч байтугай 2000 онд гэрлэсэн эхнэртээ ч энэ тухай ярьсангүй. Бид хоёр болздог байхдаа энэ зовлонгийнхоо талаар түүнд ярихыг хүсдэг байсан ч тэр намайг голж тоохгүй болчих болов уу, түүгээр ч зогсохгүй надтай гэрлэхээс татгалзвал яана гэж айдаг байлаа. Тиймээс би худал хэлсэн. Тэгээд гэрлэснээсээ хойш ч мөн л нөгөөх зуршлаасаа салж чадахгүй байв. Донтолод олзлогдохоос сэрэмжлэхийн оронд үүнийгээ нуудгаа би мэдэж байлаа. Порнографын зургуудыг компьютертоо нуудаг байлаа. Эхнэр маань интернетийн аль нэг сайтын тухай надаас асуухад түүний асуусан зүйлийг мэдэхгүй гэж хариулдаг байв. Донтолод автагдсан хүмүүс худал хэлэхдээ гарамгай болдог байх. Донтолт бидний гэр бүлийн амьдралд өргөс болж, эхнэр маань үүнээс болж маш их шаналж байгааг би мэддэг байсан ч энэ талаар

асуудалтай байгаагаа хүлээн зөвшөөрдөггүй байв. Миний санааг хамгийн их зовоодог зүйл бол миний зан авир биш харин хүмүүс намайг юу гэж бодох бол гэдэг нь л байлаа.

Миний хоёр нүүрт амьдрал, үүнээс үүдэлтэйгээр Сүнсийг алдсан нь намайг илүү их гэм нүгэл уруу татаж, эхнэрээ хуурахад хүртэл хүргэсэн юм. Намайг нэг л биш байгааг эхнэр минь хүчтэй мэдэрч, тэр тухайгаа надад ярилаа. Би маш их гэмшиж, буруугаа хүлээлээ.

Энэ бол миний доройтлын доод цэг байсан бөгөөд энэ цэгт хүрч байж л сая өөрчлөгдөх хэрэгтэй байгаагаа ухаарсан билээ. Миний хайрладаг байсан эмэгтэй өөдөөс минь харан сууж байлаа. Тэр надад хайртай байсан. Гэтэл би түүнээс урван тэрсэлсэн байдаг. Би гэр бүлээ, эрхэм дотно харилцаагаа аврахын төлөө юу л хийх шаардлагатай байна, тэр бүгдийг хийхээр хатуу шийдээд байлаа.

### Эдгэрэлт

Наманчлалын үйл явц болон Сүмийн сахилгаар дамжуулан бишоптойгоо тогтмол уулздаг болов. ХҮГ Гэр Бүлийн Төслөөс зохион байгуулдаг донтолоос ангижрах хөтөлбөрийн цуглаануудад оролцохыг бишоп надад зөвлөв. Би тэр хөтөлбөрийн тухай урьд нь огт сонсоогүй байлаа. Сүмийн сургаал, зарчмуудад үндсэлсэн Alcoholics Anonymous (Архинаас гаргах) 12 алхамт төлбөргүй цуглаан явагддагийг би мэдэж авлаа. Энэ цуглаанд оролцогсдын хувийн нууцыг хадгалдаг байв.

Эхний хэдэн цуглаанд сууж байхдаа “Би энд явах шаардлагагүй хүн. Би порнографт тийм их автаагүй. Энэ донтолыг би хэдийд ч хаяж чадна” гэж өөрийгөө өмгөөлөн бодож байснаа хүлээн зөвшөөрөх хэрэгтэй байх. Үнэн хэрэгтэй тэр

## ЗӨВХӨН БУРХАНЫ ХҮЧЭЭР ЧӨЛӨӨЛӨГДӨНӨ



“Та нүгэлтэй эсвэл сул талтайгаа тэмцэж байгаа юу? Энэ нь өглөө эрт судар судлах болон залбирч чадахгүй байхтай адил энгийн зүйл байж болно. Энэ нь мөн интернетийн порнографт донтох буюу ёс суртахууны байдалдаа хяналт тавих нь дутагдсанаас ёроолгүй ангал уруу унаж, найдваргүй болсноо мэдрэх лүгээ адил хүчтэй байж ч болно. Хийдэг юмаа үзэн яддаг хэрнээ түүнийгээ болих сэтгэлийн тэнхээ дутсан үе танд байсан уу? Тэгвэл тийм сэтгэлийн тэнхээтэй болж, өөрийгөө даруусга. Их Эзэний боломж олгогч хүч зүрх сэтгэл болоод амьдралыг чинь өөрчилж, бодгалийг чинь цэвэршүүлэх болно. Харин та анхны алхмыг л хий. Энэ бол өөрийгөө даруусгаж, донтолтоос чинь ганцхан Бурхан л чөлөөлж чадна гэдгийг ойлго.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч М.Рассел Баллард, “Be Strong in the Lord,” *Ensign*, 2004 оны 7-р сар, 12.

бодол маань буруу байлаа.

Бишопынхоо дэмжлэгээр би тэр цуглаануудад үргэлжлүүлэн оролцсоор байлаа. Миний бардам зан арилж, хөтөлбөрийн алхмуудын дагуу ажиллаж эхлэхэд шударга зан, найдвар, Бурханд итгэх итгэл, гэмшил, зүрх сэтгэлийн өөрчлөлт даруу байдал, уучлалыг эрж хайх, порнографыг сонирхдоггүй хуучин байдалдаа эргэж орох, өөрийн байдалдаа өдөр бүр хариуцлага хүлээдэг болж, илчлэлт хүлээн авах болон үйлчлэх замд орж эхэлсэн билээ. Ийнхүү урт удаан хугацаанд миний амьдрал анх удаа “эрүүл саруул” порнографтаас чөлөөлөгдөв. Эдгэрэлт “үнэхээр дуусаагүй ч” эрх чөлөөний шинэ төвшин надад

ирсэн билээ. Хөтөлбөрт оролцсоны ачаар миний донтолтын учир шалтгаан юу болохыг би ойлгосон.

Ихэнх донтогсад амьдралдаа мэдэрдэг хоосон зайг бөглөхийн тулд ямар нэг байдлаар “өөрийгөө тайвшруулах” арга хэрэглэдгийг би мэдэж авсан. Сэтгэлийн эмзэглэл, уй гашуу, ганцаардал, айдас эсвэл алив нэг байдлаар сэтгэл санаа тавгүй байх нь сэтгэл санаагаа өөд татахын тулд энэхүү өөрийгөө тайвшруулах аргыг ашиглахад хүмүүсийг уруу татдаг ажээ. Зарим хүн жороор олгодог эмийг хэрэглэдэг. Зарим нь хориотой эмнүүдийг ашигладаг. Зарим нь архи уудаг. Миний хувьд порнограф үзсэнээр богинохон хугацаанд “гялс” надад хэрэгтэй байгаа зүйлийг өгдөг гэж боддог байлаа.

Яагаад энэ донтолтод уруу татагдсанаа мэдэх нь нэг хэрэг, харин намайг донтолтод уруу татсан нөхцөл байдлаас зайлсхийх нь өөр хэрэг байлаа. Донтолтоос ангижрах нь амьдралынхаа үлдсэн хугацаанд хоногийн 24 цагийн турш, долоо хоногийн долоон өдөр сэрэмжтэй байхыг шаарддаг. “Зүгээр нэг зэрвэсхэн харахын” төлөө ч онлайнд орж болохгүй байлаа. Ганцаараа байхдаа онлайнд орохоо бүрмөсөн болив. Есөн шидийн зар сурталчилгаа харахаа больж, элдвийн муу зүйлсийг бодохоо болив. Манай гэрийн зурагт кабельгүй байлаа. Ажилдаа ирж, очихдоо зохисгүй санаа бодол уруу түлхэж мэдэх зарлалын самбар байдаг замаар явахаас зайлсхийдэг болов. Хэрэв санаа бодол минь ямар нэг байдлаар тогтворгүй болж эхлэх юм бол би эхнэртээ эсвэл бишоптойгоо ярилцах юм уу хүч чадлын төлөө залбирдаг байв.

Донтолт миний амьдралын өчүүхэн хэсгийг эзэлдэг ч ийнхүү сэрэмжлэх нь чухал байлаа. Донтолт надад болон хайртай хүмүүст минь ямар гай авчирч болохыг би мэдэж байсан учир дээрх хамгаалалтын арга хэмжээг үл тоомсорлож болохгүй байлаа.

## Бурханд найдсан нь

Энэ бол зөвхөн муу зүйлээс зайлсхийх явдал биш юм. Сайн сайхан зүйлд тэмүүлэх байнгын хүч чармайлт шаардлагатай байлаа. Хөтөлбөрийн нэлээд хэдэн зүйл нь намайг хүч чармайлт гаргахад тусалж, Бурханд улам ойртуулсан юм.

Өглөө болгон сэрэхдээ өвдөг дээрээ сөхөрч, нүглээ наманчилж, Түүний Хүү Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан Түүнд ирэх боломж олгосных нь төлөө би Тэнгэрлэг Эцэгт хандан залбирдаг. Хүслийг тань биелүүлэхийн тулд Та надад хүслээ мэдүүлнэ үү гэж би Түүнээс гуйдаг. Намайг уруу таталтаас зайлуулна уу хэмээн би Түүнээс гуйдаг. Би энэ залбирлаа зүрх сэтгэдээ өдөржин тээж явдаг учир өдрийн өнгөрөх хором бүрийг Тэнгэрлэг Эцэгтээ найдан амьдардаг билээ. Тэгээд орой болгон дахин залбирна. Санаа бодлоо ариун журамтай зүйл дээр төвлөрүүлэхийн тулд өдөр бүр судар уншихад тодорхой хугацааг зориулна. Хэрэв би эдгээр зүйлсийг хэвшил болгон мөрдөхгүй бол Сүнс миний амьдралд мэдрэгддэггүй. Ганцаархнаа байгаа үед уруу таталтыг эсэргүүцэх хангалттай хүч надад байдаггүй.

Зан авирынхаа сул талыг хүссэн үедээ өөрийнхөө хүч чадаар даван туулахад юухан байхав гэдэгт би урт удаан хугацаанд итгэж явсан хүн. Гэвч хэрэг дээрээ огт тийм биш байлаа. Донтолтоос зөвхөн “өөрийн хүчээр” ангижрах гэж хэсэг оролцсоны дараа энэ нь бүтсэнгүй. Тэгээд Их Эзэний тусламжгүйгээр хийх хэрэгтэй зүйлээ хийж чадахгүйг сая ойлгосон доо. Ифер 12:27 энэ талаар илүү сайн ойлгоход надад тусалсан юм. Их Эзэн Моронайд “Миний өмнө өөрсдийгөө даруусгадаг бүх хүмүүст миний ач ивээл хангалттай; учир нь хэрэв тэд миний өмнө даруусгаж мөн надад итгэлтэй байх аваас тэгвэл би тэдэнд сул дорой зүйлүүдийг нь хүчирхэг болгож өгнө” хэмээн хэлсэн билээ.

Нэгэнт би Түүнд очсон болохоор чадах бүхнээ хийж байгаа (2 Нифай

25:23-ыг үз) бөгөөд Түүний тусламжтайгаар би илүү амжилтанд хүрч чадна гэдгийг, өөрийнхөө хүч чадлаар мөрөөдөөд ч хүрч чадахгүй тийм хэмжээнд хүртэл хөгжиж чадна гэдгийг ухаарч ойлгосон билээ (Алма 7:14-ийг үз).

Одоо эхнэр бид хоёр донтолоос ангижрах хөтөлбөрийн цуглаануудад дэмжлэг үзүүлэгчдээр үйлчилж байна. Цагаатгал бол зөвхөн донтолыг даван туулахаар ажиллаж байгаа хүмүүст төдийгүй өөрсдийнхөө сонголтын улмаас биш атлаа донтолын балаг тэдэнд нөлөөлж буй хүмүүсийн төлөө байдаг гэдгийг мэдэж, үүнийг ойлгоход нь бусдад тусалж байна. Хэрэв бид Аврагчид хандвал Түүний ач ивээл бидний бүх амьдралын туршид үйлчлэх болно.

Донтолттой тэмцэж байгаа хүмүүст мөн тэдний хайртай хүмүүст найдвар бий шүү гэдгийг би гэрчилж байна. Есүс Христийн сайн мэдээнд ямагт найдаж болно.

### Аврагчид найдах нь

Чухамдаа Есүс Христ намайг нүглийн гинжнээс аварсан учраас би Түүнд гүнээ талархаж явдаг. Донтолт бол гинжээр хүлэгдсэнтэй адил “зовлон гамшгийн мөнхийн ангалд тэднийг доош олзлон хүргэхийн тулд хүмүүний үрсийг хүлэх тэр гинжтэй” (2 Нифай 1:13) адил юм. Би зовлонд унаснаа ойлгосон үед хаашаа хандахаа мэдэхгүй байлаа. Би хүнд байдлаасаа өөрөө гарч чадахгүйдээ гутардаг байлаа. Харин Их Эзэн намайг чөлөөлсөн юм. Намайг Түүнд хандахад Тэр тусалсан.

“Тийм ээ, би юу ч биш гэдгээ мэднэ; чадлынхаа хувьд би сул дорой; тиймийн тул би өөрөөрөө бардамнахгүй, харин би Бурханаараа бардамнах болно, учир нь түүний хүч чадалд би бүх зүйлийг хийж чадна” (Алма 26:12) гэсэн Аммоны үгийг би эш татаж чадна. Бурхан бидэнд бүх зүйлийг түүний дотор донтолын гинжийг тасдаж хаяхад тусалж чадна. ■



### ПОРНОГРАФЫГ ЯЛАХАД ЮУ ТУСЛАХ ВЭ

**А**рхи, мансууруулах бодис, (жороор олгодог эм болон хууль бус бодис) тамхи, цай, кофе, порнограф, бэлгийн гаж буруу харилцаа, мөрийтэй тоглоомонд донтох, өөр хүнээс хэт хамааралтай болох, буруу идэх зуршилд автагдсан хүмүүст зориулсан төлбөргүй, хамрагдагчдын хувийн нууцыг хадгалдаг *Донтолоос ангижрах хөтөлбөрийг* Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Гэр Бүлийн Төсөл санал болгодог. Хамгийн ойрхон болдог цуглааныг олохын тулд [www.ldsfamilyservices.org](http://www.ldsfamilyservices.org)-хаягаар орж үз. Ойрхон болдог ийм цуглааны талаар танай санваартны удирдагчид мэддэг байж болно.

Хэрэв та цуглаануудад оролцох боломжгүй бол уг хөтөлбөрийг судлах удирдамжийг ашиглаж болно. *Addiction Recovery Program: A Guide to Addiction Recovery and Healing* (зүйлийн дугаар 36764) товхимлыг олон орны хэлээр Хангамжийн төвүүдээс авах буюу [www.recoveryworkbook.lds.org](http://www.recoveryworkbook.lds.org)-аас PDF файлаар үзэж болно.

*Combating Pornography.org* бол донтолттой тэмцэж буй хувь хүмүүст зориулсан Сүмийн ивээн тэтгэдэг вэбсайт юм. Энэ нь бас тэдний эхнэр буюу нөхөр, эцэг эх, санваартны удирдагчдад тусалж болно.

*Let Virtue Garnish Thy Thoughts* (зүйлийн дугаар 00460) бол порнографтай тэмцэж байгаа хүмүүст туслах зориулалттай товхимол юм. Энэ товхимолд хор хөнөөлтэй мэдээллийн хэрэгслийг хэрхэн таних, порнографын уруу таталтыг эсэргүүцэх, түүнээс зайлсхийх болон порнографт донтсоноо хэрхэн орхих тухай, наманчлал, биеийн цэвэр ариун байдал болон дэлхийн нөлөөг даван туулах тухай судрууд болон Сүмийн бусад эх сурвалжуудыг жагсаасан байдаг. Сүмийн удирдагчид, гэр бүлийн гишүүд порнографтай тэмцэж буй хайртай хүмүүстэйгээ хуваалцаж болох ба товхимлыг олон хэлээр Хангамжийн төвүүдээс авч болно. DVD-гээр Америкийн дохионы хэлээр байгаа.

Энэ сэдвээрх бусад хэлсэн үг, өгүүлүүдийг [www.liahona.lds.org](http://www.liahona.lds.org) вэбсайтад жагсаасан байгаа.

# АЗ ЖАРГАЛД ХҮРГЭХ ҮНЭНИЙ ЗАМ

*Бид гэр орон,  
ажил төрөлдөө  
жинхэнэ аз жаргалд хүргэх  
үнэний замаар  
замнаж, мэдлэг  
болон нөлөөгөө  
дэлхийн хүмүүст  
илүү зөв шударга  
байдал, амар амгалан,  
ойлголт мэдлэгийг  
дэлгэрүүлэхийн тулд  
ашиглахын төлөө  
би залбирч байна.*

“Аз жаргалтай амьдралын” жорын тухай олон зууны турш маргасаар байна. Төлөөлөгч Паул Афинд Марсын толгод дээр “Епикур, Стойкийн гүн ухаантнуудтай” мэтгэлцсэн юм (Үйлс 17:18). Стоикчууд хамгийн эрхэм сайн сайхан зүйл бол ариун журам гэж үздэг байхад Епикурчүүд хамгийн эрхэм сайн сайхан зүйл бол зугаа цэнгэл гэдэгт итгэдэг байжээ. Олон стоик бардам зантай болж, “хүсэл санаархал, нүгэл хилэнцээ . . . хаацайлахын” тулд философийг ашиглаж байв. Олон епикур “маргааш үхэх юм чинь өнөөдөр ханатлаа идэж, ууцгаая” гэсэн уриатай, зугаа цэнгэл хөөж, хар амиа хоохойлсон хүмүүс болжээ.<sup>1</sup>

Дэлхийн эрдэм боловсролтой хүмүүсээс олон нь “оюун ухааны бясалгал”-ыг “аз жаргалтай амьдралын” гол шинж тэмдэг гэж үздэг Аристотелын үзэл баримтлалыг урт удаан хугацаанд баримталсаар байна. *New York Times Book Review*-д тойм бичигч нэгэн “хүний аз жаргалтай амьдралын олон бүрэлдэхүүн хэсгийг бүрдүүлдэг ганцхан зөв тэнцвэржүүлэгч байдаггүй” гэсэн дүгнэлтийг орчин үеийн философичид хийдэг хэмээн бичжээ.<sup>2</sup>”<sup>2</sup>

*New York Times* сонины нэг өгүүлэлд “Тэрлэлтээс ирдэг аз жаргал нь хүний сайн сайхан байдлыг тодорхойлогч бусад ямар

ч зүйлээс хавьгүй илүү чухал юм” хэмээн өгүүлжээ. Тэрбээр “оюутнуудыг ажил мэргэжилд бэлтгэхэд” бага цаг зориулж, “оюутнуудыг нийгмийн амьдралын шийдвэр гаргахад бэлтгэхэд” илүү их цаг зарцуулахыг уриалжээ.<sup>3</sup>

Би эдгээр үгсийг уншихын хамт Бошиглогч Иосеф Смит “Аз жаргал бол бидний оршихуйн зорилго, утга учир юм; мөн энэ нь төгсгөлтэй хэрэв бид аз жаргал өөд хөтөлдөг замаар замнах юм бол энэ зам нь ариун журамтай, шулуун шударга, итгэлтэй, цэвэр ариун бөгөөд Бурханы бүх зарлигуудыг сахих явдал мөн” хэмээн сургасныг тунгаан бодож үзсэн.<sup>4</sup>

*New York Times* сонин дахь гэрлэлтийн тухай үзэл баримтлал болон Бошиглогчийн энэхүү өөдрөг үзэл бүхий тунхгийн үзэл санаагаар бидэнд төлөвшөөсэй хэмээн Бурханы хүсдэг тэрхүү аз жаргалд бид хүрч чадна гэдэгт би итгэлтэй байдаг. Тэрхүү аз жаргалд хүрэхийн тулд бид юу хийх ёстой вэ?

## **Өвөг дээдэстээ талархалтай бай**

Адислалуудынхаа төлөө ялангуяа өвөг дээдэстээ үргэлж талархаж яв. Бид сайн эцэг эхээр адислагдсан учраас үргэлж талархалтай байх ёстой. Энэ бол бидний хүн нэг бүр өвөг дээдсийнхээ төлөө төлөх ёстой өр юм.



**Ахлагч  
Квинтин Л.Кук**

Арванхоёр  
Төлөөлөгчийн  
Чуулгын Ахлагч

“Алтыг нь аваад, авдрыг нь бүү хая” гэсэн зүйр үг байдаг. Бид эцэг эхээ хүндлэх ёстойг судруудад тодорхой заасан байдаг. “Хүү минь, эцгийнхээ тушаалуудыг сахь, эхийнхээ зааж сургасныг бүү огоор” (Сургаалт Үгс 6:20) хэмээн сударт өгүүлдэг билээ. Германы агуу философич Гоет эцэг эхээ хүндлэх тухай ийн өгүүлжээ:

*Өвөг дээдэс, эцгүүдээсээ өвлөж авснаа үнэхээр эзэмшье гэвэл үүнийг шинээр сур!*<sup>5</sup>

Бид эцэг эхдээ талархалтай байж, бидэнд хүлээлгэсэн итгэл найдварыг нь алдахгүйн төлөө ямагт сайн үйлс бүтээж явах ёстой юм.

### **Бие сэтгэлээ гэр бүлдээ бүрэн зориул**

Хоёрдугаарт: аз жаргалын үндэс суурь болсон мөнхийн гэр бүлд бие сэтгэлээ бүрэн зориул. Дэлхийд өнөө үед олон хүн гэрлэхгүй байхаар сонгож эсвэл гэрлэхээ хойшлуулж байна. Гэр бүл бол дэлхий үндэслэгдэн бий болохоос өмнө Бурханаас томилогдсон үүрд мөнхийн байгууллага



Хайраар бялхсан, зөв шударга гэр бүлүүдэд байдаг баяр баясгалан, хайр энэрэл, амжилт бүтээл нь бидний хурч чадах хамгийн агуу аз жаргалыг бий болгодог билээ.



мөн. Ихэнх хүмүүс гэрлэж, үр хүүхдээр адислагдах болно. Үр хүүхэдтэй болохоос илүү эрхэм дээд адислал энэ амьдралд байхгүй. Бүх судрууд дахь хамгийн сэтгэлд хоногшим хэсэгт бидний Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөн дэх хүүхдийн ач холбогдлыг тод томруунаар өгүүлсэн байдаг. Хүүхдүүд үнэхээр “ЭЗЭНээс ирдэг бэлэг” (Дуулал 127:3) мөн.

Намайг 20-иод настай байхад Ерөнхийлөгч Давид О.МкКей (1873–1970) гэрлэлт болон хүүхдүүдийн тухай захиас хэлж билээ. Тэр 95-тай байсан бөгөөд тэр жил амьдралынх нь сүүлчийн жил байлаа. Эрэгтэй, эмэгтэй хүний хоорондох цэвэр хайр бол “дэлхий дээрх хамгийн эрхэм ариун зүйлсийн нэг бөгөөд хүүхэд төрүүлж, өсгөн хүмүүжүүлэх нь хүмүүний бүх үүргүүдээс охь манлай нь юм” хэмээн сургасан юм.<sup>6</sup>

Тэр үед Ерөнхийлөгч МкКей гэр бүл салалт нэмэгдэж байгаа тухайд санаа зовдог хуваалцсан ажээ. 1969 онд Калифорни муж Нэгдсэн Улсын “шалтгаангүйгээр гэр бүл салахыг” зөвшөөрсөн анхны муж улс болов. Түүнээс өмнө гэрлэлтийг цуцлахад эхнэр,

нөхрөө хуурч, итгэл эвдсэн эсвэл өөр ямар нэг онцгой шалтгааны улмаас салж болдог байжээ. Ерөнхийлөгч МкКей гэрлэлтэд учирч буй асуудалд санаа нь зовж байсан нь тодорхой юм. “Өнөөдөр Нэгдсэн Улсад гэр бүл салалтын хувь өсөн нэмэгдсээр байгаа нь энэ үндэстэнд ноцтой аюул занал учруулж байна” хэмээн мэдэгджээ.<sup>7</sup>

Бид Ерөнхийлөгч МкКейн сургамжилсан зүйлийг эргэж харвал энэ нь үнэхээр бошиглолын шинжтэй ажээ. *U.S. News and World Report* -ын одоогийн ерөнхий эрхлэгч тэр үеэс хойших гэр бүл салалтын түүх болон түүний үр дагавруудыг он дарааллаар авч үзсэн байна. “Гэр бүл салалтын хувь 1960-аад оноос хойш хоёр дахин илүү болсныг, бутач хүүхдийн төрөлт 1960 онд 5 хувь байснаа өнөөдөр 35 хувь болж өссөнийг” тэмдэглэжээ. Тэрбээр гэр бүл салалтын хор уршиг болон хүүхдүүдэд үүний үзүүлж буй сөрөг нөлөөг тайлбарлажээ. Энэ бүгд “Төрсөн эцэг эх хоёроос бүрддэг тогтвортой гэр бүл нь . . . хүүхдийн зан чанарыг төлөвшүүлж, өсгөн хүмүүжүүлэх, эрхэмлэх зүйлсийн тухай итгэл үнэмшил бий болгон хөгжүүлж,



ирээдүйг нь төлөвлөх төгс байгуулла-  
лага болон хувирсныг” тодорхой  
харуулсан юм.<sup>8</sup>

*New York Times* сонины өгүүлэлд  
“Өнөөгийн нийгэмд . . . материал-  
лаг сонирхол давамгайлж, эртний  
ёс суртахуун, нийгмийн сонирх-  
лоос ангид болсны улмаас “сүнсний  
зүйлүүдэд харалган” болжээ гэсэн  
дүгнэлт хийсэн байна.<sup>9</sup> Энэ чинь  
Ерөнхийлөгч МкКейн бошигласон  
зүйл биш гэж үү?

Сүмийн итгэлтэй гишүүдийн  
гэрлэлтийн дийлэнх хувь нь аз  
жаргалтай, тогтвортой байгааг би  
та бүхэнд батлан хэлж байна. Ха-  
раахан гэрлэж амжаагүй та бүхэн  
гэрлэлт, гэр бүлийн төгс зорилго  
өөд итгэл үнэмшилтэйгээр урагш  
тэмүүлэх хэрэгтэй. Өөрийнхөө

бахархан биширдэг, хамгийн  
дотны найз тань байж чадах нэг-  
нийг үүрдийн итгэлт ханиа болгон  
сонгохыг би та нарт зөвлөж байна.  
Хайраар бялхсан, зөв шударга гэр  
бүлүүдэд байдаг баяр баясгалан,  
хайр энэрэл, амжилт бүтээл нь  
бидний хүрч чадах хамгийн агуу  
аз жаргалыг бий болгодог билээ.  
Энэхүү аз жаргал нь цэцэглэн  
хөгжсөн нийгмийн үндэс суурь  
мөн. Зөв шударга бөгөөд энэхүү  
зорилгодоо хүрч чадаагүй хүмүүс  
Тэнгэр дэх Эцэгээс хүүхдүүддээ  
зориулсан адислал бүрийг хүртэх  
эрхтэй юм.

#### **Сайн нөлөө үзүүл**

Гуравдугаарт: дэлхийд сайн  
нөлөө үзүүлэх хүчирхэг хүчин

зүйл бай. Өөр нэг сорилт бол  
дэлхийнх биш байж, дэлхийд  
амьдрахын тулд судрууд дахь ту-  
шаалуудыг шимтэн судлах явдал  
мөн (Иохан 17-г үз). Ерөнхийлөгч  
Жозеф Фиелдинг Смит Арванхоёр  
Төлөөлөгчийн Чуулгын гишүүн  
байхдаа бид дэлхийд байдаг бо-  
ловч . . . тэдний хилэнцэт ёс зан-  
шил, . . . хүсэл тачаал, . . . мунхаг  
явдал, . . . хуурамч онол, сургаа-  
луудаас хуваалцдаггүй болохоор  
бид дэлхийнх биш байдаг” хэмээн  
сургажээ.<sup>10</sup> Түүнээс гадна, амьдар-  
даг газартаа та нарын оруулдаг  
хувь нэмэр бол хүмүүст үлгэр жи-  
шээ үзүүлж, сайн мэдээг хуваал-  
цан, эцэг эх болон бошиглогчдын  
заасан үнэнүүдийн дагуу амьдрах  
явдал бөгөөд энэ нь та нарын



сорилтын нэг хэсэг мөн.

Энэ сорилтыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд та дэлхийд сайн нөлөө үзүүлэх хэрэгтэй мөн ийм хүсэлтэй байх ёстой. Бид ийнхүү хичээж, соригдож, туршигдсанаараа илүү агуу хаант улсын хувьд зохистой байж чадна. “Шийдвэр хувь заяаг тодорхойлдог” хэмээн Ерөнхийлөгч Томас С.Монсон заасан билээ.<sup>11</sup>

Энэ амьдрал амар хялбар биш гэхдээ ийм байх ёстой гэсэн хэрэг биш. Гэвч Их Эзэн биднийг адислахын тулд мөн бидний сайн сайхны төлөө сорилт бэрхшээлүүдийг бий болгогчийг бид мэднэ. Эсэргүүцэл тэмцлийг үл хайхран бат бөх зогсох хүч чадлыг Тэрбээр бидэнд өгөх болно. Зөв шударга байдал бол энэхүү хүч чадлын шагнал, харин зөв шударга байдлын шагнал нь “энэ дэлхий дэх амар амгалан хийгээд ирэх дэлхий дэх мөнх амьдрал” (С ба Г 59:23) юм. Дэлхийд сайн нөлөө үзүүлэхийг би та нарт зөвлөж байна.

### **Жишгүүдээрээ үлгэр дууриал үзүүлж, амьдар**

Дөрөвдүгээрт: эргэн тойрныхондоо жишгүүдээрээ үлгэр дууриал үзүүлж амьдар. Та нарын олонд чинь ажил олж хийхэд сорилт бэрхшээл тулгарна. Та ухаалаг байх хэрэгтэй. Ёс зүй, ёс суртахууны өндөр жишгүүдийг чанд баримталдаг, түүний дотор гэр бүлдээ тууштай үнэнч байдгаа ажил олгогчдоод мэдэгдэх нь чухлыг би та нарт зөвлөмж болгож байна.

Энэ нь чухал болохыг би ажил мэргэжлийнхээ гарааг эхэлсэн үед мэдсэн юм. Би Станфордын Хуульзүйн Сургуулийг дүүргэсний дараа хуулийн нэгэн компанид ажиллах зорилгыг өмнөө тавьсан. Сүмийн гишүүн бус хүмүүс тэр компанид ажилладаг байсан ч хуульчид нь

төлөвшсөн, чадварлаг хүмүүс байв. Нэг өглөө ярилцлага хийсний дараа ахлах ажилтан нь өөр хоёр ажилтныхаа хамтаар намайг үдийн хоолонд дагуулж явав. Ахлах ажилтан үдийн хоолны өмнө архи, дараа нь дарс уух уу гэж надаас асуулаа. Би аль алинаас нь татгалзав. Хоёр дахь удаад би тэдэнд идэвхтэй Хожмын Үеийн Гэгээнтэн гэдгээ мөн ямар ч согтууруулах ундаа уудаггүйгээ хэллээ.

Би тус компаниас ажлын санал авснаас хойш хэдэн сарын дараа, согтууруулах ундаа санал болгосон нь сорилт байсныг ахлах ажилтан надад хэлж билээ. Би Хожмын Үеийн Гэгээнтний хувьд номлолд үйлчилснийг тэр миний анкетнаас мэдсэн байжээ. Намайг сүмийнхээ сургаалуудад үнэнч байсан учраас л ажилд авахаар тэр шийдсэн ажээ. Тэр ахлах ажилтан үүнийг зан төлөвийн болон зарчимч байдлын чухал үзүүлэлт гэж үзсэн байлаа.

Би АНУ-ын Калифорний Сан Францискод байсан жилүүддээ Хожмын Үеийн Гэгээнтэн гэдгээ хэлхээ холбоотой байдаг хүмүүстээ мэдэгдэхийг хүсдэггүй хэдэн гишүүнийг таньдаг байлаа. Тэд юунд итгэдгээ шууд хэлэх ёстой байтал тэгээгүйгээс зайлсхийх ёстой нөхцөл байдалд итгэлээсээ ухрахад хүрдэг байжээ.

### **Гэрэл нь бай**

Эцэст нь амьдарч байгаа газрынхаа хүмүүст гэрэл нь бай. 1960-аад оны дунд үед эхнэр бид хоёр шинэхэн гэрлэсэн хосууд Сан Францискогийн Бей дүүрэгт амьдарч байхад Хожмын Үеийн Гэгээнтнүүд харьцангуй цөөхөн байлаа. Түүнээс гадна Сан Францискогийн Бей дүүрэг мансууруулах бодис хэрэглэж бусад бүхий л төрлийн садар самуун, нүгэл хилэнц үйлдэгчдийн

цугларах дуртай газар байлаа. Тэр үеийн гадасны ерөнхийлөгч энэ асуудалд санаа нь зовнин, Сүмийн гишүүдийг Сан Францискогийн Бей дүүрэгт үлдэхийг дэмжиж өгөөч гэж Сүмийн удирдлагаас хүссэн юм.

Тэр үед Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын хамгийн ахмад гишүүн байсан Ерөнхийлөгч Харольд Б.Лийг (1899–1973) энэ асуудлыг шийдвэрлэхээр томилжээ. Тэрбээр санваартны хэсэг удирдагчидтай уулзаж, гишүүд энэ нутгийг орхин явж байгаагаас энд ариун сүм барихыг Их Эзэн дэмжихгүй байгаа тухай ярьсан ажээ. Тэр дараах зөвлөгөөг өгчээ:

1. Сионыг зүрх сэтгэлдээ болон гэр орондоо байгуул.
2. Дунд нь амьдарч байгаа хүмүүстээ гэрэл нь бай.
3. Ариун сүмд заагдааг ёслолууд болон зарчмуудад анхаарлаа төвлөрүүл.

Хэрэв бид өнөөдөр Ерөнхийлөгч Лийгийн зөвлөгөөг дагавал дэлхийнх биш харин дэлхийд байх талаар амжилт гаргаж чадна. Гэвч бид дэлхийд найдах уу эсвэл ариун сүмд анхаарал төвлөрүүлэх үү гэдгийг шийдэх ёстой.

Бид амьдралынхаа туршид дэлхийн олон сорилт бэрхшээлтэй тулгарах болно. Эдгээр сорилт бэрхшээлүүдийн нэг нь Сүм болон түүний сургаалуудыг хүмүүс ойлгохгүй эсвэл буруу ойлгох явдал гарсаар байх болно. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч М.Рассел Баллард хэдэн жилийн өмнө Сүмийн гишүүдийг итгэлээ хамгаалж, буруу ташаа мэдээллийг залруулахад дуу хоолойгоо өргөхийг уриалан дуудсан билээ. “Интернетийн шинэ хэрэгслийг” эзэмших нь бидний хувьд онцгой чухал болохыг тэр онцлон

тэмдэглэсэн юм.<sup>12</sup> Дэлхий даяар тархсан Хожмын Үеийн Гэгээнтнүүд мэдээллийн олон янзын хэрэгслээр Сүмийн тухай хариуцлагагүй, буруу ташаа мэдээлэл гарсан үед тэдгээрт хариу өгч, Сүмийг хамгаалах шаардлага гарч байна. Ахлагч Баллардын өгүүлэл нийтлэгдсэнээс хойш гарсан өөрчлөлтөд бид талархалтай байдаг бөгөөд би түүний өгсөн үүрэг даалгаврыг давтан өгч байна.

Бид өөрсдөө хүсдэг мөн Бурхан бидэнд хүсдэг тэрхүү аз жаргалд хүрч чадна гэдэгт би итгэлтэй байна. Бид гэр бүлдээ болон ажил мэргэжилдээ аз жаргалд хүргэх үнэний замаар замнасан үед илүү зөв шударга байдал, амар амгалан, ойлголт, мэдлэг болон эрх чөлөөг бүх дэлхийн хүмүүст хүргэхэд өөрсдийн мэдлэг, нөлөөг ашиглахын төлөө би залбирч байна. ■

2010 оны 4-р сарын 10-нд Хавай дахь Бригам Янгийн Их Сургууль дээр хэлсэн үгнээс. Англи хэл дээрх бүрэн эхийг <http://devotional.byuh.edu/node/416>-д орж үзнэ үү.

#### ЭШЛЭЛ

1. Фредерик В.Фаррар, *The Life and Work of St. Paul* (1902), 1:535–136.
2. Жим Холт, “A Word about the Wise,” *New York Times Book Review*, Mar. 14, 2010 оны 3-р сарын 14, 12.
3. Давид Брукс, “The Sandra Bullock Trade,” *New York Times*, 2010 оны 3-р сарын 30, х. А23.
4. Иосеф Смит, *History of the Church*, 5:134–135.
5. Жоанн Вульфганг вон Гоег *Faust*, орчуулга. Баяр Тейлор (1912), 1:28.
6. Давид О.МкКей, Conference Report, 1969 оны 4-р сар, 9.
7. Давид О.МкКей, 1969 оны 4-р сар, 8.
8. Мортимер Б.Закерман, “Family-Unfriendly Policies,” *U.S. News and World Report*, 2007 оны 10-р сарын 5, 72.
9. Давид Брукс, “The Sandra Bullock Trade,” х. А23.
10. Жозеф Фиелдинг Смит, Conference Report, 1916 оны 10-р сар, 70.
11. Томас С.Монсон, “Invitation to Exaltation,” *Tambuli*, 1993 оны 9-р сар, 4.
12. М.Рассел Баллард “Интернет ашиглан сайн мэдээг хуваалцах нь” *Лиакхона*, 2008 оны 6-р сар, N1.



Дэлхийд сайн  
нөлөө үзүүлэх  
хүчирхэг хүчин  
зүйл бай.

# ГЭРТЭЭ АЮУЛГҮЙГЭЭР ХӨВЖ ХҮРЭХ НЬ



**Ричард М.Ромни**

Сүмийн сэтгүүлүүд

**В**исахапатнамын загасчид өдөр бүр далайд гардаг. Ихэнх өдөр давалгаа намуухан, далай дөлгөөхөн байдаг бөгөөд завиуд дүүрэн загас ачиж эргэж ирнэ. Гэвч давалгаа үе үе хуйлран догширно. Тэнгэр харанхуйлж, аварга том давалгаанууд хуйлран босоход загасчид зогсоолдоо эсэн мэнд эргэж ирсэндээ баярлана.

Висахапатнамын Хожмын Үеийн Гэгээнтэн залуус өдөр бүр дэлхийн амьдралд хөл тавьдаг. Ихэнх өдрүүд тэдэнд таатай сайхан өнгөрдөг. Тэд мэдлэг эзэмшиж, найз нөхөдтэй болон, амьдралын баяр баясгалангаар дүүрэн гэртээ эргэж ирнэ. Гэвч дэлхий үе үе ороо бусгаа болно. Урам хугарч сэтгэл гонсойх нь далайн давалгаа лугаа адил ихэсч, уруу таталт газар авч, аюул занал учруулан, сүнсний тэнгэрийг эргэлзээ харанхуйлна.

*Энэтхэгийн Висахапатнамын Хожмын Үеийн Гэгээнтэн өсвөр үеийнхэн ороо бусгаа цагт амьдралын хүнд сорилт бэрхшээлийг даван туулахад гэр орон нь амар тайван, аюулгүй газар байдгийг мэддэг ажээ.*

Ийм өдрүүдэд тэд гэр орон хэмээн нэрлэдэг амар тайван, аюулгүй газарт эсэн мэнд эргэж ирсэндээ баярлана.

## **Ханан дээрх зургууд**

Өсвөр насны Хожмын Үеийн Гэгээнтэн Нага Бушан Ратнам, Павани Котала Ратнам хоёр хотоос хол орших жижигхэн орон сууцанд эцэг эхтэйгээ амьдардаг. Харин аав нь гэртээ ойрхон төмөрлөгийн үйлдвэрт ажилладаг ажээ. Гэрийнх нь ханан дээрх зургуудаар тэд юуг бүхнээс илүү эрхэмлэдгийг төвөггүй ойлгоно. Хаалганы ойролцоох номын тавиур дээр гэр бүлийн гэрэл зургууд дүүрэн байлаа. Харин унтлагын хэсэгт Аврагчийн болон ариун сүмийн зургууд, Тэргүүн Зөвлөлийнхний зураг ханыг нь чимжээ.

“Өглөө сэрэх бүрдээ миний хамгийн түрүүнд хардаг зүйл бол эдгээр зургууд юм. Шөнө унтахаасаа өмнө эдгээр зургуудыг бас хардаг” гэж Павани хэллээ.

Бид гэр орноо амар тайван, аюулгүй газар болгож чадна гэдэгт Павани итгэдэг ажээ. “Тийм учраас би бүх зүйлийг цэвэрхэн байлгадаг. Энэ нь гэр орныг Сүнс оршиход тааламжтай болгох нэг арга юм” гэж тэр яриу. Сургууль дээрээ “*би Залуучуудын бат бөх байдлын төлөө* товхимлыг цүнхэндээ үргэлж авч явдаг ба номыг цүнхнээсээ гаргаж ирээд удаан хардаг.”

Эгчтэйгээ ярилцах нь түүнд амар амгаланг авчирдгийг Нага мэджээ. “Бид мэдээж хэрэг аав ээжтэйгээ





*Сүм болон гэр бүл нь Ратнамынханд (өмнөх хуудас) мөн (зүүн дээд талаас нар зөв чиглэлээр) Сужит, Сандийп, Хепсиба Бата, Павани Ратнам, Нага Ратнам нар болон Буттигийн гэр бүл, түүнчлэн гурван салбартай Висахапатнамын бусад залууст аюулгүй газар болдог.*

сайн сайхан байдлыг нэмэгдүүлдэг гэж өсвөр насны хоёр Ратнам ярив. Аав нь найман жилийн өмнө гэр бүлийнхнээ Сүм уруу авч явахын тулд талдаа 40 км газрыг ганц хүний моторт дугуйгаар туулсныг тэд дурсан ярьдаг ажээ. Аав нь баптисм хүртсэн өдөр өвчтэй байсан Паванигийн төлөө тэдний хийсэн итгэлийн залбирлуудын тухай, сургуулийн шалгалтын үеэр хүндээр өвчилсөн Нагад аав нь санваарын адислал өгсөн тухай, аав нь ээжид нь болон тэдэнд зөвлөгөө хэрхэн өгдөг тухай, тэрээр чухал шийдвэр гаргахдаа Тэнгэрлэг Эцэгт хандан залбирдаг тухай тэд ярилцдаг гэнэ.

“Манай гэр бүл сайн мэдээнд өсч хөгжсөнөөр бидний амьдралд нааштай өөрчлөлт гарсныг би харсан. Аав ээж болон ахын минь үлгэр жишээ манай гэр бүлийн отгон гишүүн намайг удирдсан юм. Миний амьдралын юм бүхэнд Есүс Христ тусалсныг би мэднэ. Надад тусалдаг, намайг хайрладаг хүмүүс миний эргэн тойронд байна бас Аврагч надад хайртай. Энэ хайр надад өөр юунаас ч илүү чухал юм” гэж Павани ярилаа.

Манай гэр бүл Хятадын Хонг Конгийн Ариун сүмд лацдан холбуулахаар очсон үед энэ хайр тодорхой харагдсан.

Дэлхий дээр ариун сүм бол бүхнээс илүү аюулгүй газар юм. “Энэ бол ариун газар. Ариун сүмийн тухай зүгээр бодоход л ариун байдал манай гэрт мэдрэгддэг.” Энэ нь Ратнамынхны гэрийг баяр баясгалантай газар болгодог ажээ.

### **Судраас ирдэг аюулгүй байдал**

Висак хотын төвд эцэг эхтэйгээ амьдардаг Хепсиба, Сандийп, Сужит Бата нар судрууд бол тэдний гэр орон дахь амар амгалангийн зангуу юм гэв. “Бид судруудыг уншсанаар өөрсдийгөө зөв замаар удирдах, амьдралдаа зөв шийдвэр гаргахад Сүнсийг урьдаг. Бид бас гэр бүлийн үдшийг хийж, гэр бүлээрээ залбирсан үед Сүнсийг гэр орондоо урьдаг” гэж Хепсиба ярилаа.

Ээж нь тэдэнд “өдөр бүр гадагшаа юманд явах, гэртээ ирэх бүрдээ залбирч бай” хэмээн сануулдаг. “Талархалтай бай” гэж ээж хэлдэг. Энэ нь намайг юм бүхний төлөө талархах хүсэлтэй болгосон юм” гэж Сандийп хэлэв.

ярилцаж, олон зүйл дээр тэдний зөвлөгөөг хүсдэг. Манай аав дүүргийн ерөнхийлөгч тиймээс бид албаны болон албаны бус сэдвээр аль алинаар нь үргэлж ярилцдаг. Бид бас ээжтэйгээ ярилцах дуртай. Гэвч эгчтэй хуваалцах ёстой ямар нэг онцгой зүйл байдаг” гэж тэр ярилаа. Нагаг уурлаж бухимдсан үед Павани түүнийг тайвшруулдаг, Нага нэлээд зожиг болохоор илүү нийтэч байхад нь түүнд тусалдаг гэнэ.

“Гэвч хамгийн чухал нь бид хоёр жишгүүдийг дагахад бие биеэ дэмжиж хүчирхэгжүүлдэг. Жишээ нь: Павани Нагагаас зохистой хувцаслах талаар зөвлөгөө авахыг хүсдэг. Хэрэв аль нэг хувцас Сүмийн жишгүүдтэй нийцэхгүй гэж тэр хэлбэл би түүнийг өмсөхгүй” гэж тэр хэллээ. Тэд бас Сүмд болон нийгэмд үйлчлэл хийх тухай олон удаа ярилцдаг гэнэ. Ийм яриа нь ирээдүйд зүрх, судасны эмч болох Нагагийн мөрөөдөлтэй заримдаа холбоотой байдаг. “Би мэргэжлээ үйлчлэл үзүүлэх бас нэг арга зам байхыг хүсдэг” гэж тэр хэллээ.

Гэр оронд нь санваар байгаа нь тэдний гэр бүлийн

Тэдний гэрээс гадна өөр нэг амар амгалангийн газар бол салбарын цуглаанууд юм. Энд гишүүд сайн мэдээнд хамтдаа суралцаж, шүтэн бишрэхэд бие биедээ тусалж, адил жишгүүдийг баримталдаг залуус үйл ажиллагаанууд дээр бие биеэ хүчирхэгжүүлэн дэмждэг. “Бид бол дэлхийн гэрэл хэмээн Их Эзэн бидэнд хэлсэн шүү дээ” гэж Сужит хэлэв (Матай 5:14-ийг үз). “Бид хамтдаа цугласан үед энэ гэрлийг хурцаар гэрэлтэх болгож, үүнийг хуваалцахдаа улам баяртай байдаг.”

### Аз жаргалтай гэр орон

Энэ бол сайн мэдээг Буттигийн гэр бүлд авчирсан нэг төрлийн хуваалцах арга зам байлаа. Сандиа Бутти, Суда Бутти эгч нар болон тэдний эцэг эхчүүд Сүмийн тухай хэрхэн мэдсэнээ ярих дуртай, энэ тухай ярихдаа үргэлж инээмсэглэдэг ажээ.

“Бид гэр бүлээрээ Сүмд нэгдсэн” гэж Сандиа ярилаа. Бид үнэн сүмийг удаан хугацаанд хайсан, тэгээд энэ сүмд баптисм хүртэх ёстойг ойлгосон. Тэгээд

нэг өдөр манай аав хоёр номлогчийг харжээ. Тэдний нэрийн тэмдэг дээр ‘Есүс Христийн Сүм’ гэсэн үгс байсныг хараад аав тэдэнтэй ярилцах хэрэгтэйг мэдсэн юм.”

Чин сэтгэлийн ярилцлагууд эхлэв. Есүс Христ Эцэгийн хүслийг биелүүлэхийн тулд бидний төлөө зовж, Цагаатгалыг гүйцэлдүүлснээр Түүнийг дагаж, Тэнгэрлэг Эцэгтээ буцаж очих боломжийг олгосныг бид мэдсэн” гэж Суда хэлэв. Тийнхүү Сүмд нэгдэн бат бөх гэрчлэлтэй болсон нь дөлгөөхөн далайгаар хөвөн гэртээ ирэхтэй адил байсан бөгөөд Буттигийнхэн ийм шийдвэр гаргасандаа баяртай байдаг ажээ.

Висахапатнамаас загасчны завиуд өдөр бүр далайд гардаг. Висахапатнамын 1,2-р болон Гайхувака салбарын залуус өдөр бүр дэлхийн амьдралд хөл тавьдаг. Тэд бүгдээрээ танил зогсоолдоо эсэн мэнд эргэн ирж чадна. Харин Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн хувьд тэрхүү зогсоол нь зөвхөн өнөөдөр төдийгүй үүрд мөнхөд аюулгүй байх газар юм. ■

### НӨХӨРЛӨЛИЙН ХӨЛӨГ ОНГОЦООР ХӨВӨХ НЬ

Павани Котала Ратнам сайн мэдээний зарчмуудаар амьдарснаар нөхөрлөлийн тухай олон зүйл сурч мэджээ. “Биднийг Сүмд нэгдсэн үед сургууль дээр манай ангийнхан намайг дандаа шоолдог байлаа. Учир нь би хэзээ ч хуулдаггүй, хэзээ ч худал хэлдэггүй байв. Хэрэв ямар нэг сайн зүйл хийхийг надаас хүсвэл би түүнийг заавал хийдэг байлаа. Бас хүн болгонтой үргэлж эелдэг найрсгаар ярьдаг байлаа. Сүм дээр надад олон сайн найз нар байсан. Харин сургуулийн найзууд маань миний жишгүүдэд дургүй байв. Тэд намайг “солиотой” гэж бусдын өмнө доог тохуу болгодог байлаа.

“Би ямар найзуудтай байвал зохих тухай аав, ээж хоёртойгоо ярилцсан. Аав, ээж хоёртойгоо ярилцсан нь миний гаргасан хамгийн зөв шийдвэрүүдийн нэг байлаа. Аав, ээж хоёр минь надад өөрийнхөө тухай сайнаар бодоход, намайг сайн хүн болж төлөвшихөд тусалсан найз нарыг сонгоход тэрчлэн хүн бүхэнд найрсаг хандахад тусалсан юм.

Удалгүй би хүн бүхэнтэй, дээд зиндааны нэг залуу, тэргүүний оюутантай гээд ер нь л хүн болгонтой ярьж үзлээ. Би сайн үлгэр жишээ үзүүлэхийг хичээдэг байлаа. Эхний үед намайг дэмждэг ямар ч найз байсангүй. Энэ нь надад ч хэцүү байв. Гэвч манай багш нар намайг дэмжсэн юм. ‘Юу чамайг ингэж өөрчлөв?’ гэж тэд хэдэн удаа надаас асуув.

Бусад оюутнууд ‘Чи яагаад биеэ ингэж авч явдаг юм бэ?’ ‘Тэр залуу нийгмийн гарлаараа чиний зиндааных биш байтал яагаад чи түүнтэй ярилцсан юм бэ?’ гэж асуудаг байв” гэж тэр цааш нь ярилаа.

Гэвч эцэстээ эсэргүүцлийн давалгаа намдав. “Би сайн талаараа бусдаас ялгаатай байсан бөгөөд үүнийгээ хадгалж, зөв зүйлийг хийдэг байх ёстой гэдгээ мэдэж байлаа. Энэ тухайд би тууштай байгаа” гэж тэр хэллээ.

Өнөөдөр Паванийг сургууль дээрээ сайн нөлөө үзүүлдэг нөхөрсөг залуу эмэгтэй гэдгийг бусад оюутнууд мэддэг болжээ.



## ЕРӨНХИЙЛӨГЧ МОНСОН ТАНТАЙ УУЛЗЪЯ ГЭЖ БАЙНА

**15** орчим жилийн өмнө би Паркинсоны өвчинтэй гэж оношлогдов. Онош тогтоосноос хойш дөрвөн жил тасралтгүй дордсоор бүр тэргэнцэр хэрэглэх болов. Би амьдралдаа аливаа зүйлд нэн идэвхтэй оролцдог байсан учир өвчний хөө улмаас ихэд санаагаар унав.

Энэ үед би Шотландын Дандийд болсон чуулганд очлоо. Тэр үед Тэргүүн Зөвлөлийн зөвлөх байсан Ерөнхийлөгч Томас С.Монсон уг чуулганд оролцсон юм. Цуглааны дараа нэг гишүүн над уруу хүрч ирлээ.

“Та Шарки ах уу?”

“Тийм ээ?”

“Ерөнхийлөгч Монсонтой уулзах уу.”

Доошоо бууж очих бодолгүй байтал

хэдэн минутын дараа нөгөөх хүн буцаж ирээд,

“Ерөнхийлөгч Монсон тантай уулзахаар хүлээж байна шүү, Шарки ах аа” гэх нь тэр.

“Тэр намайг танихгүй шүү дээ” гэж би хариуллаа.

“Гэсэн ч тэр тантай уулзахаар хүлээж байна. Таны өвчний талаар сонссон гэнэ.”

Би зөвшөөрч Ерөнхийлөгч Монсонтой уулзахаар очлоо. Тэр надтай эелдгээр мэндлээд санваарын адислал авах уу

гэж асуув. Би “тэгье ээ” гэлээ.

Тэгээд бид нэг өрөө олж, хэнээр тос түрхүүлэх вэ гэж Ерөнхийлөгч Монсон надаас асуув. Манай бишопыг хүн явуулж авчирч болох уу гэж би асуулаа. Хэн нэгэн нь бишопыг авчрахаар явах хооронд Ерөнхийлөгч

Монсонтой хамт яваа хүмүүсийн нэг нь “хэрэв хурдлахгүй бол онгоцноос хоцрох нь” гэж түүнд сануулав.

Ерөнхийлөгч Монсон инээмсэглээд “Та бидний насанд хүрэхээрээ юут хамгийн чухал болохыг мэддэг болно оо. Бид цагтаа очно” гэв.

Бишоп ирж, тэд надад адислал өгөв. Ерөнхийлөгч Монсонгийн надад өгсөн адислал эрүүл мэндийн адислал биш, харин миний байдлыг болон үүнээс улбаатай зовиурыг хөнгөвчлөх адислал байлаа. Энэ нь бас өвчинтэйгөө дасан зохицоход надад туслах боломжтой байхын төлөө гэрийнхэнд минь зориулсан адислал байлаа.

Эдүгээ арван жилийн дараа би Паркинсоны өвчинтэй хэвээрээ ч 74 нас хүрээд дажгүй л явж байна. Би чухамдаа өвчинтэйгөө дасан зохицох арга замыг олсон юм. Ерөнхийлөгч Монсонгоос адислал авсан өдрөөс эхлэн бие сайжирч, тэргэнцэр хэрэглэхээ больсон. Эмч маань намайг өөрийнхөө “хамгийн сайн өвчтөн” гэдэг.

Ерөнхийлөгч Монсон танихгүй ч надтай эелдгээр ярилцаж, адислал өгсний төлөө би түүнд үргэлж талархаж явах болно. Түүнчлэн санваарыг хэрхэн ашиглах талаар түүний заасан зүйлд би талархаж явах болно.

Бид Сүмд өөр өөр түлхүүр атгаж, өөр өөр албан тушаал хашдаг ч адилхан санваартай байдаг. Ерөнхийлөгч Монсонгийн эелдэг уриалгахан үйлдэл нь санваар гэдэг бол үүнийг зүгээр л эзэмшиж явахын нэр биш харин Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүдийн амьдралыг адислахын тулд хэрхэн ашиглахыг бид мэддэг байх явдал мөн гэдгийг надад заасан юм. ■  
Жорж Шарки, Шотланд

*Ерөнхийлөгч Монсон надтай эелдгээр мэндлээд санваарын адислал авах уу гэж асуув.*



# САНВААРААР АДИСЛАГДСАН МИНЬ

**Б**и 1996 онд ганц бие эх байхдаа Сүмд элссэн билээ. Миний ихрийн өрөөсөн Тереза надаас хэдэн жилийн өмнө Сүмд нэгдсэн байлаа. Терезаг баптисм хийлгэхэд бидний нэг найз надаас “Тереза яагаад энэ сүмд элсч байгаа юм?” Энэ Сүмийнхэн эмэгтэйчүүдийг ойшоодоггүй шүү дээ” гэж билээ.

Тэр найзын маань ойлолт буруу гэдгийг би Сүмийн гишүүдтэй харилцаатай байсан тул мэддэг байлаа. Миний мэдэхээр мөн харснаар Сүмийн гишүүдийн гэрлэлт хамгийн бат бөх бас эрх тэгш байсан юм. Сүмд зөвхөн эрэгтэйчүүд санваар эзэмшдэг ч тэд санваараа бүх нийтийн ашиг тусын тулд хэрэглэдэг гэдгийг би мэддэг байлаа.

Баптисм хийлгэснээс 11 жилийн дараа надад хөхний хорт хавдар оношлогдоод энэ үнэнийг улам ч хүчтэйгээр мэдэрсэн юм. Өвчний тухай мэдээд санваарын адислал авах хэрэгтэй гэсэн сүнсний өдөөлтийг мэдэрч тэр оройдоо санваарын адислал авав. Хорт хавдраас ангижирч бие минь эрүүл болон, Сүнс миний эмч нарыг удирдах болно гэсэн амлалтыг би тэр адислалаар хүлээн авч билээ.

Дараагийн гурван жил эмчлүүлэх болон мэс засал хийлгэх явцад миний хүлээж авсан олон адислалаас тэр адислал анхных нь байсан юм. Хэрэв эдгэрэлт нь Их Эзэний хүсэл мөн сүнслэг байдлын хувьд хүнд сорилттойгоо тэмцэх хүч өгөгдсөн бол эдгэрэх болно гэдэг итгэл надад төрсөн билээ.

Мэс заслын дараа шөнө хоёр дахь эдгэрэлтийг мэдэрч билээ. Маш их өвдсөнөөс болж сэрснээ



*Өвчний тухай мэдээд санваарын адислал авах хэрэгтэй гэсэн сүнсний өдөөлтийг мэдрэв.*

би санадаг. Яг тэр мөчид “Бие чинь сайжрахыг та мэдрэх болно. Бие чинь эрүүл болно гэдгийг танд амласан шүү дээ. Иймээс та эрүүл болно гэдгээ мэдэж байгаа” гэсэн бодол дотор зурсхийн орж ирлээ.

Өөр нэг удаа би ирээдүйнхээ талаар сэтгэл түгшин, шөнө дунд гэнэт сэрлээ. “Миний хувь заяа хаашаа эргэдэг бол?” гэж бодлоо. Сэтгэлийн тэр түгшүүр хоёр цаг орчим үргэлжилсэн ч, өвчинтэй тэмцэлдсэн гурван жилийн туршид ганцхан удаа ийнхүү сэтгэлийн

түгшүүр төрсөн нь энэ. Санваарын адислалуудаас миний хүлээн авсан амар амгалан надад хүч тамир өгч, гэсвэрлэж чадахгүй болов уу гэж бодож байсан зүйлийг даван туулах боломжийг олгосон юм.

Санваарын хүч намайг мэс заслын дараах хүндрэл болон халуурах үед надад байнга хүч чадлыг өгдөг байлаа. Ийм үед нэг орой манай хадам ах эмнэлэг дээр хүрч ирэн надад адислал өгөв. Халуун өдөржингөө нэмэгдэж байсан ч адислалын дараа аажмаар буурсан. Үүнд би гайхсангүй харин бишрэн шүтэж билээ.

Намайг эмчилж байсан эмч нарыг Сүнс удирдах болно гэсэн амлалт биелэгдсэнийг харлаа. Нэг мэс заслын дараа намайг сэрэхэд мэс заслын эмч хүрч ирэв.

“Би мэс заслаа дуусгах гэж байтал ямар нэг зүйл намайг илүү анхааралтай бай гэж сануулах шиг болсон, үүний үр дүнд би цааш тархсан байсан хавдрыг илрүүлж, түүнийг арилгасан. Илүү хавдар байсныг олсон нь маш азтай хэрэг шүү” гэж эмч надад ярьж билээ.

Тэр эмч Сүмийн гишүүн биш ч харин өмнө нь миний авсан адислалын амлалт биелэгджээ гэдэгт би итгэлтэй байлаа. Сүнс түүнийг удирдсан хэрэг.

Би тойргийнхоо зохистой санваартнуудад амьдралыг минь адислахын тулд санваарыг ашигласанд нь талархаж явдаг билээ. Санваартаа хүндэтгэлтэй хандаж, бусдыг адислахад үүнийг ашиглахад нь нөхрүүддээ дэмжлэг үзүүлж тусалдаг эхнэрүүдэд нь би баярлан талархдаг. Тэр дундаа дэлхий дээрх Өөрийн хүчээр, Түүний бүх хүүхдүүдийг адисалдаг тэрхүү хүчээр биднийг адисалсан Тэнгэрлэг Эцэгтээ би талархаж байна. ■  
Виржиниа Гиллис, Массачусетс, АНУ

## ААВ АА, ТУСЛААРАЙ

**А**НУ-ын хойд Калифорни дахь ферм дээрээ би усны хоолойг шилжүүлэн байршуулж байлаа. Энэ өдөр аав надад туслахаар ирсэн учир сайхан өдөр байлаа. Бид хоёр ажлаа дуусгаад ачааны машиндаа үсрэн орж, амттайхан хоолоо бодон, гэрийн зүг хөдөлөө. Аав машин барьж явлаа.

Манай ферм нэг талаараа Пит голын эрэгтэй нийлдэг байв. Бид таримал царгасанд машиныхаа том дугуйг хагалчихгүйн тулд талбайн захаар явлаа. Бидний баруун талд талбай, зүүн талд доод талаараа далантай гүнзгий гол байлаа. Манантай байсан учир зам сайн харагдахгүй байв.

Бид бага зэрэг хурдтай явж байсан тул замаасаа гарч, баруун талын хойд дугуй мугваагийн өтгөн саглагар бутанд шигдчихлээ. Үүнээс болоод машинаа зүүн тал уруугаа далан уруу огцом эргүүлээ. Зогсох гэж оролдсон ч голын эрэг огцом эгц байснаас гадна бид хурдтай явж байсан учир зогсож чадсангүй. Яг л гол уруу орчих нь дээ гэж бодогдлоо. Аз болоход голын эрэгт зам дээр нэг мод харагдлаа. Дараагийн удаа миний мэдрсэн зүйл бол би модон дээрээс доор байгаа машинаа харж байх нь тэр! Ёстой л үнхэлцгээ хагартал аялаа.

Ингээд үхдэг байжээ гэж бодсон чинь харин ч гайгүй, хэсэг газар хөх няц болж, зурагдан шалбарчээ. Тайвширч хэсэг амьсгаа авсны дараа машинаа далан уруу эргэж гаргах аргагүй болсноо ухаарав. Аав намайг эрж, далангийн ирмэг дээгүүр өнгийж харах болов уу гэж

бодсон ч тэгсэнгүй. Би сандарч эхлэв.

Далан дээр авиран гарсан ч аав харагдсангүй. Тэнгэр дэх Эцэгтээ хандан чимээгүй залбирч, намайг авахаар аавыг буцааж явуулна уу гэж гуйлаа. Тэгээд голын эргийг дагаж алхав.

Гэнэт намайг өөрийг нь дуудах шиг болохыг сонсох тэр мөчид аав бараг гэртээ ирээд байжээ. Аав талбайг орхиж явснаас хойш анх удаа эргэж харсан гэнэ. Тэгэхэд л аав намайг ардаа байхгүйг анзаарчээ. Ямар нэгэн базаахгүй юм болсныг мэдэж, надад туслахаар эргэсэн аж.

“Аав аа, туслаарай!” гэж намайг хэлэхийг сонссон гэж аав хожим нь надад ярьж билээ. Тэр үед аав надаас гурван км гаруйн зайтай явж байсан билээ. Яг тэр мөчид хайраар дүүрэн Тэнгэр дэх Эцэг минь миний залбирлыг сонсож, түүний тусламж надад хэрэгтэй байгааг аавд минь мэдрүүлсэн ажээ.

Би Ариун Сүнсэнд болон Түүнээс бидний хүлээн авдаг үнэний тухай шивнээ болон удирдамжинд талархалтай байдаг. Бас Ариун Сүнс түүнд юу гэж хэлэхийг амьдралдаа үргэлж сонссоор ирсэн хайртай аавдаа би баярлан талархаж явдаг. ■

Майкл К. Хюветт, Юта, АНУ

*Тэнгэр дэх Эцэгтээ хандан чимээгүй залбирч, намайг авахаар аавыг буцааж явуулна уу гэж гуйлаа.*



## АДИСЛАЛ АВАХ УУ?

**Н**эг өглөө би Бригам Янгийн Их Сургуулийн өмнө талд байдаг огцом өндөр толгод өөд мацан гарлаа. Гэнэт аваар гарч байгаа чимээ сонслоо. Эргэн тойрноо ажиглан хартал нэг залуу явган хүний зам дээр түрүүлгээ харан хэвтэж байв. Унадаг дугуй нь хэдэн метрийн зайд хэдэн хэсэг болон салж унажээ. Түүнийг толгойгоо сулхан өндийлгөх гэж оролдох хүртэл нь би яах ч учраа олохгүй зогсож байлаа. Би толгод өөд авирч байсан бусад дөрвөн хүний хамт түүн уруу яаран хүрч очлоо.

Дугуйчинд нэг оюутан түрүүлэн хүрч, түүнийг болгоомжтойгоор дээш нь харуулахад уруул, хамар, эрүү, хөмсгөн дээрээ нэлээд хэд сүрхий зүсэгдэж бэртсэн байлаа. Өөр нэг оюутан гар угсаараа тусламж дуудав. Миний дэргэд зогсож байсан нэг залуухан ээж алчуур гарган өгч нэг оюутан цус гарч байгаа уруулыг нь арчлаа. Миний дэргэд зогсож байсан хоёр дахь эмэгтэй түргэн тусламжийн эмч нар ирэхийг сэтгэл зовнин хүлээнэ.

Хүнд бэртсэн дугуйчин нүдээ анивчсанаа нээж, түүнийг тойрон зогсож байгаа хүмүүсийн нүүрийг гайхан харж байлаа.

“Би хаана байна аа?” гэж тэр хэлэв. “Юу болсон юм бэ?”

Уруулыг нь арчсан алчуураа барьсан оюутан “Та оюутны хотхоны өмнө талд байна. Дугуй чинь эвдэрчээ” гэж хариулахад

дугуйчин ёолов. “Яасан их өвдөж байна аа. Туслаарай!” гэж тэр хэлэв.

Нөгөөх оюутан, түргэн тусламж

ирж яваа гээд залуугийн нэрийг асуув.

Тэр сулханаар “Давид” гэв. “Би хаана байна аа?” гэж тэр дахин асуулаа.

Костюм өмссөн профессор бололтой өөр нэг хүн Давид уруу хүрч очин адислал авах уу гэж түүнээс асуув. Тэр талархан толгой дохилоо.

Профессор дуугүй болов. Тэр эргэн тойрноо харснаа “Надад тос байдаггүй, яана аа.” Тэнд байсан хүмүүс толгой сэгсрэв. Бэртсэн залуу ёолоод халаас уруугаа сулхан дохив. Дэргэд нь зогсож байсан оюутан халаасанд нь гараа хийж, ариулсан тостой жижигхэн бортгыг гаргаж ирэн түлхүүрийн том оосорноос нь салгаж аваад,

“Түүнд тос байна!” гэж баярлан дуу алдав.

*Бэртсэн залуу ёолоод халаас уруугаа сулхан дохив. Дэргэд нь зогсож байсан оюутан халаасанд нь гараа хийж, ариулсан тостой жижигхэн бортгыг гаргаж ирэв.*

Профессор эрэгтэй оюутнуудын хамт дугуйчны толгой дээр гараа тавин адислал өгмөгц тэр тайвшрав. Профессор тэр залууд эдгэрэх болно гэдгийг амлаж, амар амгалан байхыг энэ явдлаас сургамж авч, Аврагчид улам ойртохыг хүсэхэд надад бас тайвшралын мэдрэмж төрөв.

Удалгүй түргэн тусламж ирж, дугуйчныг аваад явлаа. Дугуйчин тусламж хэрэгтэй хэн нэгнийг адислахаар ариулан адисалсан тосыг биедээ авч явсныг би хичээлд ирэхдээ ойлгосон. Гэвч өнөөдөр тэр өөрөө адислагдлаа. Бусдыг адислахын төлөө бас өөрсдийг нь адисалдаг Их Эзэний төлөө амьдардаг итгэлтэй хүмүүсийг хараад тэднийг хайрлах хайрын гүн гүнзгий мэдрэмж надад төрж билээ. ■  
Лиa МкКланахан, Юта, АНУ

# БОЛОВСРОЛЫН ХҮЧ

## Сюзи Тагги Коело Калдас Нелсен

Ээж минь, элбэг хангалуун амьдрал гэгчийг огт үзэлгүй, өлсгөлөн, ядуу тарчиг байдалд өссөн хүн. Ээж албан ёсны боловсрол олоогүй ч боловсролын үнэ цэнэ болон амьдралыг өөрчлөгч хүчийг нь мэддэг байсан. Надад хичээлийн дэвтэр хийх гэж цаасны өөдсүүдийг зүйж оёдог байхдаа ээж минь зөвхөн боловсрол л ядуу амьдралаас гаргана гэдгийг надад ой тойнд ортол ойлгуулсан юм.

## Даруухан эхлэл

Би хойд Бразилд төрөхдөө хугацаанаасаа гурван сарын өмнө төрсөн гэдэг. Гучин жилийн өмнө жоомоор дүүрсэн улсын эмнэлэгт гурван сар дутуу төрсөн нялх хүүхэд амьд үлдэх бараг л боломжгүй байсан аж. Эмч нар намайг “хүн болохгүй” гэж ээжид хэлсэн гэдэг. Гэвч би амьд үлджээ. Амьд мэнд үлдэхэд Их Эзэн надад тусалсан юм.

Намайг тав орчим настай байхад аав ээжийг маань таван хүүхэдтэй нь орхиж явсан. Ээжийг минь багад нь эцэг эх нь бас хаяж явсан болохоор түүнд туслах ойр дотны хүн байсангүй. Бидэнд байшин түрээслэх мөнгө байсангүй болохоор алга дарам газар түрээсэлж авлаа. Бид модны өөдөс, цаас, хуванцраар байшин

*Ээж минь надад  
хичээл номондоо  
шамдан суралцах  
хэрэгтэй яагаад гэвэл  
энэ нь ядуурлыг даван  
туулах нэг арга зам  
мөн хэмээн захидаг  
байлаа.*

барьж, хуурай навчаар дээврийг нь хийв. Хоёр, гурван хүн зэрэгцэж унтах орноос өөр тавилга гэх юмгүй, тэр ороо бид хэдэн зузаан цаасан хайрцаг задалж, нугалаад зассан юм. Бидэнд түгээгүүрийн ус, цахилгаан эрчим хүч, аль нь ч байсангүй. Бид үгээгүй ядуу байлаа.

Ээж минь гэрийн үйлчлэгч хийж, хүмүүсийн юмыг угаадаг байлаа. Би ээждээ чадах ядахаараа тусалж, гол уруу хамт явж, тэгээд бид угаасан хувцсыг эздэд нь хүргэж өгөхийн тулд хэдэн цаг явган явдаг байв. Ээжтэйгээ ийнхүү мөр зэрэгцэн хамт ажиллах нь надад туйлын сайхан байдаг байлаа. Ингэснээр ээжийгээ улам их хайрлан, ээждээ улам ойр дотно болсон юм.

Хэдийгээр бид шаргуу ажилладаг байсан ч бидэнд хэзээ ч хангалтай

мөнгө байдаггүй байлаа. Заримдаа гол зогоох юмгүй болно. Ээж минь өөрийнхөө идэх юмыг бидэнд өгчихөөд хэдэн өдөр хоол ундгүй явна. Заримдаа бид ус уучихаад унтаад өгнө. Энэ бол ходоод хоржигнохоос зайлсхийхийн тулд бидний хийж чадах хамгийн сайн зүйл байсан гээд бод л доо.

Нэг өндгийг зургаан хүн хэрхэн хувааж иддэгийг та мэдэх үү? Тийм ээ, би мэднэ.

Би бага байхдаа хэдхэн найзтай байлаа гэвч бид өсч том болоод өөр өөр замаар амьдралын мөр хөөсөн. Мөнгө олохын тулд охид биеэ үнэлж, хөвгүүд хулгай хийдэг байв. Тэд намайг өөрсөдтэйгөө нийлэхийг хүсэхэд энэ бол буруу гэдгийг би дотроо мэдэрдэг байлаа. Бүр Сүмийн гишүүн болохоос ч өмнө Их Эзэн намайг мэддэг байсныг би мэднэ. Одоог хүртэл өөрийн амьдрал дахь Түүний мутрыг би мэдэрсээр байгаа билээ.

## Юу ч болсон сургуулиа бүү хая

Би дүү нарынхаа хамт улсын сургуульд бүртгүүлэхийг удаан хугацаагаар хүлээсэн дээ. Тэгсээр сая нэг юм бүртгүүлэх боломж олдоход ээж сургуулийн тухай олон сайн зүйл ярилаа. Хэрэв боловсролдоо ул суурьтай хандвал намайг хүний



дайтай хүн болно гэж ээж хэлж билээ. “Чамайг сайн амьдралтай болгож чадаагүйг минь уучлаарай. Чамайг хар багаасаа амьдралын хатууг амсахаас аргагүй болгосны төлөө намайг уучлаарай харин одоо боловсролтой болох боломж чамд нээгдлээ. Юу ч болсон сургуулиа бүү хая. Учир нь энэ бол чамайг одоогийн амьдралаас чинь гаргах цорын ганц зүйл” гэж ээжийнхээ хэлсэн үгийг би хэзээ ч мартахгүй.

Би сургуульд орсон болохоор хичээлийн хэрэглэлээ яаж ийгээд олж авах ухаан сийлэх хэрэгтэй байлаа. Тиймээс хогийн саван дотроос цагаан цаасыг ялган түүж, гэртээ авчирдаг байв. Ээж цааснуудыг нийлүүлж оёод дэвтэр хийнэ. Ээж нэг харандаа худалдаж аваад гурав хувааж хоёр дүү болон надад хичээлээ бич гэж өгдөг байлаа. Өөр хоёр дүү маань сургуульд орох нас нь хүрээгүй байв.

#### Шинэ итгэл

Ээж минь насан туршдаа өдий их зовлон үзсэн болохоор Бурхан байдаг гэдэгт итгэдэггүй байлаа. Хүүхэд ахуй насандаа би ч бас тийм

*Ээж минь намайг гараар хийсэн дэвтэртэй, харандааны гуравны нэгийг өгөөд сургуульд явуулж билээ.*

л байсан. Гэвч арай том болсон үедээ би Бурханы тухай асуудаг болж билээ. Манай гэр бүл яагаад сайхан амьдарч чаддаггүй юм бэ? Яагаад надад тоглоом, хангалттай хоол унд, шинэ хувцас байдаггүй юм бэ? гэж би өөрөөсөө асуудаг байлаа. Эдгээр асуултуудыг асуух бүрд яагаад ч юм би ганцаар биш шүү дээ гэж зүрх сэтгэлдээ мэдэрдэг байлаа. Ийм бодол намайг олон жилийн турш тайтгаруулсан юм.

Намайг 13 орчим настай байхад Хожмын Үеийн Гэгээнтэн номлогчид манайд ирэв. Тэд миний бүх асуулганд хариулж, Есүс Христийн тухай заав. Миний насны хүмүүст зориулсан тусгай хичээлээр сайн мэдээний тухай илүү ихийг сурч болох сүм байгаа гэж тэд надад ярьсан юм. Тэд надад хэрхэн залбирахыг бас Мормоны Номын тухай заалаа. Намайг баптисм хүртэхэд манай гэрийнхнээс нэг нь ч ирсэнгүй.

Ганцаардлын мэдрэмж төрсөн ч зөв зүйл хийж байгаага би мэдэж байв. Шинэ амьдрал, найдвар, аз жаргал, итгэл хийгээд хайрын амьдрал намайг угтлаа. Миний үе тэнгийнхэн тайтгарлыг мансууруулах бодис, ёс суртахуунгүй хэргээс эрж хайдгийг би мэддэг байлаа. Харин би тайтгарлыг хайраар дүүрэн Тэнгэрлэг Эцэг болон Түүний Хүүгийн сайн мэдээнээс олдог байв. Их Эзэн миний бүх амьдралыг мэддэг болхыг би баптисмынхаа дараа мэдсэн.

Сайн мэдээний тухай их зүйл мэддэг боллоо. Итгэлийг минь хуваалцдаг хүмүүстэй танилцлаа. Гишүүдийн зарим нь надтай уулзахаар манайд ирэхдээ миний амьдралын тухай бага сага мэддэг болсон юм. Тэд надад сүмд өмсөх гутал хувцас, хичээлийн дэвтэр худалдаж авч өгөн өгөөмөр сэтгэл гарган туслав. Би Сүмийн гишүүдийн хүүхдийг



## ДАДЛАГА ЭЗЭМШ

“Ямар ч салбарыг сонголоо гэсэн Их Эзэн оюун ухаан, гар хоёрыг чинь сурган дадлагажуулахыг хүсдэг. . . . Хөргөгч засварчин байна уу, чадварлаг мэс засалч байна уу, ялгаагүй та нар өөрсдийгөө сурган, дадлагажуулж байх ёстой. . . . Та нар тэрхүү дадлагынхаа ачаар Сүмд нэр хүндийг авчирч, өгөөмрөөр адислагдах болно.”

Гордон Б.Хинкли, “A Prophet’s Counsel and Prayer for Youth,”  
Лиахона, 2001 оны 4-р сар, 34.

*Сувилахуйн хөтөлбөрөөр суралцахаар тэнцсэн үед зүрх сэтгэл минь талархал, баяр хөөрөөр дүүрч билээ. Золиослол хийх нь тэр тусмаа миний хувьд байнга золиослол хийх нь хэцүүг мэдэж байсан ч Их Эзэн надтай хамт байгааг би мэддэг байлаа.*



## ИНСТИТУТ

Та нар хаана боловсролтой болсон нь хамаагүй, дэлхий даяарх 500 гаруй шашны институтын аль нэгэнд бусад залуу насанд хүрэгчидтэй хамт суралцаж болно. Хамгийн ойрхон институтийг мэдэхийн тулд орон нутгийнхаа санваартны удирдагчидтай холбоо барих буюу [www.lds.org/institutes](http://www.lds.org/institutes) хаягаар лавлана уу.

харж, өмнө хэзээ ч олж байгаагүй их мөнгө олдог болов. Нас бага байсан болохоор сайн мэдээнээс холдон хөндийрөх нь миний хувьд амархан байж болох байв. Гэвч би Сүмийн гишүүдийн дэмжлэгтэйгээр шинэхэн олсон итгэлээрээ бат бөх байлаа.

Сайн мэдээ үнэхээр миний амьдралыг өөрчилсөн юм. Баптисм хүртсэнийхээ дараа сурах илүү эрч хүчтэй болсноо мэдэрсэн. Их зүйл сурч, цагийн багш боллоо. Хэрэв ямар нэг сэдвийг мэдэхгүй бол түүнийг зааж *чаддаг* болтлоо бүр

сайн судалдаг байв. Олсон мөнгөө гэрийнхэндээ зарцуулна.

Патриархын адислалаа авлаа. Их Эзэн миний номлолын талаар онцгой адислалыг хадгалсан байжээ. Энэ адислал миний амьдралыг эгнэгт өөрчилсөн юм. Тэрхүү онцгой адислал нь юу байсныг мэдээгүй ч хэрэв би дуулгавартай байвал үүнийг ойлгох болно гэдгийг мэдэж байлаа.

## Шинэ боломжууд

Би 2000-2002 онд Бразилын Куритиба Номлолд үйлчилсэн. Нэг хамтрагчийнхаа оролцоотойгоор Нэгдсэн Улсад явж суралцах боломж надад олдсон юм. Энэ миний амьдралыг эгнэгт өөрчилнө гэдгийг би

мэдсэн. Тэнгэрлэг Эцэг намайг мэддэг бөгөөд надад зориулсан тусгай төлөвлөгөө Түүнд бий гэдгийг би мэдсэн билээ. Миний боловсролд түлхэц үзүүлсэн энэхүү боломж залбирлын минь хариу байлаа.

Хоёр дахь хэл сурах нь амаргүй байж болох ч хэрэв шаргуухан хичээвэл боломжтой зүйл гэдгийг би мэдэж байлаа. Бригам Янгийн Их Сургуулийн Англи хэлний төвийн номын санд өдөрт 10 цаг суудаг байв. Манай багш нарын нэг нь хэлний бэлгийн төлөө залбирдаг байхыг бидэнд зөвлөдөг байсан учраас би орой бүр залбирч, энэ бэлгийг Тэнгэрлэг Эцэгээс гуйдаг байлаа. Тэр надад тусалсан нь тодорхой байлаа.

Англи хэлний төвийн хичээлээ дүүргэсний дараа би нэлээд хэдэн их сургуульд тэнцэв. Тэгээд Айдахо дахь Бригам Янгийн Их Сургуульд сувилахуйн хөтөлбөрөөр суралцахаар шийдлээ. Энэ хөтөлбөрөөр суралцах нь ялангуяа гадаадын оюутнуудад маш хүнд гэдгийг би сонссон. Тиймээс би тун шаргуу суралцсан. Ихэнх цагаа номын санд өнгөрүүлдэг болохоор найз нар маань намайг шоглож, номын санд нүүтээд орчихмоор юм даа гэдэг байж билээ. Номын сан хаагдсаны дараа гэртээ ирээд хичээлээ үзнэ.

Хүнд үе тулгарахад би Ерөнхийлөгч Гордон Б.Хинклийн (1910–2008) дараах үгсийг санадаг байлаа: “Чадах чинээгээрээ сайн боловсрол эзэмш. Машинаа золиосол; дэлхийн ажил хийхэд өөрийгөө тэнцэхээр болгоход шаардлагатай бүхнийг золиосол.”<sup>1</sup> Эдгээр үгс бол Бурханы бошиглогчийн үгс гэдгийг мэдсэн болохоор би үүнд буурь суурьтай хандсан юм.

Сувилахуйн хөтөлбөрөөр суралцахаар тэнцсэн үед зүрх сэтгэл

*“Ажил хийхэд өөрийгөө тэнцэхээр болгоход шаардлагатай бүхнийг золиосол.” Эдгээр үгс бол Бурханы бошиглогчийн үгс гэдгийг мэдсэн болохоор би үүнд буурь суурьтай хандсан юм.*

минь талархал, баяр хөөрөөр дүүрч билээ. Золиослол хийх нь тэр тусмаа миний хувьд байнга золиослол хийх нь хэцүүг мэдэж байсан ч Их Эзэн надтай хамт байгааг би мэддэг байлаа.

Сургуульд сурч байхдаа нөхөртэйгөө танилцаж, бид 2007 онд гэрлэв. Ээж минь мөн тэр жил Сүмд нэгдсэн. Бидэнд тохиолдсон хамгийн хүнд хэцүү үед ч намайг яагаад ийм их аз жаргалтай байдгийг ээж огт мэддэггүй байсан гэж надад ярьж билээ. Гэвч өөрөө Сүмд нэгдсэн хойноо ээж бүхнийг ойлгосон юм. Есүс Христийн сайн мэдээ манай гэр бүлийг адисалсан бөгөөд ээж минь хийсэн бүх золиослолынхоо дараа хэрхэн адислагдсаныг нь хараад би хэчнээн баяртай байсан гэвч. Ээждээ би үргэлж талархаж явах болно.

2010 оны эхээр би төгсөх шалгалтуудаа бэлтгэж байх үеэр жирэмсэн болж анхныхаа үрийг хэвлийдээ тээж явлаа. Сувилахуйн хөтөлбөрөө дүүргэхээс хоёрхон сарын өмнө жирэмсний хүндрэлийн улмаас манай анхны хүүхдийг мэс засал хийж төрүүлэв. Багш нар намайг чөлөө авч, дараа нь сургуулиа төгсөхийг зөвлөсөн ч, ердөө хоёр сар үлдээд байлаа!

Тиймээс сургуулиа төгсөхийн

тулд нөхөр бид хоёр хамгийн түрүүнд анхаарах зүйлсэд цаг хугацаа, хүч чармайлтаа төвлөрүүлэх нарийн хуваарь гаргаж мөрдөв. Хичээллэх хуваариа гарган нөхөр, хүү хоёртоо ч анхаарал тавих цагийг бас төлөвлөв. Заримдаа намайг хичээлтэй үеэр манай хадмууд хүүг минь хардаг байлаа. Ангийн хоёр найз маань хичээлийн материалуудыг нэгтгэн дүгнэхэд тусалдаг байлаа. Их Эзэн хүнд үед надад туслахын тулд эдгээр хүмүүсийг явуулсныг би мэдэрдэг, мэддэг байлаа.

### **Аз жаргалтай амьдрал**

Сургуулиа төгссөний дараа улсын магадлан итгэмжлэх шалгалт өгч, сувилагчаар ажиллан гэр бүлээ тэжээх болов. Энэ хооронд нөхөр минь сургуулиа дүүргэв. Миний нөхөр мэргэжлээрээ ажиллаж эхэлсэн болохоор би ажил хийх бодолгүй байгаа ч амьдралд зовлон бэрхшээл тохиолдох юм уу эдийн засгийн хямрал болж, би ирээдүйд ажиллах шаардлагатай боллоо гэхэд миний боловсрол туслах нь лавтай.

Боловсрол амьдралыг өөрчлөх *хүчтэй* гэж ээжийн хэлдэг зөв ажээ. Боловсрол намайг өөрчилсөн юм бас хүүхдүүдийн минь амьдралыг өөрчлөх болно. Их Эзэний төлөвлөгөөг дагасан учраас амжилтад хүрснийг минь хүмүүс мэдэх болно гэдэгт би итгэдэг. Их Эзэн намайг боловсролтой болохыг хүссэн юм. Тиймээс Тэрбээр энэ зам өөд хийсэн миний алхам бүрд тусалсан билээ. Хүүхдүүд минь над шиг суралцаж мөн миний адилаар боловсролын үнэ цэнийг ойлгоно гэдэгт би найддаг. ■

### **Эшлэл**

1. Гордон Б.Хинкли, “A Prophet’s Counsel and Prayer for Youth,” *Лиакхона*, 2001 оны 4-р сар, 34.

### **БОЛОВСРОЛТОЙ БОЛОХООР БЭЛТГЭХ НЬ**

**Б**ие дааж амьдрах чадвартай болоход нь хэрэгтэй боловсрол олж авах болон сургалтад хамрагдахад нь Сүмийн гишүүдэд туслах зорилгоор Боловсролын Тасралтгүй Санг (БТС) 2001 онд үндэслэн бий болгосон. Уг хөтөлбөрийн шаардлагыг хангасан Сүмийн гишүүд сургалтын төлбөрөө төлөхийн тулд зээл авдаг. Тэд ажилтай болсныхоо дараа зээлээ эргүүлж төлдөг. Хүсэлт гаргагч нь БТС-гийн зээл авахын тулд дараах шаардлагуудыг хангасан байх ёстой:

- Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн зохистой, идэвхтэй гишүүн байх. 19-26 насны ганц бие эрэгтэй хүсэлт гаргагчид нь буцаж ирсэн номлогчид байх эсвэл тэд хүндэтгэх шалтгаантай байх ёстой.
- Санваартны удирдагчаараа батлуулсан байх ёстой.
- Гэрлээгүй буюу 30-аас доош настай бол шашны институтэд элсч сурсан байх шаардлагатай.
- БТС батлагдсан оронд амьдарч, ажилладаг буюу сургуульд сурдаг байх. БТС-гийн зээлийг гишүүд 40 гаруй оронд авч байна.
- Сургалтын зардлаасаа аль болох ихийг өөрөө төлөхийг хичээж, сургуулиа төгсөөд илүү сайн ажилтай болж, зээлээ бүрэн төлөх шийдвэр төгс байх.

Хэрэв та БТС-гийн зээл авахыг сонирхож байгаа бол орон нутгийн санваартны удирдагчтайгаа холбоо барина уу. Уг хөтөлбөрийн тухай нэмэлт мэдээллийг [ref.lds.org](http://ref.lds.org)-т орж үзнэ үү.

## “Хүнд сорилтууд намайг илүү сайн болоход туслахаар өгөгдсөн үү эсвэл буруу замд орсныг минь анхааруулж байгаа Тэнгэрлэг Эцгийн сануулга уу гэдгийг би хэрхэн ялгаж таних вэ?”

**Х**эрэв та хүнд сорилтуудыг сүнслэг байдлынхаа өсөлт хөгжилтөд ашиглавал тэдгээр нь юунаас үүдэлтэй нь хамаагүй, улам сайжрахад чинь тусалж болно. Хэрэв та буруу замаар уруудаж байгаа бол ухамсар тань үүнийг өөрт чинь мэдүүлэх болно. Хийсэн ямар нэг зүйлийнхээ талаар сэтгэл таагүй байвал Тэнгэрлэг Эцэгт хандан залбирч, уучлал гуй. Ямар нэг асуудал төвөг удсан бол түүнийгээ засч залруулахыг хичээ. Бас эцэг эх, санваартны удирдагчдаас зөвлөгөө хүсч болно. Эдгээр алхмууд илүү сайжрах болон зөв замд ороход чинь тусална.

Нүгэд үл хүргэх сорилт бэрхшээл ч гэсэн илүү сайн хүн болоход чинь тусалж болно. Ийм сорилт бэрхшээл итгэл, тэсвэр хатуужлыг чинь сорьж, өөрийн чинь талаар чамд сургамж өгч болно. Эдгээр сорилтуудыг өсөлт хөгжилтийнхөө төлөө ашиглахын тулд тэдгээрээс ямар сургамж авч болохыг, улам сайжрахын тулд юу хийж болохыг өөрөөсөө асуу.

Хэрэв та Тэнгэрлэг Эцгээс тусламж хүсвэл итгэл тань сорилт бэрхшээлийн үед улам хүчирхэгжиж болно. Аврагч зовж шаналж байхдаа залбирсан шиг та “маш шаргуу” (Лук 22:44) залбирч болно. Тэнгэрлэг Эцэг сорилт бэрхшээлийг зайлуулж болно эсвээс үүнийг даван туулахуйцаар таныг хүчирхэгжүүлж болно (Мозая 24:14–15-ыг үз).

### Найз нөхөд, гэрийнхэн чинь тусалж болно



Намайг буруу замд орж уруудах үед Тэнгэрлэг Эцгийн намайг сэрэмжлүүлдэг нэг арга бол хувийн туршлагаа надтай хуваалцахад найз нөхөд, гэр бүлийн гишүүдэд Тэрбээр сүнслэгээр нөлөөлдөг явдал мөн. Тэднийг хувийн туршлагаа хуваалцах үед ямар нэг зүйлийн талаар буруутай юм шиг санагдах юм уу ямар нэг зүйлийг өөрчлөх хүсэл төрвөл би наманчлах буюу амьдралдаа өөрчлөлт хийх хэрэгтэй юм байна гэдгээ мэддэг.

Люис С., нас 17, Флорида, АНУ

### Зүрх сэтгэлээ шинж

Өөрийн чинь хийдэг зүйл Тэнгэр дэх Эцэг тань өөрөөс чинь хийхийг хүсдэг тэр зүйл мөн үү гэдгийг мэдэхийн тулд зүрх сэтгэлээ шинжиж бай. Сайнаас мууг ялган танихыг заадаг Ариун Сүнс бидэнд байдаг. Хэрэв та Бурханыг эрэлхийлж, Түүнээс асуувал юу хийх ёстойг чинь Ариун Сүнс харуулах болно. Сорилт бэрхшээл

өөрт чинь зааж байна уу эсвэл сэрэмжлүүлж байна уу ялгаагүй та үүнд итгэл болон Их Эзэнд найдах найдлагаар хариулбал өсч хөгжин, Христээр төгөлдөржихөд өөрт чинь туслах нэг л адил зорилготой юм.

Эмили Б., нас 18, Калифорни, АНУ

### Их Эзэн таныг тайтгаруулна



Аливаа сорилт бэрхшээлийг хүчирхэгжүүлэгч туршлага болгон хувиргаж, өөрийг чинь илүү сайн хүн болгох нь Тэнгэрлэг Эцэгийн зорилго мөн. Бүх зүйл та өөрөө сорилт

бэрхшээлд хэрхэн хандахаас шалтгаална. Зарим бэрхшээл сорилт даван туулахад хэтэрхий хүнд юм шиг санагдаж болно гэвч бидэнд итгэл байвал хэсэг хугацааны дараа тэдгээр нь биднийг адислах болно. “Би та нарыг өнчрүүлж орхихгүй. Би та нар уруу ирнэ” (Иохан 14:18) хэмээн Их Эзэн бидэнд хандан хэлсэн үгийг би үргэлж санахыг хичээдэг. Та энэхүү мэдлэгтэйгээр өөртөө тохиолдсон аливаа сорилт бэрхшээлийг даван туулж, улам хүчирхэг болон өсч хөгжих болно. Буруу замд орж уруудсаныг чинь Тэнгэрлэг Эцэг анхааруулж байна гэдгийг мэдэрсэн үедээ төмөр бариулаас чанга барихын тулд итгэлтэй байж, Сүнсний өдөөлтүүдийг сонс. Тэрбээр танд хайртай, насан туршид чинь таңд туслахын тулд чадах бүхнээ хийгээсэй гэж өөрөөс чинь үргэлж хүсэн хүлээж байдаг.

Оливия Б., нас 18, Миннесота, АНУ

### Энэ тухай эргэцүүлж бодоорой

Сорилт бэрхшээлийн зорилгыг мэдэх хамгийн сайн арга бол энэ талаар мацаг барьж, чин сэтгэлээсээ залбирах явдал гэж би боддог. Бас энэ тухай эргэцүүлэн бодохыг



хичээ. Та сорилт бэрхшээлийг даван туулсны дараа илүү сайн хүн болсон уу өөрчлөгдөлгүй хэвээрээ үлдсэн үү? Хэрэв сорилт бэрхшээлийг даван туулснаар та илүү сайн, аз жаргалтай хүн болно гэж бодож байвал та зөв зам дээр байгаа нь тэр.  
*Аммон К., нас 16, Юта, АНУ*

### Зөв зам дээрээ үлд



Бид судруудаа өдөр бүр уншиж, залбирч байх ёстой. Хэрэв бид юмсыг Ариун Сүнстэй хамт хийх юм бол Бурхан бидэнд ямар сонголтууд хийх болон хийх ёсгүйг мэдүүлэх болно. Хэрэв таны явж байгаа зам, Тэнгэр дэх Эцэг өөрийг чинь сонгоосой гэж хүсэн хүлээдэг тэр зам биш бол даруй эргэ. Нарийн бөгөөд давчуу зам дээр үргэлж үлд.

*Элизабет П., нас 15, Пеннсилвани, АНУ*

### Сорилт бэрхшээлээсээ суралцахын төлөө залбир



Тэнгэрлэг Эцэг амьдралын бүх үеийн туршид бидэнд сорилт бэрхшээлүүдийг өгдөг бөгөөд тэдгээр нь Түүний сайн мэдээнд итгэх бидний итгэлийг бэхжүүлдэг. Хэрэв бид буруу зам дээр байгаа бол энэ нь бидний хийсэн буруу сонголтын балаг юм. Бурхан өөрийг чинь хүчирхэгжүүлж, сорилт бэрхшээлийн сайн үр дагавар юу болохыг ялган танихад туслахын тулд Түүнд хандан үргэлж залбирч бай. Тэнгэрлэг Эцэгээс бидний зам дээр тавьдаг сорилт бэрхшээлүүд нь бидэнд сургамж өгч, гэрчлэлийг өсгөн нэмэгдүүлж дахин унахгүй байхад бидэнд болон бидний туршлагаар дамжуулан бусдад тусалдаг билээ.

*Радди Р., нас 17, Гвипас, Эквадор*

### Сорилт бэрхшээл сэрэмжлүүлэг болдог

Заримдаа бидэнд тэгж санагдаггүй ч сорилт бэрхшээл бүхэн биднийг хүчирхэгжүүлдэг гэж би боддог. Би 14-тэй байхдаа өвдөж, найман сар сургуульдаа явалгүй гэрээр хичээлээ үзсэн. Энэ сорилт намайг улам сайн, илүү хүчирхэг хүн болоход тусалсан юм. Энэ нь өөртөө байгаа юмсын төлөө талархалтай байхад надад тусалсан. Сорилт бэрхшээл нь зарим үед амьдралд хаана яваагаа эргэн харах боломжийг бидэнд олгодог бөгөөд тэдгээр нь сэрэмжлүүлгийн сайн хонх болдог.

*Женнифер П., нас 17, Умард арал, Шинэ Зеланд*

### Тэвчээртэй хүлээ

Хэрэв сорилт бэрхшээл нь аль нэг зарлигийг зөрчсөний үр дагавар бол энэ нь сэрэмжлүүлэг байж болно. Гэвч сорилт бэрхшээлүүд нь таны хяналтаас гадуур байвал тэдгээр нь өсч хөгжихөд чинь танд тусалж болно. Хэрэв энэ туршлагаас сургамж авч, ямар нэг юмыг өөрчлөх хэрэгтэй байвал та нар Тэнгэрлэг Эцэгт хандан залбирч, асуу. Энэ тохиолдолд чухам юу сурах хэрэгтэй вэ? гэдгийг өөртөө мэдүүлж өгөхийг Түүнээс гуй. Хүч

чадал, тайтгарлын төлөө залбир. Тэгээд тэвчээртэй хүлээ. Хариу нь удахгүй ирж байж болно.  
*Майкла П., нас 17, Айдахо, АНУ*



### АВРАГЧТАЙ ИЛҮҮ АДИЛХАН БОЛОХЫН ТУЛД

“Биднийг төгс хайрладаг Тэнгэрлэг Эцэг маань Христтэй илүү адилхан болоход бидэнд хэрэгтэй зан төлөвийн шинжүүдийг хөгжүүлэх боломжийг олгодог. Бидэнд тохиолддог сорилт бэрхшээлүүд олон хэлбэртэй байдаг бөгөөд ийм сорилт бүрээс ирдэг сайн зүйлийг танин мэдэж сурах нь Аврагчтай илүү адилхан болох боломжийг бидэнд олгох болно. Бид энэ сургаалыг ойлгосноор бидний Тэнгэрлэг Эцэгийн хайрыг илүүтэйгээр мэддэг. Бидэнд юу, яагаад тохиолдохыг бид энэ амьдралд хэзээ ч мэдэхгүй гэвч энэ туршлагаас өсч хөгжих болно гэдэгт итгэлтэй байж болно.”

Далын Ахлагч Жеймс Б.Мартинo, “All Things Work Together for Good,” *Лиахона*, 2010 оны 5-р сар, 101.

## ДАРААГИЙН АСУУЛТ

“Сайн мэдээгээр амьдрахын тулд хийх хэрэгтэй бүх зүйлийг хийнэ гэж бодохлоор дэндүү төвөгтэй юм шиг санагдах юм. Би юунаас эхлэх вэ?”

Хариултаа 2011 оны долдугаар сарын 15-ны дотор дараах хаягаар ирүүлнэ үү:

*Liahona*, Questions & Answers 7/11  
50 E. North Temple St., Rm. 2420  
Salt Lake City, UT 84150-0024, USA хаягаар шуудангаар явуулж болно.  
Эсвэл и-мэйл: [liahona@ldschurch.org](mailto:liahona@ldschurch.org)

Хариулын хэмжээг тохируулах болон тодорхой болгохын тулд хянан засварлаж болно.

И-мэйл буюу захидалдаа дараах мэдээлэл болон зөвшөөрлийг оруулна уу: (1) бүтэн нэр, (2) төрсөн он сар өдөр, (3) тойрог буюу салбар, (4) гадас буюу дүүрэг, (5) таны хариулт болон гэрэл зургийг нийтлэхийг зөвшөөрсөн өөрийн чинь бичгээр гаргасан зөвшөөрөл, 18 нас хүрээгүй бол, эцэг эхийн бичгээр гаргасан зөвшөөрөл (и-мэйл байж болно).

# Таны үлгэр жишээ

*Сайн мэдээгээр  
амьдрах нь зөвхөн  
таныг төдийгүй  
бас бусдыг  
хүчирхэгжүүлдэг.*

**А**роны санваартаа хүндэтгэлтэй ханддаг залуу эрэгтэйчүүдийг би гүнээ хүндлэн биширдэг. Африк дахь Кенийн Найроби гадасны гурван залуу эрэгтэйн тухай би та нарт ярья.

## **Мартин бат бөх итгэлтэй болсон нь**

Вестланд салбарын Мартин 14 настайдаа Найроби дахь гэрээсээ хол дотуур байртай сургуульд сурч байхдаа тэндхийн цорын ганц Сүмийн гишүүн байжээ. Мартины сургуульд долоо хоногийн зарим өдөр өглөөний хоолонд цай талх л өгдөг байж. 700 сурагчтай сургуулийн удирдлагад нэг хүнд зориулан тусгай цэс зохиох боломж байсангүй, тиймээс Мартин ус, талх авч байх болжээ.

Ням гарагуудад тэр бусад сурагчдын хамт сүмд явдаг байлаа.

## **Мартин**



# ЧУУХАЛ

Мартин тэнд шашны сургаалыг заримдаа мушгин гуйвуулдаг гэж боддог байсан ч очиж сонсдог байжээ. Хүмүүс түүний “хачин” итгэл бишрэлийн тухай үе үе дорд үзсэн өнгө аясаар ярьдаг байлаа. Заримдаа бүр түүнийг чөтгөрийг шүтэн бишрэгч гэж нэрлэдэг байв.

Эдгээр сорилтууд Мартины итгэлийг судруулсангүй харин бэхжүүлсэн ажээ. Аав ээж хоёр нь сар бүр эргэж ирдэг байсан нь мөн *New Era* сэтгүүлийн шинэ дугаарыг үргэлж илгээдэг салбарын ерөнхийлөгчийн захиас нь түүнд агуу урам дэм хайрладаг байлаа. Энэ сэтгүүлийг уншдаг байсан нь дээрх сорилтуудыг даван туулахад түүнд зориг нэмсэн ажээ.

## Жозеф огт тасалдаггүй

Рирута тойргийн Жозеф Аароны санваарын багшийн албан тушаалтай. Үе тэнгийнхнээс олон нь мансууруулах бодис болон бусад нүгэл хилэнцүүдэд оролцдог том сургуульд тэрбээр Сүмийн цорын ганц гишүүн ч гэсэн сайн мэдээнд итгэлтэй хэвээр байдаг ажээ. Жозеф сүмийн цуглаануудыг огт тасалж үзээгүй билээ. Тэр сүм дээр үргэлж эрт ирдэг, байнга цэвэр цэмцгэр явдаг бөгөөд чуулгын ерөнхийлөгч, бишоп нарын өгсөн үүргийг биелүүлэхэд үргэлж бэлэн байдаг. Бараг ням гараг бүр тэр ариун ёслолыг бэлтгэхэд тусалдаг байна.

## Хамфри даалгавраа шуудангаар явуулдаг

Аппер Хилл тойргийн Хамфри бол Сүмийн багшийн албан тушаалтай. Тэр ердөө хоёрхон жилийн өмнө баптисм хүртжээ. Хамфри Мартины адил дотуур байртай сургуульд явдаг. Түүний итгэл тийм их

өссөний нэг шалтгаан нь тэр Сүмд нэгдсэн цагаасаа хойш семинарын даалгавраа шуудангаар хүлээн авч, шуурхай хийгээд семинарын багшдаа шуудангаар явуулдаг байжээ.

Дотуур байртай сургууль хаагдахад Хамфри ням гарагт сүмд очихын тулд талдаа 45 минут явган явдаг байжээ. Гэсэн ч тэр сүм дээр ямагт эрт ирж, өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэхэд бэлэн байдаг гэнэ.

Хамфри үг хэлэх даалгавар авсан бол түүнд хичээнгүйлэн бэлтгэнэ. Түүний хэлсэн үгийг сонссон бүх хүнд тэр үгээ чамбай бэлтгэсэн нь тодорхой харагддаг ажээ.

## Жишгүүдээр амьдрах нь

Өнөөдөр дэлхийн ихэнх хэсэгт ёс суртахууны жишгүүдийг уландаа гишгэж байна. Ямар нэгэн сайн сайхан бөгөөд хүндэтгэлтэй зүйлсийг эрэлхийлдэг залуус үүнийг хаанаас олохоо мэдэхгүй байна. Ёс суртахууны жишгүүдийг хувь хүмүүс тогтоодог

## Жозеф



**Далын Ахлагч**

Жозеф В.Ситати



**Хамфри**

бөгөөд өөрчлөгдөн хувирч байдаг гэсэн хуурмаг санааг сургалтын байгууллагууд сурталчилж байна.

Гэвч та итгэлээрээ амьдарснаар, сайн мэдээнээс ирдэг тогтвортой байдал, өөртөө итгэх итгэл, амар амгалан, баяр баясгаланг гэрчлэхэд нь үе тэнгийнхэндээ тусалж чадна. Таны үлгэр жишээ сэргээгдсэн сайн мэдээний сургаалуудыг хүлээн авахад бэлтгэхэд нь бусдад тусалж чадна. Залуу эрэгтэйчүүдийн Бурханы өмнө хүлээсэн үүрэг, залуу эмэгтэйчүүдийн Хувийн Хөгжил дэвшил нь Бурханд улам ойр дотно болж өсч хөгжих болон насанд хүрэгчид, үе тэнгийнхний итгэлийг хүлээхэд тань тусалж чадна.

### **Төгс үлгэр жишээ**

Та залуу эрэгтэй, залуу эмэгтэй байна уу ялгаагүй, үе тэнгийнхэн болон эргэн тойрондоо байгаа бусад хүмүүстэй харилцаж амьдрахдаа санваарт хүндэтгэлтэй ханддаг бол Аврагчийг үнэнхүү дагаж байгаа нь тэр. Аврагчийн идэр насны амьдрал бол та нарын хувьд гайхамшигтай үлгэр жишээ мөн. Тэр дөнгөж 12-тойдоо Тэнгэрлэг Эцэгийнхээ ажилд оролцохын зэрэгцээгээр дэлхийн эцэг эхээ хүндэлдэг байв. Тэрбээр ариун сүмд хүмүүст зааж байсан тухай судрууд өгүүлдэг. Түүний сургаалын мэдлэг эрдэмд боловсорсон ахмад хүмүүсийн гайхлыг төрүүлж байлаа (Лук 2:42–52-ыг үз). Хэрэв бид Сүнснийг өөрсдөдөө байлгаж чадвал 12 нас

гэдэг сайн мэдээний гүнзгий зүйлсийг ойлгоход балчир нас биш гэдгийг Аврагч харуулсан юм.

Итгэлээрээ хүчирхэг, зоригтой байсан залуу хүмүүсийн өөр олон жишээ судруудад байдаг. Үүнд: Иаковын хүү Иосеф, Даниел, Нифай болон бусад олон хүн орно. Түүнээс гадна бид өнөө үеийн жишээ болгон хожмын үеийн бошиглогчид, төлөөлөгчдийг нэрлэж болно.

Аароны санваарыг сэргээсэн нь Тэнгэрлэг Эцэг Сүмийн залуу эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдэд итгэл хүлээлгэдгийн нотолгоо мөн. Тэрбээр Өөрийн хүүхдүүд, залуус болон ахмад хүмүүсийг адислахын тулд санваарыг ашигладаг байхыг залуу эрэгтэйчүүд та нараас хүсэн хүлээдэг. Та нар сайн мэдээг зааж, хүмүүст баптисм хүртээн, ариун ёслолыг гүйцэтгэн, өвчтэй болон зовж шаналсан хүмүүст туслан, гэр бүлүүдийг бэхжүүлэхийн тулд гэрээр нь очиж уулзан, бишоп буюу салбарын ерөнхийлөгчийн өгсөн үүрэг даалгаврыг биелүүлснээр санваараа ашиглаж байгаа нь тэр. Хүмүүс та нарын Аароны санваарын үйлчлэлээр дамжуулан өөрсдийг нь хайрладаг Тэнгэрлэг Эцэгийн хайрыг мэдэрдэг билээ. Мөн ийм замаар залуу эмэгтэйчүүд та нар ариун сүмд орохоор зохистой амьдарч, эргэн тойрон дахь хүмүүстээ үйлчилж, тусламж хэрэгтэй хүмүүсийг халамжлан, хүч чадал, авьяас билгээ хөгжүүлснээр Аврагчийн үлгэр жишээг дагаж чадна.

Санваарын эдгээр үүргүүддээ хүндэтгэлтэйгээр хандаж, эрхэмлэн дээдэлдэг залуу эрэгтэйчүүдийг би Сүмийн олон нэгжид харсан. Мөн бүх зүрх сэтгэлээрээ үйлчилдэг олон залуу эмэгтэйчүүдийг би харсан. Ийм үйлчлэл хийгээд үүнийг үзүүлдэг арга хэлбэр нь Бурхан Эцэгт болон Түүний Хүү, Есүс Христэд итгэх итгэлийг тань бэхжүүлдэг юм. Энэ нь бас та нарын үйлчилдэг хүмүүст итгэлийг төлөвшүүлэх болно. ■

## **ЖЮЛИЕТ БОЛ НАЙДВАРТАЙ ХҮН**

**З**алуу эмэгтэйчүүд та нар залуу эрэгтэйчүүдийн адил сайн мэдээгээр амьдарснаар мөн тийм үлгэр жишээг үзүүлж чадна. Та нар хувийн хөгжил дэвшил дээрээ ажилласнаар өөрсдийгөө Бурханы охид гэдгээ мөн Тэнгэрлэг Эцэг та нараас юуг хүсэн



хүлээдгийг мэдэхэд туслах зарчмуудыг ойлгож мэдэх болно.

Тийм үлгэр жишээний нэг нь Жюлиет юм. Вестланд салбарын гишүүн Жюлиет Сүмд хүүхэд байхдаа баптисм хүрсэн ажээ. Тогтмол орлогогүй, өрх толгойлсон эх нь түүнийг хүнд нөхцөл байдалд өсгөн хүмүүжүүлсэн ч Жюлиет өндөр жишгүүдийг баримталдаг байсан нь сургуулийн удирдлагуудад гүнзгий сэтгэгдэл төрүүлж, түүнийг сургуулийнхаа тэргүүний охин болгожээ. Тэр сургуульдаа хамгийн их итгэл хүлээсэн сурагч юм.

Сайн мэдээний жишгүүдээр амьдрах нь санваарт хүндэтгэлтэй хандаж байгаа хэрэг гэдгийг Жюлиет мэддэг ажээ. Санваарт хүндэтгэлтэй ханддаг залуу эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд Бурханы болон хүмүүний таашаалыг хүлээж чадна гэдгийг түүний үлгэр жишээ харуулж байна.

# Сургаал ба Гэрээ

## 121:41–43

*Санваарын эрх мэдлийг Их Эзэний арга замаар хэрхэн ашиглахыг Иосеф Смит заасан юм.*



### Сэнхрүүлэл

Сэнхрүүлэл гэдэг нь гуйх буюу тайлбарлах аргаар бусдыг ямар нэг зүйлд итгүүлэн үнэмшүүлэх явдал мөн.



### Тэсвэр тэвчээр

*Тэсвэр тэвчээр* бол тэвчээр хатуужил юм.

“Их Эзэн бидэнд яаж тэвчээртэй хандаг шиг бид үйлчилдэг хүмүүстэй тийм тэвчээртэй хандъя. Тэд бас бидэн шиг төгс биш гэдгийг ойлгогтун. Тэд мөн бидэн шиг алдаа гаргадаг. Тэд бусад хүмүүсийн эргэлзээ тэдэнд ашигтай байхыг яг л бидэн шиг хүсдэг.

“Хэнд ч хэзээ ч бүү бууж өг. Энэ нь бас өөртөө бууж өгөхгүй байх явдал юм.”

Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх, Ерөнхийлөгч Диетер Ф.Угдорф, “Continue in Patience,” *Лиахона*, 2010 оны 5-р сар, 58.

### Эелдэг зөөлөн хийгээд номхон дөлгөөн байдал

Эелдэг зөөлөн хийгээд номхон дөлгөөн байдлын тухай судрууд зарим зүйлийг бидэнд заасан байдаг:

- Эдгээр шинж чанар бол Сүнсний үр жимс мөн (Галат 5:22–23-ыг үз).
- Эелдэг зан бол Их Эзэний үйлчлэгчдийн шинж мөн (1 Тесалоник 2:7; 2 Тимот 2:24-ийг үз).
- Номхон дөлгөөн хүмүүс дэлхийг өвлөнө (Дуулал 37:11; Матай 5:5-ыг үз).

**С ба Г 121:41 Хүч буюу нөлөө нь санваарын ариун журмаар төдийгүй гагцхүү сэнхрүүлээр, тэсвэр тэвчээр, эелдэг зөөлөн хийгээд номхон дөлгөөнөөр тэтгэгдэж чадах буюу байх ёстой ажгуу;**

**С ба Г 121:42 Нинжин сэтгэл, мөн цэвэр мэдлэгээр энэ нь зусардалтгүйгээр мөн заль мэхгүйгээр оюун санааг агуу ихээр өргөжүүлэн тэлдэг буюу—**

**С ба Г 121:43 Ариун Сүнсээр хөдөлгөгдсөн үед хурц тодоор, цагаа олж шүүмжил; мөн тэрээр чамайг дайснаа гэж үзэхгүйн тулд тэгээд та нар шүүмжилсэн түүнийг хайрлах хайраа дараа нь нэмэгдүүлснээ харуул.**

- Номхон дөлгөөн зан бол Христэд итгэх итгэлийн шинж мөн (Моронай 7:39-ийг үз).
- Номхон дөлгөөн зан Ариун Сүнсний айлчлал уруу хөтөлдөг (Моронай 8:26-г үз).

### Чин сэтгэлийн хайр

*Чин сэтгэлийн* гэдэг нь жинхэнэ, хувирдаггүй, хуурамч биш гэсэн утгатай.

Хэн нэг нь саяхан танд чин

сэтгэлийн хайраа харуулсан уу? Ийм хайрыг та бусдад хэрхэн харуулж болох вэ? Энэ тухай тэмдэглэлдээ бич.

### Зусардалтгүйгээр мөн заль мэхгүйгээр


*Зусардалт* гэдэг нь өөрийнхөө үнэн байдлыг нуусан дүр эсгэлт юм. *Заль мэх* бол хуурах, залилах явдал мөн.

### Цагаа олж, хурц тодоор шүүмжлэх нь

*Шүүмжлэх* гэдэг нь зэмлэх, эелдэг зөөлнөөр залруулах, сайшаахгүй байгаагаа илэрхийлэх явдал мөн.

*Цагаа олж* гэдэг нь түргэн, тэр даруйд, хожимдохоос өмнө гэсэн утгатай.

*Хурц тод* гэдэг нь тодорхой гэсэн үг юм.



### Ариун Сүнсээр хөдөлгөгдсөн үед

“Сүнсэлэг нөлөө бүхий, хайр дээр үндэслэсэн шүүмжлэл нь эв нэгдлийн урилга болж чадна. Ариун Сүнсээр хөдөлгөгдсөн үед эв нэгдлийн урилгыг өгч чадахгүй бол зөрчил сөргөлдөөнд хүргэнэ.

Тэргүүн Зөвлөлийн нэгдүгээр зөвлөх, Ерөнхийлөгч Хенри Б.Айринг, “Be One,” *Лиахона*, 2008 оны 9-р сар, 6.

*Редакторын тэмдэглэл: Энэ хуудас бол сонгосон судрын шүлгийн бүх талыг хамарсан тайлбар биш зөвхөн өөрийн тань судалгааны эхлэх цэг юм.*

# АРИУН ОЙН ЦООРХОЙ



ГЭРЛЭ ЭХРИЙГ ЖОН ТӨЛӨӨРД

Дэлхийг өөрчилсөн ямар үйл явдал энд болсон бэ? Энэ таны амьдралыг өөрчлөг.

# СҮНСНИЙ ТЭМДГҮҮД

Педро Оваллес

**Б**и Бүгд Найрамдах Домникан Улсад бүрэн цагийн номлолд үйлчилж байгаа бөгөөд саяхан заах хүмүүс олоход төвөгтэйгөөрөө нэрд гарсан нэг бүсэд шилжиж ирээд байна. Намайг энд ирэхэд бид ердөө ганцхан сонирхогчтой байлаа. Түүний нэр Оривиадес. Тэр өмнө нь сүмд явж байсан ч дохионы хэлээр харилцдаг дүлий учраас номлогчид заах боломжгүй байсан гэнэ.

Нэг өдөр хамтрагч бид хоёр Оривиадест заах боломжийг бидэнд олгох гайхамшгийн төлөө мацаг барьж, залбирахаар шийдэв. Хамтрагч бид хоёр дохионы хэл мэдэхгүй болохоор гэр бүлийн гишүүдийнх нь нэг нь орчуулахад туслах тохиромжтой цагийг олж тохиров.

Гэвч биднийг Оривиадестай уулзахаар иртэл гэр бүлийнх нь гишүүдээс хэн нь ч байсангүй. Оривиадесыг сандал авчрахаар түр зуур гарах хооронд хамтрагч бид хоёрт Сүнс биднийг удирдахын төлөө залбирах боломж гарав. Бүр залбирахаасаа өмнө би Сүнсийг хүчтэй мэдэрс билээ.

Оривиадес дохионы хэлээр ярьж эхэлсэн ч бид түүнийг ойлгосонгүй. Бид хоёр зүгээр л түүнийг болон бие биеэ хараад инээмсэглэн, яах ёстойгоо таамаглах гэж оролдов. Бид дараагийн удаа орчуулагчтай болно гэдэгт найдан уулзах цагаа цаасан дээр бичиж түүнд харуулъя гэж шийдлээ. Гэвч бид эндээ үлдэж, түүнд заах гэж оролдоод үзэх хэрэгтэй гэсэн хүчтэй мэдрэмж бидэнд



төрлөө. “Сүнс бидэнд бага ч гэсэн туслахын төлөө хичээгээд үзье” гэж би хамтрагчдаа хэллээ.

Бид хичээлээ зураг ашиглан, гараараа болхидуухан дохио зангагаар заах гэж оролдов. Бид хоёр Оривиадесын дохионуудыг алгуураар ойлгодог болж, хариу дохиж чаддаг болов. Тэр биднийг маш сайн ойлгож байгаа бололтой.

Бид түүнтэй гэрчлэлээ хуваалцах хэрэгтэй хэмээн өдөөгдөв. Тэгээд Анхны Үзэгдлийн зургийг түүнд үзүүлээд, “Үүнийг үнэн гэдгийг би мэднэ” гэж цаасан дээр бичлээ.

Дараа нь Оривиадес, “Бурхан надад хэлсэн—энэ нь үнэнийг би мэднэ. Би залбирсан энэ нь үнэнийг би мэднэ” гэж хариулав.

Хамтрагч бид хоёр нүд дүүрэн нулимстай энэ уулзалтыг өндөрлөлөө. Сэргээгдсэн сайн мэдээний тухай энэ сонирхогчид гэрчлэх боломжийг Бурхан бидэнд олгосон бөгөөд Ариун Сүнс бидний захиасыг түүний зүрх сэтгэлд хүргэснийг би мэднэ (2 Нифай 33:1-ийг үз). Бид зарим үед сайн мэдээг хуваалцахдаа төгс байдлаар эсвэл уран цэцнээр ярих хэрэггүй юм байна, заримдаа ерөөсөө ярих ч хэрэггүй юм байна гэдгийг мэдсэн.

Мацаг барих, залбирах болон итгэл зэрэг энгийн зүйлс бидэнд болон бидний үйлчилж байгаа хүмүүсийн амьдралд хэрхэн гайхамшгуудыг үйлдэж болдог нь үнэхээр гайхалтай билээ. ■

# Загасчлахыг ХҮМҮҮНД Заа

## Адам К.Өүлсон

Сүмийн сэтгүүлүүд

Эзра шурагт бяцхан завиа сэлүүрдэхээ больж, Номхон Далайн булангийн нөгөө талд жаргаж байгаа нарыг харлаа. Тэр олон жилийн турш энд аавтайгаа загасчилсан ч өнөөдөр танил газраа нулимстай нүдээрээ ширтэн явлаа.

Өнөөдөр тэр ганцаараа иржээ.

Сэлүүрт завь усан дээр зөөлхөн хайргадахад “Анхааралтай хараач, Эзра. Нэг л өдөр намайг хадан гэртээ харихаар чи гэр бүлээ яаж тэжээхээ мэддэг байх хэрэгтэй болно” гэсэн аавынхаа үгийг тэр сонсох шиг болжээ.

Өнөөдөр аавынх нь түүнд анхааруулж захисан бас түүнийг бэлтгэдэг байсан тэр өдөр нь иржээ. Харин энэ өдөр хэтэрхий хурдан ирсэн аж. Тэр дөнгөж 16-тай байлаа. Тэр үүнд бэлэн биш байв.

## Үүрэг хариуцлага

Эзра ааваараа бахархан биширдэг ажээ. Эзра долоон настайгаасаа загасны тороо усанд тавьж, загас орсон эсэхийг шалгахад нь аавдаа тусалж чадахуйц насанд хүрэхийг олон жил тэсч ядан хүлээсэн ажээ.

Загасчлахаас төдийлөн их мөнгө олдоггүй ч олсон мөнгө нь Эзраг, таван эмэгтэй дүү, ээжийнх нь хамт тэжээх болон Нэгдсэн Улсад номлолд үйлчилж байсан эгчийг нь дэмжихэд, тэрчлэн хөршүүдэдээ илүүчлэн туслахад хангалттай хүрдэг байлаа. Тэр ч байтугай Эзра өөрийнхөө номлолд зориулан мөнгө хадгалах боломжтой байжээ.

Гэвч аав нь өөд болчихлоо. Аав нь зуурдаар нас барахад Эзрагийн зүрх шимшрэн, уй гашууд автжээ. Аавыгаа алдсан нь түүний хувьд бишрэн шүтдэг баатрыгаа,

бишопоо, халамжлан хүмүүжүүлэгчээ алдсантай адил байлаа.

Гэтэл энэхүү уй гашуу дээр аав нь түүнийг бэлтгэхийг хичээж байсан гэр бүлээ тэжээх үүрэг хариуцлага гэнэт түүн дээр ирснийг ухаарах нь бүр ч аймаар байв. Эзра одоо гэр бүлээ тэжээх хэрэгтэй боллоо.

## Залбирал

Тэр аавыгаа өөд болсны дараах долоо хоногт загасчлахыг ч бодсонгүй. Сэтгэл санаа нь дэндүү тавгүй байв. Аавынхаа завийг авах, торыг нь хэрэглэх, ажлыг нь түүнгүйгээр хийх нь дааж давшгүй мэт санагдсан гэнэ.

Дараагийн долоо хоногт загасчлахаар явах нь гэр бүлд нь хэрэгтэйг мэдсэн ч маш хүнд санагдаж байлаа. Эзра аавтайгаа адилхан байхыг хэдийчинээ хүсэх тусам, зорилгодоо хүрэх нь мөн ч хол байгааг улам илүү ойлгожээ.

“Үнэндээ найдвар байхгүй юм шиг л санагдаж байсан шүү. Аавынхаа мөрөөр анх удаа алхах нь хэцүү байлаа. Сэлүүрт завиа далай уруу гаргах үед аав минь дэргэд байх шиг санагдлаа. Аавын минь надад хэлдэг байсан үг сонсогдох шиг болж, гэр бүлийнхээ төлөө хүлээх хариуцлагын хүндийг мэдэрч билээ” гэж тэр яриу.

Тэрбээр Номхон Далайн гүехэн усан дотор зогсоод, Түүнд итгээрэй гэж аавынхаа захисан өөрт нь тусалж чадах тэр Хүнд хандлаа.

“Аавын минь зогсдог байсан газрыг надад үзүүлээч. Аавын минь захидаг байсан зүйлийг биелүүлэхэд надад туслаач” хэмээн Эзра залбирлаа.



*16 настай самуа залууд тусламж хэрэгтэй болсон үед тэр аавынхаа зааснаар Тэнгэрлэг Эцэгтээ хандсан гэнэ.*



**Эзра найз Фетюгийн хамт загасны тороо аваад сэлүүрт завиндаа буцаж ирэв.**

### **Залбирлын хариу**

Тэрхүү залбирлын дараа оройн нам гүмхэнд Эзра нэгэн өөрчлөлтийг мэдрэв. Тэр аавынхаа загасчилдаг байсан газар уруу хөтлөгдөж байгаага мэдэрэхэд аавынх нь заадаг байсан зүйлс санаанд нь орж ирлээ.

“Залбирлын дараа би илүү их хүч чадалтай болсноо мэдэрсэн. Тэнгэрлэг Эцэг надад тусална гэдгийг би мэдсэн” гэж тэр хэллээ.

Аврагч эртний Төлөөлөгчдөд загасны тороо хаана хаяхыг үзүүлсэн шиг тусламжийг Эзра бас хүлээн авчээ. “Тэр өдөр би олон загас барьсан шүү” гэж тэр хэлэв.

### **Эцэг нь ямар бол хүү нь тийм**

Эзра аавынхаа хийдэг байсан зүйлсийг хийж чадна гэдэгт эргэлзэж байсан ч бодсоноосоо хавьгүй илүү зүйлийг хийж чадах юм байна гэдгээ мэдсэн ажээ.

“Миний бодож сэтгэх, юмсыг ойлгож, хийх арга барил, амьдралд их өөрчлөлт гарсан. Аавынхаа хийдэг зүйлсийг хийж чадах юм байна гэдгийг би ойлгосон” гэж Эзра ярилаа.

Эзра өөрийнхөө бодож байснаас хавьгүй илүүгээр аавтайгаа адилхан болжээ. Тэрбээр загасчны хувьд бас багшийн хувьд аавынхаа мөрөөр замнаж явна.

Эзраг загасчлахаар явсан хоёр дахь долоо хоногт найз Фетю нь түүнтэй хамт явж загас барихыг сурч болох уу гэж асуусан гэнэ. Эзра загас хэрхэн барихыг Фетюд зааж, Фетю түүний ажилд туслан, хамт байжээ.

“Аав надад заадаг байсны адилаар бусад хүмүүст заах боломж надад олдсонд би баяртай байна. Би аав шигээ зөвхөн загасчин төдийгүй бас багш болсноо мэдээд их баярласан шүү” гэж Эзра хэллээ.

### **Хүнд загасчлахыг заа**

Хэрэв та хүнд загас өгвөл түүнийг нэг өдрийн хоолтой залгуулж байгаа хэрэг харин түүнд загасчлахыг зааж өгвөл насных нь хоолтой болгож байгаа хэрэг гэсэн зүйр үг байдаг. Эзрагийн аав хүнд загасчлахыг заадаг байсан нь тодорхой байна.



*Эзра номлолд үйлчлэхээр төлөвлөж байна. Тэнгэрлэг Эцэг түүний залбиралд хариулсныг тэр санадаг. “Тэрбээр намайг дуудсан үед би хариулах боломжтой байхыг хүсдэг” гэж Эзра хэллээ.*



**Эзра гэр бүлээ тэжээх хариуцлага ноогдсоны дараа “Эхний үед гэр орноо аавынхаа дайтай авч явах нь хэцүү байсан шүү” гэв.**

Харин Эзра загасчлахаас хавьгүй илүү их зүйлийг ааваасаа сурсан ажээ. Тэнгэрлэг Эцэгтээ найдаж болохыг тэр мэдсэн гэнэ. Энэхүү мэдлэг нь түүнд насан туршид нь бүр загасчлах чадвараас нь илүү сайнаар үйлчлэх болно.

Тэнгэрлэг Эцэгийн тусламж түүнд хэчнээн их хэрэгтэйг Эзра мэддэг учир, аав нь нас барахаасаа долоо хоногийн өмнө түүнийг томилсон пристийн албан тушаалынхаа үүргийг зохистойгоор биелүүлэхийг хичээдэг ажээ. Тэр бас загасчлах ажлаа сургууль, семинарын хичээлтэй давхцуулахгүйгээр хуваарь гарган зохицуулдаг байна.

Эдүгээ загасчлах нь түүний хувьд мөнгө олох арга хэрэгсэл байгаа бол хэзээ нэгэн цагт тэр хүмүүсийн загасчин болно хэмээн тэр өгүүлэв (Матай 4:19-ийг үз).

“Гэр бүлийн нэг үдшийн үеэр аав биднийг бүгдээрээ номлолд үйлчлээсэй гэсэн бодолтой байдгаа хэлж билээ. Энэ бол миний эрхэм дээд зорилго” гэж Эзра хэллээ.

Түүнийг дуудагдах үед Их Эзэн залбиралд нь хариулсныг Эзра санадаг ажээ. *Тэрбээр намайг дуудсан үед би хариулах боломжтой байхыг хүсдэг.* ■

# УСАН СЭЛЭЛТЭЭС би юу сурав?

*Үе тэнгийнхэн бүгдээрээ муу нөлөө үзүүлдэггүйг усан сэлэлт надад заасан юм.  
Заримдаа энэ нь амжилт гаргахад тусалдаг.*

## Марисса Томпсон

**Б**и долоотой байхдаа яаж сэлдгийг мэддэггүй байлаа. Иймээс ээж намайг найз Аанжитай хамт усан сэлэлтийн дугуйланд явуулж билээ. Хичээл бүрийн төгсгөлд манай багш биднийг сэлэлтийн дасгал хийлгэхээр усан сангийн гол хэсэгт аваачдаг байлаа. Манай багш биднийг гэдсэн доороос тулж бид нуруундаа “хөөсөнцөр” бэхэлдэг байсан учир цөөрмийн голд аюулгүй байдаг байлаа.

## Усан санд үе тэнгийн охины үгийг дагасан нь

Нэг өдөр Аанжи бид хоёрт хөөсөнцөр байсангүй тиймээс бид хоёр усанд оролгүй бие биеэ налан зогсож байлаа. Аанжи зэргэлдээх хананы булан хүртэл 1.2 метр зайд сэлээд үзэхээр шийдэв. Би эхлээд эргэлзсэн ч тэр намайг зоригжуулав. Тэгэхлээр нь би хэдийгээр айсан ч чадахаараа их агаар амьсгалж аваад нөгөө талд сэлээд хүрчихэж чадна гэж бодоод ус уруу орлоо. Нуруун дээрээ хөөсөнцөртэй үед усан дээгүүр хөвдөг шигээ хөвөх юм байх гэж бодсон чинь харин живж эхлэх нь тэр. Айж сандран, живж байгаага мэдлээ. Тэгтэл манай багш хэдэн долоо хоногийн өмнө “Хэрэв сэлж байхдаа хяналтаа алдвал нэг гараа уснаас ил гарган дээш өргө, тэгвэл хэн нэг нь туслахаар ирнэ” гэснийг санав.



Үүнийг санаад би энэ л дээшээ болов уу гэж бодсон зүгт гараа өргөлөө. Агаар огт байхгүй юм шиг санагдлаа. Аль зүг дээр байгааг мэдэхгүй гараа тал тал тийш нь сунгаж үзлээ. Тэгтэл би толгойгоороо усан

сангийн хана мөргөв. Аанжи тэнд намайг хүлээж байжээ. Намайг живэх шахсаныг тэр мэдээгүй бололтой.”

Хэдэн долоо хоногийн дараа би гэрийхэнтэйгээ нууран дээр очлоо. Би усанд яаж сэлдгийг мэдэхгүй хэвээр байсан болохоор гүехэн усан дотор л эргэлдэж байв. Тэнд очоод 10 орчим минут болоод байтал нэг найз маань нуур уруу явж байхыг харлаа. Би ичсэндээ балмагдав. “Намайг сэлж чаддаггүйг Стефани мэдчихвэл яана аа?” гэж бодохоос ичих шиг болов. Тэгээд би тэр даруй өвдөг дээрээ сөхөрч сэлж байгаа юм шиг дүр үзүүлж, хөлөөрөө ус өшиглөн, хоёр гар дээрээ усан дотор тулан явж эхлээд. Стефани ус уруу үсрэн орж, сэлж эхлэв. Үүнээс болж би бүр ч их ичлээ. Хэсэг хугацааны дараа тэр хүрч ирэн надтай ярилцлаа. Тэгээд тэр намайг орхичихоод өөр чиглэлд төгс, өөгүй сайхан сэлээд явчихлаа. Сэлж байгаа дүр үзүүлж, нүд хуурсан нь юу гээчийн тэнэг хэрэг вэ гэж дотроо бодов.

Хэдэн хором өнгөрсний дараа айхаа больж сэлээд үзье гэж шийдэв. Би гүехэн усан дотор байсан болохоор газар дээрээс гараа дээш өргөж, нохойчлон сэлж үтэл болж байна шүү. Усан дээр хөвөн гарч ирлээ. Хэдхэн секунд л болсон байх



би хөвж байв. Тэгээд оройжингоо дахин дахин үүнийгээ давтан хийлээ. Биднийг буцах үед би нуурын нэг эргээс нөгөө эрэгт сэлэн хүрч чаддаг болов.

### Үе тэнгийхний нөлөө хүчтэй байдаг

Дээрх хоёр явдлыг эргэн бодоход үе тэнгийхний нөлөөний хүчийг би гайхдаг. Эхний удаа үе тэнгийн охины нөлөө намайг живүүлчих шахсан ч дараагийн удаа намайг сэлж сурахад өдөөн түлхсэн юм. Энэ нь үе тэнгийхний нөлөө сайн ч бай, муу ч бай үргэлж хүчтэй байдгийг харуулж байна.

Үе тэнгийхний дарамт шахалт нь Фарисайчууд Христийн үгсэд итгэхгүй байсны нэг шалтгаан бас болж байжээ “Тэд хүний алдрыг Бурханы алдраас илүү таалсан юм” (Иохан 12:43). Агуу хийгээд нүсэр барилгаас тэднийг шоолон, хуруугаараа зааж байсан хүмүүсээс болж Их Эзэнээс ичсэн хүмүүсийг Лихай зүүдэндээ харсан билээ (1 Нифай 8:26–28-ыг үз).

Хүмүүсийг зөв гэж бодсон зүйлээс нь эргүүлдэг өсвөр насныхны нэг нэгэндээ үзүүлдэг муу нөлөөг би мэднэ. Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн жишгүүдээс болж хүмүүс намайг шоолж байлаа. Хувцас хулгайлахыг, шалгалтандаа хууран мэхлэхийг, бусад хүмүүстэй бүдүүлэг харьцахыг хүсдэг найз нар надад

байсан. Тэд намайг усанд амжилттай сэлж сураасай гэж хүсэхийн оронд намайг доош нь түлхэж, живүүлэх зангуу байхыг хүсдэг.

Гэвч намайг сайн юмс хийхэд амьдралыг минь муутгах биш, өөд татах юмс хийхэд өдөөн түлхдэг найз нар бас надад бий. Намайг наймдугаар ангид байхад миний найз Али дараагийн хичээлийн жилд эмэгтэйчүүдийн маршийн багт оролцохыг ятгасан юм. Энэ нь тун

амаргүй байлаа. Учир нь би ахлах сургуульд шинэхэн ирсэн болохоор уг үйл ажиллагаанд оролцоно гэхээс айдас хүрдэг байж билээ. Али үүнийг хэрэгтэй юм гэж надад итгүүлж, найзын хувьд урам дэм өгөөгүй бол би тэр үйл ажиллагаанд хэзээ ч оролцохгүй байсан биз ээ. Үе тэнгийхний энэхүү нөлөө ахлах сургуулийн амьдралд дасан зохицоход надад маш их тусалсан билээ.

Ахлах сургуульд сурч байхад дараа нь коллежид сайн найз нар надад нөлөөлж, намайг оюутны зөвлөлд орж ажиллах, дүнгээ ахиулахын төлөө хичээн чармайх, сайн мэдээний тухай гэрчлэлээ өсгөн нэмэгдүүлэхэд өдөөж, урам дэм хайрласан юм. Эдгээр найз нар амьдралд минь сайн нөлөө үзүүлсэн билээ. Тэд намайг амжилтад хүрэхийг хүсч, өсч хөгжихөд минь тусалсан юм.

Олон хүний боддог шиг, үе тэнгийхэн бүгдээрээ муу нөлөө үзүүлдэггүйг дээрх туршлагууд надад харуулсан. Нөлөө чухам хэнээс ямар хэлбэрээр ирж байгаад л хэргийн учир оршино. Миний эргэн тойронд сайн нөлөө байгаа үед дэлхийн зам уруу хальтиран орох магадлал бага байдгийг би мэдсэн. Сүм болон өндөр жишгүүдээр амьдардаг найз нөхдийн сайн нөлөө нь усан дээр хөвөх боломжийг надад олгодог байсан нуруундаа бэхэлсэн хөөсөнцөр лүгээ адил юм. ■



**А**в минь талийгаач болохоосоо өмнө надад Христийн мэндэлсний баярын нэгэн онцгой бэлэг өгсөн. Энэ бол бяцхан мөнгөн хонхтой хүзүүний зүүлт. Энэ зүүлт Сүнсийг үргэлж сонсож, цэвэр ариун байхыг надад сануулсан юм. Энэ бол надад үнэт эрдэнэс билээ.

# Их Эзэнд ИТГЭ

**Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгч Элайн С.Далтонтой Меган Витерс Роксасын хийсэн ярилцлагаас**

*“Бүх зүрхээрээ ЭЗЭНД итгэ”  
(Сургаалт Үгс 3:5).*

**Б**и бяцхан охин байхдаа ааваасаа салдаггүй хаашаа л явбал дагаж явдаг байлаа. Аав маань Их Эзэнд бие сэтгэл бүхнээ хэрхэн зориулсныг хараад би үргэлж гайхан биширдэг байлаа. Аав хувиа бодолгүй үйлчлэхийн үлгэр жишээг надад харуулдаг байсан. Тэр жил бүр ердөө долоо хоног л амардаг байв. Гэвч аав аялаар явахын оронд хөрш бэлэвсэн эмэгтэйн цонхыг хамт будъя гэж биднээс хүсдэг байж билээ. Энэ бол олон үйлчлэлийнх нь зөвхөн ганцхан жишээ. Аав маань үргэлж бусдын талаар санаа тавьдаг байсан.

Намайг ахлах сургуульд байхад

аав хүндээр өвчлөв. Би байнга залбирч, аавыг минь эдгэрэхэд адисалж өгөөч гэж Тэнгэрлэг Эцэгээс гуйдаг байлаа. Аав нэг сар эмнэлэгт хэвтээд талийгаач болж, манай гэр бүлд маш их гарз тохиолдов. Бидэнд аав маань их хэрэгтэй байхад яагаад ийм зүйл тохиолдсныг бид ойлгохгүй байлаа. Яагаад бидэнд ийм явдал тохиолдов гэдгийг ойлгохын тулд бас Тэнгэрлэг Эцэг яагаад миний залбиралд хариулахгүй байгааг мэдэхийн тулд залбирлаа. Тэнгэр чим чимээгүй дүнсийх мэт санагдаг байв. Би олон залбиралдаа хариу авсангүй. Тэнгэрлэг Эцэг намайг орь ганцааранг нь орхисон юм шиг санагддаг байлаа. Гэвч залбирсаар л байлаа.

Жилийн дараа намайг ариун ёслолын цуглаанд оролцож байтал нэг үг хэлэгч Сургаалт Үгсээс дараах судрыг уншлаа:

“Бүх зүрхээрээ ЭЗЭНД итгэ.

Өөрийн ойлголтод бүү түшиглэ.

Өөрийн бүх замаараа Түүнийг таньж мэд. Тэр чиний замыг шулуун болгоно” (Сургаалт Үгс 3:5).

Энэ бол миний залбирлын хариу байсныг Сүнс надад гэрчилсэн юм! Би Их Эзэнд итгэх хэрэгтэй байлаа. Ийнхүү хариу хүлээж автал урт удаан хугацаа өнгөрсөн юм. Энэ бол миний хүлээж авахыг хүссэн хариу биш байлаа. Харин миний залбиралд ирсэн *хамгийн* гайхамшигтай хариу байв. Яагаад аав маань өнгөрснийг би заавал ойлгох учиргүй байжээ. Би Их Эзэнд итгэх хэрэгтэй байлаа.

Их Эзэнд итгэсэн үед та үнэхээр хэцүү юуг ч хийж чадна. Учир нь Тэрбээр замыг чинь удирдан чиглүүлж, дэргэд чинь орших болно. Тэрбээр гарыг чинь өргөж, өөрийн чинь эргэн тойронд тэнгэр элчүүдээ илгээх болно. Энэ бол миний гэрчлэл. Энэ бол бидэнд бүгдэд нь хамаатай юм. ■

Тусгай гэрч



Энэ сэдвээр Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Л.Том Перри бодлоо хуваалцаж байна.

# Бид сэргээгдсэн Сүмээр дамжуулан ямар адислалууд хүлээн авдаг вэ?

*"The Message of the Restoration,"* Лиахона, 2007 оны 5-р сар, 85–88; *"What Seek Ye?"* өгүүлээс Лиахона, 2005 оны 5-р сар, 84–87.

Есүс Христийн сайн мэдээ бүрнээрээ дэлхий дээр сэргээгдээд байна.

Манай Сүм бол эрэгтэй, эмэгтэйчүүд бидний Аврагч болон Түүний сайн мэдээг олох арга хэрэгсэл мөн.

Иосеф Смит Бурханы бошиглогч бөгөөд Бурханы хаант улсыг байгуулах болон бидний Их Эзэн Есүс Христийн хоёр дахь ирэлтэд бэлтгэхэд шаардлагатай бүх зүйлийн сэргээгч байсан билээ.

Бид Аврагчийн сэргээгдсэн Сүмээр дамжуулан Түүнд эргэж очиход шаардлагатай авралын бүх ёслолуудыг хүлээн авдаг.

Санваарын түлхүүрүүд газар, тэнгэр аль алинд лацдан холбох хүчний хамт хүмүүнд сэргээгдсэн юм.

Чи Хүүхдийн Хэсгийн энэ сарын сэдвийн тухай илүү ихийг мэдэхийн тулд энэ хичээл болон үйл ажиллагааг ашиглаж болно.

## Сайн мэдээний анхдагч зарчмууд болон ёслолууд

намайг Бурхантай дахин амьдрах боломжтой болгодог


**Ана Мариа Кобурн,  
Кристина Франко нар**

*“Бид Ариун Сургаалын анхны зарчим болон ёслол нь, нэгдүгээрт: Их Эзэн Есүс Христэд итгэх итгэл, хоёрдугаарт: Наманчлал, гуравдугаарт: Нүглээс ангижрахын тулд усанд умбуулан хийгдэх баптисм, дөрөвдүгээрт: Толгой дээр гар тавиулан хүртэх Ариун Сүнсний бэлэг гэдэгт итгэдэг” (Итгэлийн Тунхаг 1:4).*

**И**тгэлийн тунхагийн дөрөвт Тэнгэрлэг Эцэгтэйгээ хамт амьдрахын тулд өөрийн чинь дагах ёстой дөрвөн чухал зарчим болон ёслолын тухай өгүүлдэг.

Нэгдүгээрт: чамд Есүс Христэд итгэх итгэл хэрэгтэй. Есүс Христэд итгэх итгэлтэй байхын тулд Түүнийг хэзээ ч хараагүй ч Тэрбээр амьд, Тэрбээр аврагч бөгөөд өөрт чинь хайртай ч итгэдэг байх ёстой. Христэд итгэх итгэлтэй байснаараа ч өөрөөс чинь хийхийг Түүний хүсдэг зүйлсийг, тухайлбал: залбирч байх, сүмд явж, эелдэг найрсаг байж, зарлигуудыг сахихыг хүсэх болно.

Өөрөөс чинь хийхийг Есүсийн хүсдэг нэг чухал зүйл бол найман нас хүрэхээрээ (эсвэл түүнээс



дээш насандаа) баптисм хийлгэх явдал мөн. Чи Есүсийн адил усанд умбуулалтаар баптисм хүртэх болно. Энэ нь чи бүхэл биеэрээ усан дотор орно гэсэн үг. Чиний баптисмыг баптисм хүртэх санваарын эрх мэдэл бүхий хэн нэгэн гүйцэтгэх болно. Чи баптисм хүртэх үеэрээ бас Тэнгэрлэг Эцэгт амлалтууд өгдөг. Чи зарлигуудыг сахина гэсэн амлалт өгөх бөгөөд хэрэв зарлигуудыг сахвал, Ариун Сүнсний нөхөрлөл чамд байх болно гэж Тэр амладаг.

Баптисм хүртсэнийхээ дараа чи Ариун Сүнсний бэлэг хүлээн авна. Санваарын эрх мэдэлтэй хүн толгой дээр чинь гараа тавин Ариун Сүнсний бэлгийг чамд өгөх болно. Ариун Сүнс чамайг удирдаж, заан, тайтгаруулж, Есүс Христийн тухай гэрчлэх болно.

Есүс Христийн Цагаатгалын улмаас чи төрсөн өдрөөсөө эхлэн


найман нас хүртлээ гэм буруугүй, цэвэр ариун байдаг. Найман нас хүрч баптисм хийлгэснийхээ дараа ямар нэг буруу юм хийсэн бол наманчлах хэрэгтэй. Наманчилна гэдэг нь буруу зүйлдээ гэмшиж, Тэнгэрлэг Эцэгээс болон гомдоосон байж болох хүмүүсээс уучлал гуйна гэсэн үг. Наманчилсны дараа чи дахиад тийм алдаа гаргахгүй, зарлигуудад илүү дуулгавартай байхын төлөө бүх чадлаараа хичээх хэрэгтэй. Хэрэв наманчилвал Цагаатгал чамайг дахин цэвэр ариун болоход тусална.

Есүс Христэд итгэх итгэлтэй байж, наманчлан, усанд умбуулалтаар баптисм хүртэн, Ариун Сүнсний бэлэг авах нь гэр бүлийнхээ хамт Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёртой хамт амьдрахаар буцаж очиход чинь чамд туслах учраас маш чухал юм. ■

### Үйл ажиллагаа

Чи энэ пүрштэй хөдөлгөөнт дүрсийг сайн мэдээний анхдагч зарчмууд болон ёслолуудын сануулагч болгон хийж болно. 63-р хуудсыг хатуу цаасан дээр наа. Таван тэмдгийг хайчилж ав. Дараа нь хөдөлгөөнт дүрсийг бүдүүн зураасаар хайчлах юм уу, цоолж ав. Тэмдгүүдийг хөдөлгөөнт дүрсээс утсаар болон туузаар уяж өлгө.





●  
Сайн мэдээний  
анхдагч зарчмууд болон  
ёслолууд нь:

●  
1. Их Эзэн Есүс  
Христэд итгэх итгэл

●  
2. Наманчлал

●  
3. Нүглийн  
уучлалын төлөө  
усанд умбуулалтаар  
хийх баптисм

●  
4. Ариун Сүнсний  
бэлгийн төлөөх гар  
тавилт юм.

# Компьютероо унтраагаад надад хэл



**“Б** и оюун санаа, бие  
махбодоо цэвэр ариун  
байлгах болно.”

Миний сайн мэдээний  
жишгүүд

### Даниел Кеннигтон

Бодит түүхээс сэдэвлэв.

*“Итгэлтэй байгтун, мөн  
уруу таталтанд бүү авт”  
(С ба Г 9:13).*

**К**оннор гэрийнхээ компьютер дээр суугаад найзынхаа өгсөн вэбхуудасны хаягийг шивж орууллаа. “Чи энийг орж үзээрэй!” гэж найз нь хэлсэн аж.

Гэвч вэбхуудас гарч ирэнгүүт Коннорт аймаар санагдав. Хуудсыг тэр дор нь хаах гэж хэчнээн ч оролдоод нэмэргүй, хулгана дээр дарах тусам нөгөөх муухай зургууд шинээр гарч ирсээр байлаа. Сандарсан Коннор компьютерийн унтраах товчлуурыг дараад унтлагын өрөөндөө гүйж оров.

Коннор тийм муухай зурагнууд үзсэндээ ихэд харамсчээ. Тэр хэдэн сарын өмнө баптисм хийлгэснээсээ хойш Ариун Сүнснээс ирдэг амар амгаланг онцгой мэдрэх болсон ажээ. Гэвч тэр муухай зургуудыг үзсэнээс хойш амар амгалангийг мэдрэмж нь огт байхгүй болов. Гэм буруутай юм шиг санагдаж, юу үзсэнийг нь хэн нэг нь мэдчихсэн юм шиг айж байлаа.

Коннор хоолны үеэр таг чимээгүй байв. Гэрийнхнийхээ яриаг

сонсохыг хичээсэн ч нөгөөх муухай зургууд санаанд нь дахин дахин орж ирсээр байв. Муухай мэдрэмж түүнээс салахгүй байв.

Коннор орой нь залбирал хэлэхдээ харсан зургуудынхаа тухай Тэнгэрлэг Эцэгт ярилаа. Тэр үүнд харамсаж байгаагаа хэлээд тэр зургуудыг дахин харахгүй гэжээ. Залбирлын дараа тэр арай тайвширсан ч ээждээ хэлэх ёстой гэсэн мэдрэмж төржээ. Коннорт харсан зүйлээ ээждээ хэлэх нь нэг л эвгүй санагдаад байв. Ээж нь уурлаж, урам нь хугарвал яах юм бэ?

Эцэстээ Коннор ээждээ ярихаар шийдэв. Тэр ээжийгээ ном уншиж байхад нь өрөөнд нь орж, орон дээр нь суув.

“Ээж ээ, би тантай ярилцаж болох уу?” гэж тэр асуув.

“Тэг л дээ, миний хүү” гэж ээж нь хэллээ. “Юун тухай юм бэ?”

Тэр ээждээ болсон бүтдийг, найз нь юу гэж хэлснийг, вэбхуудаст ороод харсан зүйлийнхээ тухай нэгд нэгэнгүй ярьжээ. Ээж нь түүний өөдөөс эгцлэн харсан ч уурласангүй.

“Би яахаа ч мэдсэнгүй. Компьютероо унтраачихаад гүйгээд явчихсан. Ээж ээ, намайг уучлаарай. Би тэр хаягийг компьютертээ

шивж оруулдаггүй байсан юм. Тийм муухай зургууд байгаа гэж мэдсэнгүй л дээ” гэж Коннор хэлэхэд

ээж нь хүүгээ чанга тэврэв. “Чамайг тийм зураг харсанд ээж нь харамсаж байна. За-рим хүмүүс хүүхдүүдэд муухай юм үзүүлэх гэж урхиддаг. Харин чи зөв зүйл хийжээ. Хэрэв чи компьютер дээр муухай зураг үзвэл ‘компьютероо унтраагаад надад хэлж бай. Юу гэсэн үг вэ гэвэл компьютерийнхоо унтраах товчийг дараад тэр дороо надад ирж хэлж бай гэсэн үг. Чи маш зөв зүйл хийжээ” гэж ээж нь хэлсэн гэнэ.

Коннорын санаа сая л амарлаа!

“Коннор оо, энэ чинь чиний буруу биш шүү дээ. Энэ бол алдаа. Болсон явдлын талаар чи гэм буруутай юм шиг санасны хэрэггүй” гэж ээж нь хэлэв.

“Ээж ээ, хэрэв би зөв зүйл хийсэн юм бол яагаад надад эвгүй мэдрэмж төрөөд байгаа юм бэ?”

“Ямар нэг аюултай зүйл байгаа бол Ариун Сүнс

# ИНТЕРНЕТИЙГ АЮУЛГҮЙ БАЙЛГАХ САНААНУУД

- Интернетийг ашиглахаасаа өмнө эцэг эхээсээ зөвшөөрөл ав.
- Эцэг эх, гэр бүлийн бусад гишүүд дэргэд чинь байгаа үед Интернетийг ашигла.
- Эцэг эх чинь зөвшөөрөл өгөөгүй бол жинхэнэ нэр, нас, хаяг, утасны дугаар болон хувийн бусад мэдээллийг бусдад бүү өг.
- Дуртай вэбхуудсуудаа тухай бүр хайхгүйн тулд өөрийн таних түлхүүрийг оруул.

## Зохисгүй вэбхуудсуудаас зайлсхийхийн тулд:



1. Дэлгэцийг эсвэл компьютерийг унтраагаад.



2. насанд хүрэгчдэд хэл.



3. Тэр хуудсанд дахиж бүү ор.



4. Хэрэв хэн нэг нь өөрт чинь зохисгүй вэбхуудас үзүүлбэл, түүнийг орхиж явахаас бүү ай.

бидэнд мэдэгддэг. Чамд төрсөн мэдрэмж бол Ариун Сүнс чамд муу зүйлээс холд гэж хэлж байгаа нь тэр. Би компьютер дээрээ зохисгүй хуудсуудад хаалт тавьсан шүүлтүүр суулгана. Гэвч зарим үед зохисгүй зүйлс гарч ирж мэднэ. Хэрэв дахиад иймэрхүү юм тохиолдвол чи яахаа мэдэв үү” гэж ээж нь асуув.

“Компьютероо унтраагаад танд хэлнэ” гэж Коннор хариуллаа.

“Тун зөв!” гэж ээж нь хэлэв.

Коннор орондоо орохоос өмнө санаа нь амарсныхаа төлөө Тэнгэрлэг Эцэгт хандан залбирав. Тэр залбирч байхдаа Ариун Сүнснээс ирсэн амар амгаланг мэдрэв. Бүх зүйл сайхан болно гэдгийг тэр мэдэж байлаа. ■

**Х**эрэв чи аюулгүй, зугаатай вэбхуудас хайж байгаа бол [friend.ids.org](http://friend.ids.org)-т орж үз. Энэ вэбхуудсанд түүхүүд, будах хуудсууд, дүрс бичлэг, слайд, тоглоом, бусад олон зүйл байдаг.



# Бидний хуудас



Монреалын Кубек гадасны Вилл Мэри тойргийн Хүүхдийн Хэсгийн хүүхдүүд, багш нар, удирдагчдад Монреалын Кубек Ариун сүмийн газар дээр очиж үзсэн нь таалагджээ. Ариун сүмийн ерөнхийлөгчийн зөвлөл тэдэнд баяр хүргэн, орчинтойронгоо танилцуулахад тэд чимээ шуугиангүй, хүндэтгэлтэй байлаа. Өнгө өнгийн цэцэг орчинд нь алагласан, үзэсгэлэнт сайхан ариун сүмийг харах нь тэдэнд туйлын сайхан байлаа. Тэдэнд бас ариун сүмийн тухай кино үзүүлж, тус ариун сүмийн зурагтай жижигхэн карт бэлэглэв.

Панамын Майкл Ж. (баруун талд), нас 11, каратегийн хичээлдээ дуртай, сургуульдаа шамдан суралцдаг. Тэр сайн сурдаг учраас сургууль дээрээ нэг удаа "өдрийн захирал" болсон гэнэ.

Майкл аль хэдийнээ зоригт номлогч болжээ. Майкл гэрийнхээ ойролцоох олон улсын яармаг худалдааны орох хаалган дээр эцэг эхийнхээ хамт Сүмийн тухай товхимлуудыг хүмүүст тарааж, Сүмийг танилцуулах хэсэгт очиж үзнэ үү хэмээн урьж байлаа. Тэр бас найзынхаа гэр бүлд Сүмийн танилцуулгын картыг өгч, улмаар номлогчид Сүмийн тухай тэдэнд заасан гэнэ. Тэр бүрэн цагийн номлогч болохыг тэсч ядан хүлээж байна.



Гар зураг, гэрэл зураг, туршлага, гэрчлэл буюу захидлаа [liahona@ldschurch.org](mailto:liahona@ldschurch.org) гэсэн хаягаар и-мэйлээр, сэдвийн мөрөн дээр "Our Page" гэж бичин ирүүлнэ үү. Эсвэл:

Liahona, Our Page

50 E. North Temple St., Rm. 2420

Salt Lake City, UT 84150-0024, USA гэсэн хаягаар шуудангаар ирүүлж болно.

Ирүүлэх материалдаа, хүүхдийн бүрэн нэр, нас, эцэг эх, тойрог буюу салбар, гадас буюу дүүргийн нэр, хүүхдийн гэрэл зураг, ирүүлсэн материалыг ашиглахыг зөвшөөрсөн эцэг эхийн зөвшөөрлийн бичиг (е-мэйлээр ирүүлж болно) байх ёстой. Ойлгомжтой тодорхой байлгах үүднээс засвар хийгдэж болно.



## ТАЙТГАРЛЫН ТӨЛӨӨХ ЗАЛБИРАЛ

Нэг шөнө би манай гэр түймэрт өртөж, бүх юм шатаж байна гэж хоёр удаа зүүдлэв. Тэгээд айсан гэж жигтэйхэн. Тиймээс дахиад ийм зүүдлэхгүйн төлөө Тэнгэрлэг Эцэгт хандан залбирлаа. Дахиад орондоо буцаж ороод унттал нэг их сайхан талбай дээр байна гэж зүүдлэв. Би маш их тайван, айх зүйл огт байхгүй байлаа.

Нивиа Анжелика А., нас 10, Мексик



Жеремиа П., нас 10, Самоа

# Миний гаргасан ЧУХАЛ ШИЙДВЭР

Ребека Шоо

Бодит түүхээс сэдэвлэв.

*“Тэдний хүүхдүүд нүглүүдийнхээ ангижралын тулд  
найман настайдаа баптисм хүртэж, мөн гар  
тавилтыг хүлээн авах ёстой” (С ба Г 68:27).*

**Н**иколе, өнөө орой Жонсо-  
ныхон дахиад ирнэ шүү  
гэж ээж хэллээ. “Чи тэдний  
хүссэнээр залбирсан уу?”

“Үгүй ээ, амжаагүй л байна  
шүү” гэж би хэллээ.

Ахлагч Жонсон, Жонсон эгч  
хоёр бол манай тойргийн ном-  
логч хос юм. Тэд надад номлог-  
чийн ярилцлагуудыг заахаар  
манай гэр бүлийн үдэшт ирээд  
байна.

Манай гэрийнхэн сүмд үргэлж  
явдаггүй болохоор миний ойл-  
гоогүй нэлээд зүйл байлаа.  
Одоо би найм хүрэх гэж бай-  
гаа болохоор баптисм хийл-  
гэх эсэхээ шийдэх хэрэгтэй  
гэж ээж надад хэлдэг.

Ахлагч Жонсон, Жонсон  
эгч хоёр өнгөрсөн долоо  
хоногт Иосеф Смит үнэнийг  
мэдэхийн тулд хэрхэн залбир-  
сан тухай надад заасан. Тэгээд тэд  
намайг баптисм хийлгэх талаар  
залбирч үзээрэй гэсэн юм.

“Ямар мэдрэмж төрөх нь вэ?  
Анхааралтай ажиглаарай. “Ариун  
Сүнс бидэнд үнэнийг мэдэхэд хэр-  
хэн тусалдгийг мэдэхэд энэ чинь  
хэрэгтэй” гэж Жонсон эгч хэлсэн.

Би Иосеф Смит шиг 14 нас  
хүртлээ хүлээж болно гэж боддог  
байлаа.

Өнөө орой Ахлагч Жонсон хи-  
чээл заахдаа аягануудыг нэг нэгэн

дээр нь давхарлаж тавьсаар цам-  
хаг болгов. “Хэрэв чи сайн суурь  
тавихгүй бол цамхаг нурж унана.

Сүм яагаад ийм бат бөх суурь-  
тай байдаг гэж чи боддог вэ?” гэж  
тэр асуув.



Би өнгөрсөн  
долоо хоногийн  
хичээлийг саналаа.  
“Тэнгэрлэг Эцэг, Есүс  
хоёр Сүмийг хэрхэн  
сэргээхийг Иосеф  
Смитэд хэлснийх болов уу” гэж би  
хэллээ.

“Тэр зөв өө. Биднийг зөв замаар  
удирдах бошиглогчид, төлөөлөг-  
чид байдаг шүү дээ” гэж Ахлагч

Жонсон хариуллаа.

Тэгэхэд нь би ойлгосон. Ерөн-  
хийлөгч Томас С.Монсонгийн  
тухай сонсох бүрд надад үргэлж  
сайхан санагддаг.

Тэгээд Жонсон эгч надаас “Бап-  
тисм хийлгэх талаар залбирч үзэв  
үү?” гэж

миний санаа зовж байсан  
асуултыг асуув.

“Үгүй ээ. Амжаагүй л байна” гэж  
би хариуллаа.

“Баптисм хийлгэхийг хүсч  
байна уу?” гэж Жонсон эгч асуув.

Би түүнд хариулахыг хүссэн  
ч яасныг бүү мэд, гэнэт мөрөө  
хавчив.

Миний жаахан эмэгтэй дүү  
намайг өөр шигээ усан дотор бүх  
биеэрээ орохоос айж байна гэж  
боджээ. Гэвч би усанд дуртай,  
яагаад санаа зовоод байгаагаа  
мэдэхгүй байв.

“Чи хариуцлага хүлээхээс  
айдаг уу?” гэж Жонсон эгч  
асуув.

Жонсон эгчийг ингэж хэ-  
лэнгүүт би юунд санаа зовж  
байгаагаа ойлголоо. Баптисм  
хийлгэсний дараа намайг  
хариуцлага хүлээх болно гэж ээж  
хэлсэн билээ. Тэр нь юу гэсэн үг  
вэ? гэвэл би сонголтынхоо төлөө  
хариуцлага хүлээнэ гэсэн үг байв.  
Бурханы зарлигуудыг хичээнгүй-  
лэн сахих ёстой болно. Би тэр



хангадаг юм.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Ричард Г. Скотт,  
“To Acquire Spiritual Guidance,” *Лиахона*, 2009 оны 11-р сар, 6.

“Зөв шийдвэр гаргах өөрийн чинь чадвараас хэтэрсэн хэцүү шийдвэр гаргах шаардлага танд тулгарч . . . болно гэдгийг Тэнгэр дэх Эцэг мэддэг. . . . Тэрбээр Ариун Сүнсээр дамжуулан . . . тусламж хүлээж авах арга хэрэгслээр

хариуцлагыг биелүүлэхэд өөрийгөө бэлэн болсон гэж бодохгүй байв. Би аав шигээ сүмд явахаа боливол юу болох вэ?

“Чи найм хүрээд баптисм хийлгэхгүй байлаа ч сонголтуудынхаа төлөө хариуцлага хүлээх болно шүү дээ. Харин баптисм хийлгэж, гишүүнээр батлагдсаны дараа зөв сонголт хийх талаар чи улам их тусламж авах болно. Ариун

Сүнсний бэлэг чамд байх учраас тэр” гэж Жонсон эгч хэллээ.

Тэгээд бид миний сахих ёстой зарим зарлигийн талаар ярилцав. Архи, тамхи, мансууруулах бодис эрүүл мэндэд муу гэдгийг би аль хэдийнээс мэддэг учир Мэргэн Ухааны Үгийг сахих нь миний хувьд хэцүү биш байв.

Жонсоныхныг явсан хойно би баптисм хийлгэхээс айхаа болив.

Зөв сонголт хийж, Тэнгэрлэг Эцэгийн зарлигуудыг сахихыг би үнэхээр хүсч байлаа. Үүнд Ариун Сүнс надад тусалсанд баяртай байлаа.

Өрөөндөө ороод орныхоо дэргэд өвдөг сөгдлөө. Залбирч байхдаа баптисм хийлгэх нь зөв гэдэгт бат итгэлтэй байв. Энэ мэдрэмж бол миний залбирлын хариу гэдгийг би мэдсэн. ■

# Эелдэг хариулт

Лора Хантер

Бодит түүхээс сэдэвлэв.

“Эелдэг хариулт уур хилэнг зайлуулна. Харин хүйтэн цэвдэг үгс уур хилэнг хөдөлгөнө”  
(Сургаалт үгс 15:1).

2.



4.



1.



3.





5.

Лизигийн хувьд мөн  
л ийм байна гэж чи  
бодож байна уу?

Дараагийн удаа ингээд  
үзээрэй. Тэгээд юу  
болохыг хараарай.




6.

Би шидэт далавчаар  
тогломоор байна!



7. Алис аавынхаа хэлснийг саналаа.

Лизи, миний титмийг өмсмөөр байна  
уу? Чи гүнж болно, харин би шидэт найз  
чинь болно.



8.

За тэгье. Би үзэсгэлэнт  
гүнж болно!


За, наашаа хүрээд ир  
эрхэм дээдэс ээ. Хоёулаа  
тоглоё!





**Б**ид заримдаа уур уцаартай байгаа үедээ хэн нэгэнд эелдгээр хариулах нь хэцүү байдаг л даа. Энэ хуудсан дээр харуулсан бөгж эсвэл бугуйвчийг хийхэд туслахыг аав ээжээсээ хүс. Зөв сонголт хийх болон эелдгээр хариулахад туслах сануулагч болгон түүнийгээ зүү.





**БАПТИСМ ХҮРТСЭНЭЭР БИ БУРХАНТАЙ  
ГЭРЭЭ ХИЙДЭГ.**

“Бид Сайн мэдээний анхдагч зарчим болон ёслол нь, нэгдүгээрт: Их Эзэн Есүс Христэд итгэх итгэл, хоёрдугаарт: Наманчлал, гуравдугаарт: Нүглээс ангижрахын тулд усанд умбуулан хийгдэх баптисм, дөрөвдүгээрт: Толгой дээр гар тавиулан хүртэх Ариун Сүнсний бэлэг гэдэгт итгэдэг” (Итгэлийн Тунхаг 1:4).

## Удмын бичгүүдийг олон улсын хэлээр индексжүүлэх хэрэгцээ

Хикари Лофтус

Сүмийн сэтгүүлүүд

**Б**үх дэлхий даяар хүмүүс өвөг дээдсээ хайж харин юм хүмүүс энэхүү судалгааг хийх боломжийг олгож байна.

2006 онд онлайнд байршуулсан FamilySearch индекс нь удмын бичгийн судалгаа (бичил хальсан дээрх зэрэг) хийх болон уг бичигт агуулагдсан баримтыг боловсруулах боломжийг дэлхий даяарх сайн дурынханд олгосон юм.

Хожмын Үеийн Гэгээнтэн болон ХҮТ бус идэвхтэй индексжүүлэгчид үйл ажиллагаагаа эхэлснээс хойш 547,978,000 удмын бичгийг индексжүүлж дуусган, FamilySearch маш амжилттай ажиллажээ. Гэвч индексжүүлэлт хийдэг хүмүүс одоо ангиас бусад хэлээр удмын бичгүүдийг индексжүүлэх шинэ зорилго тавьж байгаа аж.

“Бид англи биш нэрсийг индексжүүлэх шаардлага улам бүр нэмэгдсээр байна. Англи биш нэрстэй илүү сайн ажиллахын тулд өөр хэлээр ярьдаг хүмүүсийг энэ ажилд оролцуулахыг хичээж байна” гэж FamilySearch-ын маркетингийн менежер Жим Эриксон яриу.

Англи хэлээрх удмын бичгийн индексжүүлэлт үргэлж өсч байгаа ч олон улсын удмын бичгийн индексжүүлэлт илүү түргэн өсч байна. Улс орны засгийн газрууд, удмын бичиг хөтөлгөчид FamilySearch-ийн үйлчлэлийг мэддэг болсноор хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх боломжтой болж байна.

FamilySearch-ийн ажилтнууд ажлаа эхлэхийн тулд засгийн газар, номын сан болон бусад эх сурвалжуудаас удмын бичгийн цэдгүүдийг

хүлээн авч, дижитал системээр хуулбарыг хийдэг. Эдгээр хувиудыг жижиг бүлгүүд болгон хуваагаад “бичил хэсгүүд” хэмээн нэрлэж, ингэснээр сайн дурынхан онлайнгаар хэрэглэх боломжтой болсон. Сайн дурынхан FamilySearch-д орж, бичил хэсгийг татаж аваад, дэлгэцэн дээр гарч ирсэн мэдээлэл уруу нэвтрэнэ. Уг мэдээллийг гэр бүлийн түүх судлаачид хожим нь илүү өргөн хэрэглэх боломжтой болсон. Бичил хэсэг бүр нь сайн дурын индексжүүлэгч 30 минутын дотор багтаан хийж дуусгах ажлаас бүрддэг гэж FamilySearch-ийн Индексжүүлэх төслийн зохицуулагч Кати Гейл ярилаа.

FamilySearch индексжүүлэлтэд оролцогч сайн дурынхан дотор англи хэлээр ярьдаггүй (одоо уг сайтыг долоон хэлээр ашиглах боломжтой) хүмүүс, түүний дотор номлолын үйлчлэл, сургууль, бусад төрлийн сургалтаар хэлний чадвар эзэмшсэн хүмүүс орж болно.

Та нарын ажиллаж, амьдардаг оронд ургийн бичгийг индексжүүлдэг төсөл байхгүй бол тухайн хэлээр ярьдаг өөр оронд энэ төсөл хэрэгждэг байж болно.

Украины Киевийн Ариун сүм баригдаж байх үеэр Украины Гэгээнтнүүд ариун сүм баригдаж дууссан үед тэнд аваачихаар нэрсийг олж, индексжүүлэх ажилд оролцож байлаа. Тус ариун сүм онцгойлон адислагдах үед Киев төсөл дээр ажилласан Украин, Орос, Хойд, Өмнөд Америк, Европын 401 индексжүүлэгч болон Гэгээнтнүүд 200,000 украинчуудын нэрсийг ариун сүмд авчирчээ.

Индексжүүлэх ажил аль нэг бүсэд өсөн нэмэгдэж байгаа үед бичил хэсгүүдээр хангадаг FamilySearch-ийн

ажилтнууд өсөлтийг судалж, хэрэгтэй бол тухайн бүс нутагт хамааралтай төслүүдийн гүйцэтгэлийг хурдастгана.

Индексжүүлэлтийн одоогийн явцаар бол



одоо байгаа бичил хэсгүүдийг индексжүүлж дуусахад зарим оронд арван жил шаардагдаж байгаа учир нэмэлт индексжүүлэгчид хэрэгтэй байна. Англиас бусад хэлүүд дээрх олон тооны бичил хэсгүүдийг индексжүүлэхэд дунджаар хоёроос зургаан жил шаардлагатай.

“Хэрэв төсөл ийм байдлаар үргэлжилбэл хэнд ч ач холбогдлоо өгөхгүй. Индексжүүлэлтийн зорилго нь удмын бичгүүдийг электрон файлаар хангаснаар хүмүүс өвөг дээдсээ олох явдал юм.

Бид төслүүдийг харьцангуй түргэн дуусахаар хичээн ажиллаж байна” гэж FamilySearch-ийн Индексжүүлэх үйл ажиллагааны менежер Паул Старки ярих.

Сүмийн эзэмшилд Гранит Маунтейн Рекорд Ваултад хураангуйлан хадгалсан удмын бичгүүдийн 2.4 сая орчим бичил хальс байна. Энэ



ГЭРЭЛ ЗҮРГИЙГ ВЕЛДЕН К.АНДЕРСЕН, © ИИ

## ОДОО ИНДЕКСЖҮҮЛЖ ЭХЛЭЭРЭЙ

Индексжүүлэлтэд [indexing.familysearch.org](http://indexing.familysearch.org)-хаяагаар орж оролцоно уу.

Менюгээс долоон хэлний нэгийг нь сонгож, ажлаа эхэлнэ.

**Get Started** дээр дар.

Индексжүүлэх программ хангамж нь автоматаар татан авч, хэрэглэхэд бэлэн болгоно.

Уг програмтай танилцахын тулд сургалтын бичил хэсэг дээр дадлага хий.

Ингээд индексжүүлэлтийг эхэл! Та улс орнуудаар зохион байгуулсан аль ч төслөөс нэг бичил хэсгийг сонгож болно. ■

бол ойролцоогоор 15 тэрбум удмын бичгийг индексжүүлэх шаардлагатай байна гэсэн үг юм. Дэлхий даяар бусад тоо томшгүй олон удмын бичиг байдаг.

“[Хувь хүмүүсийн нэр болон удмын бичгүүдийг олох нь] судлаачдын зүрх сэтгэлийг эцгүүд уруу нь эргүүлэх явдал мөн. Сүмийн гишүүд индексжүүлсэн мэдээллийг өвөг дээдсээ олж тогтоон баримтжуулж, ариун сүмд тэдний төлөө авралын ёслолууд хийхэд ашигладаг” гэж Эриксон ах хэллээ.

Компьютер ашигладаг хэн ч гэсэн индексжүүлэх ажилд оролцож чадах ч уг ажлын ач холбогдлыг дутуу үнэлж болохгүй гэж Гейл эгч ярих. “Хэрэв хүмүүс индексжүүлэлтийг гэр бүлийн түүхийн нэн чухал эх сурвалж гэж үзэн, энэ ажлын ач холбогдлыг ойлгох юм бол улам олон сайн дурынхан хэрэгтэй болно.

Индексжүүлэлтэд оролцох олон хүн бидэнд хэрэгтэй байна. Бид энэ хөтөлбөрийг найз нөхөд, гэр бүлийн гишүүд нь Сүмийн гишүүд үү, биш үү гэдгийг үл харгалзан хүмүүстэй хуваалцдаг байхыг хүсч байна. Энэ бол зөвхөн Сүмийн гишүүдэд зориулсан ажил биш. Хүн бүхэн нийтлэг нэг зорилгын төлөө хамтран ажиллах нь урамтай байдаг” гэж Эриксон ах ярих. ■

**FamilySearch-ийн индексжүүлэлтийн зохицуулагчид англи хэлээр бусад хэлээр индексжүүлэх ажилд сайн дурынхныг татан оруулах зорилт тавьж байгаа ажээ.**

# Эквадорт хэрэгжүүлсэн хөтөлбөрийн үр дүнд хүмүүсийн бие даасан байдал өсч байна

Хетер Вригли

Сүмийн сэтгүүлүүд

**“**Хувь хүний эрх чөлөө, иргэний үүрэг нь тэд амьдралаа авч явахад өөртөө туслах зарчмаас хамааралтай байдаг” гэж Сүмийн арвангурав дахь Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон (1899–1994) ХҮГ Энэрлийн хөтөлбөр болох Бенсоны хөдөө аж ахуйн институт, Хүнсний институт ба Корпорацийг нээж хэлсэн үгэндээ тэмдэглэжээ.

Бенсоны институт бие даах зарчмын үзэл санаан дээр тулгуурлан, дэлхийн мянга мянган ядуучуудад хүнс тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, шим тэжээллэг болон эрүүл хоол хүнс хэрэглэж, амьдралаа дээшлүүлэхэд нь тусалсан юм.

2009 онд Бенсоны институтийн гишүүд хөдөө аж ахуйн арвин баялаг уламжлалтай Эквадорт очиж ажиллажээ. Гэвч Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын судалгаагаар 15 сая хүн амтай энэ улсын таваас доош настай хүүхдүүдийн 23 хувь нь тэжээлийн дутагдалд байнга ордог ажээ. Ядуу тарчиг амьдралаа өөрчлөн сайжруулахаар хичээж буй хүмүүст туслан, дээрх статистикийн тоог бууруулахад Бенсоны Институтээс зохион байгуулж байгаа ажил тусалж байна.

Зургаан хүүхэдтэй нэгэн эмэгтэй: “Бенсоны институт энд ажиллаж эхлэхээс өмнө гэр бүлээ тэжээхэд байнга хүндрэл тохиолддог байлаа. Хүүхдүүдээ өдөр бүр аяга хоол, зүсэм талх өгч чадахгүй ядуу эх байна гэдэг тун ч гунигтай хэрэг шүү” гэж яриу.

Бенсоны институтийн хөтөлбөрт хамрагдаж байгаа гэр бүлүүд хүнсний ногоог сэлгэн тарих арга техник, мал, тэжээвэр амьтад үржүүлэх жижиг ферм эрхлэх, тэжээллэг хүнсийг тогтмол хэрэглэх, хувийн эрүүл ахуй болон хоол хүнсийг зохих журмын дагуу бэлтгэхэд суралцсан ажээ.

Олон хүний хувьд өдөр тутмын сорилт

байсан өлсгөлөн фермийн аж ахуй эрхлэх шинэ арга техникийн ачаар эдүгээ байнгын сорилт байхаа больжээ. Гэр бүлүүд өөрсдийн нөөцийг бүрдүүлэхүйцээр хүнсний үйлдвэрлэлээ эрс нэмэгдүүлсний зэрэгцээ, орлого олохын тулд бүтээгдэхүүнээ зардаг болсон гэнэ. Түүнээс гадна гэр бүлүүдийн эрүүл мэнд, хүнс тэжээл, эрүүл ахуй сайжирсан байна. Цэцэрлэгтээ өөрсдийн хөдөлмөрөөр тарьж ургуулсан



**Бенсоны институтийн хөтөлбөрөөр ажилласан гэр бүлүүд эрүүл мэнд, хоол хүнс, эрүүл ахуйгаа сайжруулж чаджээ.**

жимсийг идсэнээр урьд нь гачигддаг байсан шим тэжээлийг хангалттай авдаг болжээ.

“Өмнө нь хүүхдүүд маань хичээлдээ тийм сайн биш байлаа. Уг хөтөлбөр эхэлсний дараа хүүхдүүд маань хичээлээ хурдан ойлгодог болсон. Урьд нь манайхны хүүхдүүд байнга өвчлөдөг байсан бол хөтөлбөрөөс хойш хүүхдүүд өвчлөхөө больсон. Урьд нь тэд хичээл дээрээ унтдаг байсан бол одоо хичээл дээрээ унтахаа больсон. Тэд урьд нь ядранги, цонхигор царайтай харагддаг байсан бол хөтөлбөрийн дараа илүү эрүүл чийрэг, эрч хүчтэй харагддаг болсон” гэж тэндхийн нэг багш ярилаа.

Сүмийн халамжийн бүх хөтөлбөр, үйл ажиллагаа нь бие даах чадварын нотлогдсон зарчмууд дээр суурилдаг билээ. Энэхүү зарчим нь Бенсоны институтийн туршлага, мэдлэг олгох хэдэн арван жилийн практик үйл ажиллагаатай нийлэн дэлхий даяар хэдэн арван мянган хүний амьдралыг адисалсаар байна. ■

**Эквадорт хэрэгжүүлж буй төслийн тухай дүрс бичлэгийг онлайнаас [76 Лиакхона](http://lds.org/church/news/growing-self-sufficiency-in-ecuador-ээс үзнэ үү.</a></b></p></div><div data-bbox=)**

## ДЭЛХИЙД ГЭРЛЭЭ ХАРУУЛЬЯ

### Гэрлийг дэлхийд өргөн харуул хэмээн Төлөөлөгчид Төв Америкийн Гэгээнтнүүдэд захив

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч М.Рассел Баллард, Ахлагч Тодд Кристофферсон нар 2011 оны 1-р сард Гватемал, Гондурас, Никарагуад томилолтоор ажиллах үедээ, Сүмийн гишүүн бүр Есүс Христэд итгэх гүнзгий итгэлийг өөртөө төлөвшүүлэх ёстой гэж хэлжээ. Тэд Сүмийн бусад удирдагчдын нэгэн адил залбирал, судар судлах, гэр бүлийн үдэш, ариун сүмд үйлчлэх, Хүндэтгэлийн өдрийг ариунаар сахих, Их Эзэний зарлигуудад дуулгавартай байж, эргэн тойрныхоо хүмүүстэй итгэлээ хуваалцах замаар гэр бүлээ бэхжүүлдэг байхыг гишүүдэд зөвлөв.

Ахлагч Кристофферсон, Баллард нар хэд хэдэн гадасны чуулганыг тэргүүлж, орон нутгийн санваартны удирдагчид, эцэг эхчүүд, гэр бүлийн хосууд, залуу насанд хүрэгчид, өсвөр насныханд зориулсан галын дэргэдэх ярилцлагуудад оролцов. Тэд бас дөрвөн номлолын 1,100 гаруй номлогчид, гадасны ерөнхийлөгчийн зөвлөлүүд, бишопууд, салбарын ерөнхийлөгчидтэй уулзжээ.

### Ахлагч Скотт Мозамбикт эргэж ирэв

“Та нар бол дэлхий дээрх Бурханы хамгийн үнэ цэнэтэй хүүхдүүд, Бурхан та нарт хайртай” хэмээн Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Ричард Г.Скотт саяхан Зүүн Өмнөд Африкийн бүст очихдоо Мозамбикийн Гэгээнтнүүдэд хандан хэлэв. Энэ орныг сайн мэдээг номлоход зориулж онцгойлон адисалснаас хойш арваннэгэн жилийн дараа Ахлагч Скотт 2011 оны нэгдүгээр сард эргэж ирэхдээ Сүм агуу өсөлт дэвшилтэд хүрснийг мэдсэн аж.

Ахлагч Скоттыг анх ирэхэд Мозамбикт Сүмийн гишүүн ердөө 40-хөн байсан бөгөөд сүм Өмнөд Африкийн Иоханнесбургийн Номлолд харьяалагдаж байжээ. Түүнийг хоёр дахь удаагаа ирэхэд Сүм улс орон даяарх 2 дүүрэг, 19 салбар, 3 бүлэгт цугладаг 5000 гаруй гишүүдтэй болж өсч хөгжсөн байлаа. Энэ оронд бас Мозамбик, Ангола хоёрыг хариуцдаг Мозамбикийн Мапуто Номлол байрлаж байна.

Ахлагч Скотт явахынхаа өмнө Сүмийн



ГЭРЛЭГ ЗҮРГИЙГ АХЛАГЧ НЕЙЛ Л.АНДЕРСЕНЭ ЗӨВШӨӨРЛӨӨР НИЙЛГЭВ

**Арванхоёр  
Төлөөлөгчийн  
Чуулгын  
Ахлагч Нийл  
Л.Андерсон  
номхон да-  
лайн бүсийн  
номлогчид  
болон гишүүд-  
тэй уулзжээ.**

Хүмүүнлэгийн Тусламжийн хөтөлбөрөөр Мозамбикт ажиллаж байгаа эмч нартай уулзжээ.

### Ахлагч Беднар, Андерсен нар Номхон Далайн Гэгээнтнүүдийг хүчирхэгжүүлэв

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Давид А.Беднар, Нейл Л.Андерсен нар саяхан Номхон Далайн орны Сүмийн гишүүд, номлогчдоод заавар өгч, сэтгэл санааг нь өргөн, итгэлийг нь бэхжүүлэв.

Ахлагч Беднар Тонга, Шинэ Зеланд, Хавай, Маршаллын арлууд дахь номлогчид, гишүүдтэй уулзжээ. Маршаллын Арлуудын гишүүдийн хувьд Ахлагч Беднарын айлчлал чухал үйл явдал болсон. Учир нь Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн энэ оронд анх удаа айлчилж байгаа нь энэ ажээ.

Ахлагч Андерсен Австрали, Папуа Шинэ Гвиней, Шинэ Зеланд Францын Полинезид томилолтоор ажиллав.

“Бид далайн арлууд болон дэлхийн хязгааруудад айлчлах үедээ газар болгонд Сүмийг хардаг. Сүм бат бөх сууриа олж өсч хөгжиж, итгэл бишрэлтэй, сайн хүмүүстэй болжээ. Энэ бол үнэхээр гайхамшигтай” гэж Ахлагч Беднар хэлжээ. ■

Өнөө үеийн бошиглогчид, төлөөлөгчдийн үйлчлэлийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг [lds.org/study/prophets-speak-today-гээс](https://lds.org/study/prophets-speak-today-гээс) үзнэ үү.

### Нью Каледоны гишүүд ариун сүмд айлчлахад нь тэдний итгэл болон гэр бүл нь урам зориг өгчээ

Нью Каледоны 147 гишүүн нэгдүгээр сард Шинэ Зеландын Хамилтонд ариун сүмд орохын тулд тэнд бүтэн сар болжээ.

Олон хүний хувьд энэ аялалаар ХҮТ-н ариун сүмд анх удаа орох гэж байлаа. Бусад гишүүдийн хувьд тэд жилд нэг удаа ариун сүмд ордог байжээ.

“Нью Каледонд ариун сүм байдаггүй бөгөөд ихэнх гишүүд маань тийм ч чинээлэг гэр бүл биш юм. Ариун сүмийн аялалд зориулж, эцэг эхчүүд бүтэн жил ажиллаж, мөнгө

хураасан” гэж аялалын бүлгийн гишүүн Жорж Гайди хэлэв. Ариун сүм эдгээр гишүүдийн гэрээс 1600 км хол оршдог ажээ.

Тэд Шинэ Зеланд уруу ариун сүмд явах ийм их хүсэлтэй байдгийн учир нь тэд тэнд Есүс Христэд итгэх итгэлээ болон гэр бүлээ бэхжүүлэхэд оршдог юм.

Нью Каледон дахь дүүргийн ерөнхийлөгч Жерард Мөү Тем “ариун сүмд явах нь олон хүний хувьд итгэлээ бэхжүүлж, Бурханд ойр өсч хөгжих боломж юм” гэж нэмэн хэллээ. ■

#### **ДЭЛХИЙ** ДАХИНД

##### **Соломоны Арлуудын Ерөнхий сайдад Гэр бүлийн тунхгийг гардуулав**

Сүм 2011 оны 1-р сарын 21-ний баасан гарагт “Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг”-ийг (*Лиахона, Ensign*) Соломоны арлуудын ерөнхий сайд Данни Филиппт ёслол хийж гардуулав.

Бүсийн Дал Дөрк Смиверт болон Сүмийн бусад төлөөлөгчид ерөнхий сайдын гэрт очиж, уг тунхгийг гэр бүлийн жижигхэн баримлын хамт гардуулжээ.

##### **Эл-Сальвадорын Ариун сүмийн нээлтийн өдрүүдийг зарлав**

2011 оны 7-р сарын 1-23-ныг дуустал ням гарагаас бусад өдөр Сан Сальвадорын Эл-Сальвадорын Ариун сүмийн нээлтийн ажиллагаанд Сүмийн Тэргүүн Зөвлөлөөс

гишүүд болон олон нийтийг урьж байна.

Соёл урлагийн арга хэмжээ 2011 оны 8-р сарын 20-ны бямба гарагт, тус ариун сүмийн онцгойлон адислах үйл ажиллагаа дараагийн өдөр нь болно.

##### **Сүмийг байгуулахад авьяас чадвараа хуваалцах боломжийг Вэб хуудас гишүүдэд олгож байна**

Helping in the Vineyard бол байнга өсөн нэмэгдэж байгаа сайн дурынхны төслүүдэд Сүмийн гишүүдийн тусалж болох Сүмийн шинэ вэбсайт юм. Төслүүдэд орчуулга, FamilySearch-ийн индексжүүлэлт, гэрэл зураг, видео болон имижуудийг тэмдэглэх болон интернэтэд нэвтэрч аль ч газраас хийж болох редакцийн ажил зэргүүд байгаа болно.

Vineyard-ыг бүтээгчид 2011 оны туршид 10,000 сайн дурынхан онлайн төслүүдэд бүртгүүлж оролцоно гэдэгт найдаж байгаа ажээ. Гишүүд одоогоор зөвхөн англи хэлээр

байгаа [vineyard.lds.org](http://vineyard.lds.org)-т бүртгүүлэн, оролцож болно.

##### **Хүүхдийн уран бүтээлийн шинэ үзэсгэлэн музейд нээгдэв**

Солт Лейк хот дахь Сүмийн Түүхийн Музей бүтээлчээр суралцах орчин болон хүүхдийн урлагийн бүтээл гэсэн хоёр шинэ үзэсгэлэн нээлээ.

*The Gospel Blesses My Life (Сайн мэдээ миний амьдралыг адисалсан нь)* сэдэвт, Есүс Христийн сайн мэдээний тухай мэдлэг амьдралыг хэрхэн адисалдгийг дүрсэлсэн, дэлхийн 42 орны хүүхдийн уран зургийн үзэсгэлэн юм. Нөгөө нь.

*A Book of Mormon Fiesta: A Latin American Celebration (Мормоны Номын Баяр: Латин Америкт тэмдэглэсэн нь)* үзэсгэлэн нь Сүмийн доторх Латин өв болон Латин Америкийн гишүүдийн түүхүүдийг дүрсэлжээ.

Дээрх үзэсгэлэнгүүдийн талаарх нэмэлт мэдээллийг [churchhistorymuseum.org](http://churchhistorymuseum.org)-аас үзнэ үү. ■



## САНАЛ ЗӨВЛӨМЖ

### Бат бөх итгэлтэй байх зориг

Би *Лиахона*-д нийтлэгдсэн зөвлөгөөг өдөр бүр тунгаан боддог. Энэ нь өдөр бүр шийдвэр гаргах болон сайн мэдээгээр тууштай амьдрахад надад тусалдаг. Энэ сэтгүүл бат бөх итгэлтэй байх зоригийг надад өгдөг.

Рамон Кристофер Хиполито Виллюна, Филиппинес

### Шийдвэрлэх боломжгүй мэт санагддаг асуудлуудыг шийдэхэд тусалдаг

*Лиахона*-д нийтлэгддэг захиасууд бат бөх итгэлтэй байхад надад тусалдаг. Шийдвэрлэх боломжгүй мэт санагддаг асуудлыг шийдвэрлэхдээ захиасуудыг дахин уншсанаар төгс шийдлийг олдог. Тэргүүн Зөвлөлийн захиас бичиг, Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн дуу хоолой хэсгүүдийг сэтгүүлдээ заавал оруулж байна уу.

Эвелин Форсон, Гана

### Энэ бол үнэн

*Лиахона* намайг 15 жилийн өмнө Сүмд элссэн цагаас хойш миний хөтөч байгаа билээ. Захиасуудыг нь унших бүрд би Сүнснээс хүчтэй мэдрэмж, сэтгэгдэл хүлээн авдаг. Энэ сэтгүүл уйтгар гуниг төрөх үед надад тайтгарлыг авчирдаг. Дэлхий даяарх Гэгээнтнүүдэд тохиолдсон явдлууд болон Ерөнхий эрх мэдэлтнүүдийн үгсийг унших үед тайтгарал, амар амгалан болон энэ нь үнэн гэсэн мэдрэмж надад төрдөг.

Фелип Юрбина, Коста Рика

Санал зөвлөмжөө [liahona@ldschurch.org](mailto:liahona@ldschurch.org) хаягаар илгээнэ үү. Ирүүлсэн материалуудыг хэмжээ, тодорхой байдлын хувьд хянан засварлаж болно.

## ГЭР БҮЛИЙН ҮДШИЙН САНААНУУД

*Гэр бүлийн үдэшт ашиглаж болох өгүүллүүд болон үйл ажиллагаанууд энэ дугаарт орсон болно. Зарим жишээг доор өгөв.*

### “Аз жаргалд хүрэх үнэн зам,” х. 28:

Энэ өгүүллийг гэр бүлтэйгээ хуваалцсаны дараа дараах асуултуудыг тавь: Одоо бидний гаргадаг шийдвэрүүд ирээдүйн аз жаргалд хэрхэн нөлөөлдөг вэ? Бид зөв шийдвэр гаргаж байгаа гэдэгтээ хэрхэн итгэлтэй байж болох вэ?

### “Боловсролын хүч,” х. 42: Энэ

өгүүллийг зохиогч “Та нар чадах хэрээрээ боловсролтой болох хэрэгтэй” гэж боловсролын талаар Ерөнхийлөгч Гордон Б.Хинклийн хэлсэн үгэнд онцгой ач холбогдол өгчээ. “Ажил хийхэд өөрийгөө тэнцэхээр болгоход шаардлагатай бүхнийг . . . золиосол.” Золиослол болон ажил хөдөлмөрөөс ирдэг адислалуудын тухай гэр бүлээрээ ярилц.

### “Хүмүүнд загасчлахыг заа,” х. 54: Энэ

өгүүллийг гэр бүлтэйгээ унших буюу товч утгыг нь ярилц. Эзра өөртөө тулгарсан хүнд сорилтыг даван туулахын төлөө хэрхэн бэлтгэсэн бэ? Тэнгэрлэг Эцэг Түүнд хэрхэн тусалсан бэ? Танай гэр бүл бэлтгэлтэй байхын тулд юу хийж болох тухай ярилц.

### “Их Эзэнд итгэ,” х. 60: Энэ өгүүллийг

гэр бүлээрээ унш. Залбирал нь хэрхэн хариулагдсан тухай туршлагаа хуваалцхыг гэр бүлийн гишүүдээс хүс. Залбиралд хариулдаг Их Эзэний олон өөр арга замын тухай мөн Түүнд итгэхийн ач холбогдлын тухай ярилц.



### Охины минь асуулт

Би тойргийн бишопын хувьд хүүхдүүддээ гэр бүлийн үдшээр заах боломж олгоход нь эцэг эхчүүдийг дэмждэг. Эхнэр бид хоёр энэ үүргээ биелүүлэхээр шийдсэн юм.

Манай хүү эхлээд заахад залбирлын тухай түүний хичээл бидэнд таалагдлаа. Дараагийн даваа гарагт охины маань ээлж болов. Тэр баптисм хүртээд ердөө хэдхэн сар болж байлаа. Охин маань Бурханы бүтээлт сэдвээр хичээл заах байв. Түүнийг жинтэй асуултууд асуухад бид хариулж байлаа. Хичээлээ тэр өөрийнхөө гэрчлэлээр дуусгав.

Гэтэл манай хүү “Чи хичээл заасангүй ш дээ, зөвхөн асуултууд л асуулаа” гэв. Гэвч миний эхнэр охины нэг асуултанд хариулахдаа гэр бүлүүдийг бий болгосны

төлөө бас хайраар дүүрэн нөхөртэй гайхамшигтай гэр бүлийг өгсний төлөө Бурханд талархалтай байдаг гэж хэлсэн нь надад маш сайхан санагдсан гэдгээ би гэр бүлийнхэндээ хэллээ. “Дэлхийг хэн бүтээсэн бэ?” гэсэн асуултанд манай бяцхан охин сэтгэл нь ихэд хөдөлж, “Есүс” гэж хариулсанд зүрх сэтгэл минь талархлаар бялхан дүүрснийг би гэрийнхэндээ хэлсэн. Манай гэрийнхний бусад олон хариултаас энэ сэдвээрх тэдний ойлголт гайхалтай гүнзгий байгааг мэдэж билээ.

Хүүгийн маань бодлоор манай бяцхан охин “заагаагүй ч,” түүний хичээл бас хүүхдүүд маань хичээл заасан гэр бүлийн үдшийн цуглаанууд миний хувьд хамгийн сайхан болсон билээ.

Ричард Айкпегву, Нигери

# БАТ БӨХ СУУРИН ДЭЭР БАРИХ НЬ

**Жошуа Ж.Пёрки**

Сүмийн сэтгүүлүүд

Өргөн уудам Огайо мөрнөөс холгүй Кентакийн Люисвиллийн захад Анкорож хэмээх нэг жижигхэн хот байдаг. Усан онгоцны ахмад сүүлчийн боомтоо байгуулсан газарт аж төрж байсан хөдөө аж ахуй эрхлэгчдийн хувьд энэ газар олон шашны гэр бүлүүдийн өлгий нутаг болжээ.

Сүм дээр хүмүүсийн гэр оронд байсан цагаан агч, царс, агч, туулайн бөөр, бургас моддын доорх гайхамшигтай ертөнцийг шинжлэн судалж явахдаа би Христийн шашны тулгуур сургаалуудын нэг: Есүс мастер багш болж ирэн, нинжин сэтгэлтэй, шударга зарчимч байх арга замуудыг бидэнд заасныг мэдсэн билээ.

Миний эцэг эх хоёр сүмдээ итгэлтэй, сайн хүмүүс байсан юм. Аав ээж хоёр хэрхэн сайн хүн байхыг мөн бусад хүмүүст эелдэг хандах зэрэг нь зөв зүйл, харин хулгай хийх зэрэг нь буруу гэдгийг надад заадаг байлаа. Нөгөө талаар нэг хүний зөв гэж итгэдэг зүйлийг өөр хүмүүс бас зөв гэж боддог бол энэ нь үнэмшилтэй байна гэдгийг надад заадаг байлаа, бүр эдгээр итгэл үнэмшил нь тулгуур зарчмын хувьд ялгаатай байсан ч тэр шүү. Миний ойлгосноор энэ үзэл баримтлалаар бол мөнхийн зарчмууд нь хүн бүрийн хувьд үнэн биш бөгөөд зөвхөн оюуны өндөр чадавхтай хүмүүс тэдний хувьд юу зөв болохыг тодорхойлох эрх үүрэгтэй гэсэн хувийн үзэл бодол юм.

Ёс суртахууны харьцангуйн онолын тэрхүү сургаалаас болж, Мормоны номлогчдын заасан Цагаатгалын хэрэгцээ, санваарын эрх мэдэл, бошиглогчдод итгэх нь надад



*Гэрчлэл  
гуйвшгүй  
бат бөх  
болж чадна.*

үнэхээр хэцүү байлаа. Чухамдаа хөрвөлт уруу хийсэн миний аян бүтэн зургаан жил болсон бөгөөд би хэн юм бэ? би юунд итгэдэг хүн бэ? үнэн ба алдаа, нүгэл ба түүний үр дагаврын тухай үүрд мөнхийн үнэнүүдийг бий болгосон Бурхан үнэхээр байдаг гэж үү? гэсэн үй түмэн асуулт намайг зовоосор байлаа.

Гайхалтай нь би сүнсний баталгааг хүлээн авлаа. Гэвч үүнийг хүлээн авахуйц

даруухан болтол сүнсний баталгаа надад ирээгүй юм. Эхлээд баптисмын гэрчлэл дараа нь Мормоны номынх тэгээд Иосеф Смит бол үнэн бошиглогч гэсэн гэрчлэл ирсэн. Дараа нь өнөөдрийн бошиглогчид, төлөөлөгчдийн тухай нэмэлт гэрчлэлүүд

дараа дараагаар ирсэн юм.

Эцэст нь би сайн мэдээ үнэн гэдэгт итгэдэг төдийгүй үүнийг мэддэг болсон юм. Олон жижиг гэрчлэлийн охь манлай нийлсээр итгэл минь бат бөх болсон суурийг бүрдүүлсэн бөгөөд энэ нь миний гэрчлэлийг бусниулсан сорилтын эсрэг хамгаалалт болсон билээ.

Их Эзэнээс хариу хүсэн хүлээх нь бидний бурханлиг эрх юм. Бидний гэрчлэл бат бөх байхын тулд бид өөрсдийгөө өдөр бүр сүнслэг тэжээлээр тэжээж байх ёстой. Гэвч бид нэгэнт гэрчлэлтэй болсон зарчмуудын талаар дахин дахин асуух нь Их Эзэний хөтөлбөрт үр ашиггүй юм гэдгийг би бас мэднэ. Хэрэв тэгвэл энэ нь эцэстээ урвалт уруу хөтөлдөг юм.

Би залуу үеийнхээ ёс суртахууны сургаалтай зууралдахаа нэгэнт больсон. Бошиглогчид бидэнд хандан ярихад түүний үгс Бурханаас ирж байгааг би мэддэг. Миний гэрчлэлийг сорих нөхцөл байдал бий болоход би өмнө нь хүлээн авсан гэрчлэлдээ итгэдэг тэгээд үүгээрээ амьдрахын тулд чадах бүхнээ хийдэг. Энэ бол амар амгаланд хүрэх зам; энэ бол аз жаргалд хүрэх зам. ■

# Сүмийн Халамжийн төлөвлөгөө

Бие даасан байдал ба үйлчлэлийн 75 жилийн ойгоо тэмдэглэж байна

Бидний үндсэн зорилго бол . . . тэтгэмж аван, үр бүтээлгүйгээр залхууран суух хөнөөлт хилэнцийг хүмүүсийнхээ дунд үгүй болгох тогтолцоог бий болгож, бие даах чадвар, ажилч хичээнгүй, арвич хямгач чанар, өөрийгөө хүндэтгэх явдлыг байнгын хэвшил болгон хөгжүүлэх явдал юм. Сүмийн зорилго нь хүмүүсийг амьдралаа сайн сайхнаар авч явахад нь туслах явдал мөн. Ажил хөдөлмөр бол Сүмийн гишүүдийн амьдралыг удирдан чиглүүлэгч гол зарчим мөн.

**Ерөнхийлөгч Хебер Ж. Грант** (1856–1945), Conference Report, 1936 оны 10-р сар, 3; мөн *Teachings of Presidents of the Church: Heber J. Grant* (2002), 115-ыг үз.

## ГАРЧИГ

- 82** Тэргүүн Зөвлөлийн захидал
- 83** Их Эзний арга замаар хангах нь
- 84** Арвич хямгач амьдралын 75 жил
- 85** Бие даах чадварын тухай товч ойлголт
- 92** Аврагчийг дагаснаар өрөвч сэтгэлийн үйлчлэлээ дээшлүүлэх нь
- 93** Олны хүч оломгүй далай
- 96** Халамжийн зарчмуудыг амьдралынхаа хэсэг болгох нь



ЕСУС ХРИСТИЙН ХОЖМЫН ҮЕИЙН ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

ТЭРГҮҮН ЗӨВЛӨЛИЙН АЛБАН ГАЗАР

47 EAST SOUTH TEMPLE STREET, SALT LAKE CITY, UTAH 84150-1200




2011 оны 6-р сарын 1

Хүндэт ах эгч нар аа:

Сүмийн халамжийн хөтөлбөр үйл ажиллагаагаа эхэлсний 75 жилийн ой энэ жил тохиож байна. Уг хөтөлбөр хэрхэн эхэлсэн тухай зарим түүхийг дараах хуудсаас үзнэ үү. Эдгээр түүх нь бас Сүмийн олон улсын халамжийн олон үйл ажиллагаа болон дэлхий даяарх Сүмийн гишүүдийн амьдралд баримталдаг халамжийн ажлын зарчмуудыг харуулах болно.

Энэхүү ой нь бие даах чадвараа илүү дээшлүүлж, хүмүүст туслахад Аврагчийн үлгэр жишээг дагахад биднийг урихын хамт энэ тухай сануулагч болдог билээ. Энэхүү тусгай хэсгийг уншиж, халамжийн болон бие даах чадварын зарчмуудын талаар залбиран, тунгаан бодож, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэхэд бид та бүхнийг болон гэр бүлийг тань урьж байна.

Хүндэтгэсэн,

Тэргүүн Зөвлөл

## Их Эзэний арга замаар хангах нь


Үнэт цаасны зах зээл асар их алдагдал хүлээсэн үе байсан юм. Банк болон санхүүгийн бусад байгууллагууд дампуурлаа. Ажилгүйдэл урьд хожид үзэгдээгүйгээр өсөн нэмэгдэж байв. Хүмүүс орон гэргүй болж байлаа. Засгийн газрууд эдийн засгийн уналтыг зогсоохын тулд өндөр өртөг зардалтай хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байв. Улам олон хүн хоол хүнс, эн тэргүүний хэрэгцээт бусад зүйлсгүй тул төрийн байгууллагуудад хандахаас өөр аргагүй байлаа.

1930-аад онд тохиолдсон эдийн засгийн хямрал саяхан бас тохиосон билээ. Сүмийн халамжийн хөтөлбөр тэр үед ч “хүмүүст амьдралаа өөд татахад нь тусалж байсан” шиг мөн эдүгээ<sup>1</sup> байгалийн гамшиг бүх нийтийг хамарсан эдийн засгийн уналт, хямралын үед түүнчлэн хувь хүмүүс болон гэр бүлүүдэд байнга тохиолддог жижигхэн сорилт бэрхшээлүүдэд ч тусалсаар байгаа билээ.

Өнөөдрийн энэ халамжийн хөтөлбөрийг 1936 оныг хүртэл албан ёсоор зохион байгуулаагүй ч үе үеийн Гэгээнтнүүд арвич хямгач амьдралын зарчмуудыг амьдралд хэрэгжүүлсээр ирсэн билээ. Учир нь халамжийн хөтөлбөрийн уран барилгач нь Аврагч Есүс Христ юм. ‘Мөн агуулах нь сүмийн өргөлүүдээр зохицуулагддаг байх ёстой; мөн бэлэвсэн хийгээд өнчин хүмүүс тэрчлэн ядуусын адилаар хангагдах ёстой’ гэж Их Эзэн мэдэгдэхдээ арга замыг нь ч заасан юм. (С ба Г 83:6) Энэхүү арга замыг сануулагч нь дараах үгс юм. ‘Харин энэ нь миний өөрийн замаар хийгдэх ёстой нь шаардлагатай билээ.’ (С ба Г 104:16).<sup>2</sup>

Бид Их Эзэний арга замаар хангахын тулд эхлээд өөрсдийнхөө бие даах чадварыг хөгжүүлээд дараа нь бусдад бие даах чадвартай болоход нь туслах ёстой. Сэтгэл зүрхээ бүрэн зориулдаг эрэгтэй, эмэгтэйчүүд энэхүү өргөн цар хүрээтэй, сүнслэг нөлөө бүхий хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тусалж байна. Учир нь энэ хөтөлбөр Их Эзэний арга замд итгэх итгэлээр дамжин хэрэгждэг юм” гэж Ерөнхийлөгч Монсон хэлжээ.<sup>3</sup>

Энэ онд тэмдэглэсэн халамжийн хөтөлбөрийн 75 жилийн ой нь бие даах чадвартай болох,



ядуучууд, тусламж хэрэгтэй хүмүүсийг анхаарч халамжлах, бусдад үйлчлэх зэрэг үндсэн зарчмуудын талаар тунгаан бодох боломжийг Хожмын Үеийн Гэгээнтнүүдэд олгосон юм. Бид эдгээр зарчмуудаар амьдарснаар зовлон зүдгүүрийг хөнгөвчлөн, зан чанараа төлөвшүүлэх болон эв нэгдлийг хөхүүлэн дэмжих илүү чадвартай болно.

### ЭШЛЭЛ

1. *Teachings of Presidents of the Church: Heber J. Grant* (2002), 115.
2. Томас С.Монсон, “The Way of the Lord,” *Ensign*, 1977 оны 11-р сар, 7.
3. Томас С.Монсон, *Ensign*, 1977 оны 11-р сар, 7.

*Халамжийн хөтөлбөрийн урт хугацааны зорилго бол Сүмийн гишүүдэд, өгөгч болон хүлээн авагчид эцсийн эцэст энэ Сүм оршин тогтнохын үүрэг зорилго, шалтгаан нь болсон сэтгэл санаа, оюун ухааны гүн дэх бүхнийг ил гаргаж, сүнсний нуугдмал баялгийг үр өгөөжтэй цэцэг, үр жимс болгон хувиргах зан чанарыг төлөвшүүлэх явдал мөн.*

Ерөнхийлөгч Бага Ж.Рюбен Кларк (1871–1961), Глен Л.Радд, *Pure Religion: The Story of Church Welfare Since 1930* (1995), 301.

Үе үеийн Гэгээнтнүүд ядуучууд болон тусламж хэрэгтэй хүмүүст анхаарал халамж тавьдаг Аврагчийн үлгэр жишээг дагасаар ирсэн юм.

81-р хуудас дахь гэрэл зургууд—Дээд талд: Солт Лейк хот дахь Бишопуудын төв агуулахад гишүүд ачаа буулгаж байгаа нь 1937 он. Дунд нь: Филипиногийн залуус ногооны талбайд үр суулгаж байгаа нь. Доод талд: Юта дахь нэгэн гадасны халамжийн ферм дээр гишүүд ажиллаж байгаа нь.



## Арвич хямгач амьдралын 75 жил

Сүмийн халамжийн хөтөлбөр албан ёсоор хэрэгжээгүй ч Гэгээнтнүүд бие дааж амьдрах чадвар, ядуучууд болон тусламж хэрэгтэй хүмүүсийг халамжлах, бусдад үйлчлэхийн чухлыг ойлгож, амьдралдаа хэрэгжүүлдэг байлаа. “Бурханы хайраар дүүрэн хүн зөвхөн өөрийнх нь гэр бүл адислагдсанаар сэтгэл ханадаггүй харин бүх дэлхий, бүх хүн төрөлхтнийг адислахын төлөө санаа тавьдаг юм” хэмээн Бошиглогч Иосеф Смит хэлсэн билээ.<sup>1</sup>

Сүм зохион байгуулагдсанаас хойш удалгүй тусламж хэрэгтэй хүмүүст туслахын тулд бишопын жижиг агуулахууд бий болсон юм. Иосеф Смит 1830-аад оны үед Огайогийн Көртландад мацгийн өргөлийг цуглуулах ажлыг санаачлан зохион байгуулжээ.<sup>2</sup> Энэ үед бас аравны нэгийн зарчмыг нэвтрүүлсэн ажээ (С ба Г 119-ийг үз). Аравны нэг болон мацгийн өргөлийг ажил хийх, бүтээгдэхүүн үйлдвэрлэх хэлбэрээр мөн бараа материалуудаар төлдөг байв. Бишопууд болон салбарын ерөнхийлөгчид өнөөдрийнхтэй адил арга замаар бараа материалуудын хуваарилалтад хяналт тавьдаг байлаа.<sup>3</sup>

Эхэн үеийн Гэгээнтнүүдийг амин зуулгаа хэрхэн


залгуулах нь толгойн өвчин болоод байв. Сүмийн удирдагчид болон гишүүд залхууралтай тэмцэхийн тулд амьжиргааны тогтвортой төвшинг бий болгох арга замыг хамтран хайж байлаа. Тэднээс зарим нь Сүмийн барилгууд болон засаг төрийн байгууллагуудаас хэрэгжүүлж байсан ажлын төслүүд дээр ажиллаж байлаа. Зарим хүн ферм дээр ажиллан, зарим нь өөрсдийгөө болон гэр бүлээ тэжээхийн тулд бараа материал зардаг байв. Гэгээнтнүүд хамтран хөдөлмөрлөснөөр хэрэгцээгээ хүрэлцэхүйцээр хангадаг болж адислагдсан юм.

Өнөө үед бидэнд тулгарч байгаа сорилт бэрхшээлүүд өөр ч Гэгээнтнүүд Аврагчийн сургаалууд болон өмнөх үеийнхний үлгэр жишээг дагаснаар өөрсдийгөө тэжээн тэтгэж, ядуучууд, тусламж хэрэгтэй хүмүүст анхаарал халамж тавьсаар байна.

### ЭШЛЭЛ

1. *Teachings of Presidents of the Church: Joseph Smith* (2007), 330–31.
2. Ховард В.Хантер, “Fast Day,” *Ensign*, Nov. 1985 оны 11-сар, 72-ыг үз.
3. Глен А.Радд, *Pure Religion* (1995), 2, 4-ийг үз.

Өнөө үеийн тухай мэдээллийг дараах эх сурвалжуудаас үзэж болно: Сюзан Клейтон Радер, *Supporting the Rescue of All That Is Finest* (2005); Глен А.Радд, *Key Moments in Church Welfare Services* (2008); Глен А.Радд, *Important Events for Historical Church Welfare* (1999); Глен А.Радд, *A Brief History of the Church Employment Program* (1998); Глен А.Радд, *Pure Religion* (1995).



### 1936

- Дөрөвдүгээр сарын 6: Ерөнхийлөгч Хебер. Ж.Грант болон түүний зөвлөхүүд ерөнхий чуулган дээр Сүмийн аюулгүй байдлын төлөвлөгөөг зарлажээ.
- Аравдугаар сар: Сүм Халамжийн Ерөнхий хороог үндэслэн бий болгов.

*“Бид мацаг барих үедээ . . . өлсөж мэднэ. Мөн богинохон хугацаанд өөрсдийгөө өлсгөлөн бөгөөд тусламж хэрэгтэй хүмүүсийн оронд тавин үзэж болно. Бид ингэснээрээ тэдний мэдэрдэг шоовдорлогдмол байдлыг улам сайн ойлгодог. Бид бусдын зовлонг нимгэлэхийн төлөө бишопт өргөл өгснөөрөө зөвхөн тэдэнд буян үйлдээд зогсохгүй бас өөрсдийнхөө хувьд ч гайхамшгийг үйлддэг.*

**Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Жозеф Б.Вертлин** (1917–2008), “The Law of the Fast,” *Лиакона*, 2001 оны 7-р сар, 90; *Ensign*, 2001 оны 5-р сар, 73.



АНУ-ын Калифорнийн Мадера дахь Сүмийн эзэмшлийн усан үзмийн талбайд Гэгээнтнүүд ажилладаг. Энэ талбайгаас хэдэн зуун тонн үзэм хурааж дэлхий даяар илгээдэг.

## Бие даах чадварын тухай товч ойлголт

Олон гишүүн халамжийг түр хугацаагаар хүнд байдалд орсон гишүүдэд туслах хөтөлбөр гэж боддог байж болох юм. Гэвч Сүмийн халамжийн хөтөлбөрийн зорилго үүнээс илүү өргөн хүрээтэй юм. Уг хөтөлбөр нь бие даах чадварыг амьдралын хэв маяг болгон төлөвшүүлэхийг зорьдог. Бие даах чадвар гэдэг нь “өөрийгөө болон гэр бүлээ эн тэргүүний хэрэгцээт зүйлсээр хангах чадвар, шийдвэр төгс байдал хийгээд хүч чармайлт”<sup>1</sup> бөгөөд бидний материаллаг болон *сүнсний сайн сайхан байдлын* нэн чухал элемент мөн хэмээн Ерөнхийлөгч Томас С.Монсон заажээ.<sup>2</sup>

Зөвхөн бие даах чадвартай байх хүсэл хангалтгүй юм. Бид өөрсдийнхөө болон гэр бүлийнхээ хэрэгцээг хангахын төлөө ухамсартай, идэвхтэй хүч чармайлт гаргах ёстой. Бид бие дааж амьдрах чадвартай болохын төлөө чадах бүхнээ хийсний дараа “Их Эзэнд хандан, дутагдаж байгаа зүйлээ итгэлтэйгээр асууж болно” хэмээн Тэргүүлэх Бишоп Давид Бертон бидэнд сануулсан юм.<sup>3</sup> Бие даах чадвартай байх нь бусдыг адислах боломжийг бидэнд олгодог. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Роберт Д.Хейлс: “Бид гагцхүү бие даах чадвартай байсан тохиолдолд л бусдад үйлчилж, тэднийг адислах талаар Аврагчийг жинхэнэ ёсоор дуурайж чадна” гэж хэлсэн байдаг.<sup>4</sup>

Бие даах чадварт чинээлэг хангалуун амьдралын



Зүүн дээд талд: 1947 онд Нидерландын Гэгээнтнүүд Шерманы Гэгээнтнүүдэд зориулж тарьсан төмсөө ачуулж байгаа нь. Дээд талд: Эквадор дахь хүнс үйлдвэрлэлийн сургалт хүнсний ногооны арвин ургац хураахад гишүүдэд тусалжээ.



**1937**

- Сүм Солт Лейк хотод Бишопуудын төв агуулахыг үндэслэн бий болгов.



**1938**

- Солт Лейк хотод Халамжийн Талбай дахь газрыг худалдан авч барилгын ажил эхлэв.
- Дөрөвдүгээр сар: Сүмийн аюулгүй байдлын төлөвлөгөөг “Сүмийн халамжийн төлөвлөгөө” болгон нэрийг нь өөрчлөв.
- Наймдугаар сарын 12: Сүм Солт Лейк хотод Дезерет аж үйлдвэрийн анхны дэлгүүрийг нээв.



нэлээд хэдэн үзүүлэлт түүний дотор боловсрол, эрүүл мэнд, ажил эрхлэлт, гэр бүлийн хүнсний нөөц болон санхүү, сүнсний хүч чадал ордог.

### 1. Боловсрол

Их Эзэн бидэнд “судлахаар мөн тэрчлэн итгэлээр суралцахыг эрэлхийлэхийг” (С ба Г 88:118) зарлиг болгосон билээ. Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли (1910–2008) заасан нь: “Бид боловсролд итгэдэг. Сүм боловсролд дэмжлэг үзүүлдэг. Сүмийн гишүүн бүрд чадах чинээгээрээ боловсролтой болох, Их Эзэнээс ирсэн заавал биелүүлэх ёстой нэг үүрэг байдаг. . . . Хожмын Үеийн Гэгээнтнүүд оюун ухаан, гар хоёроо хоёуланг нь хөгжүүлэх үүрэгтэй гэсэн Их Эзэний онч мэргэн үг байдаг.”<sup>5</sup>

Бүгд Найрамдах Доминикан Улсын иргэн Роберто Элийт Гонзалез номлолоосоо буцаж ирсний дараахан коллежид элсэн боловсролтой болох зорилго тавьсан байлаа. Аав нь Робертог зөвхөн хичээлдээ бүхий л анхаарлаа төвлөрүүлэхэд нь туслахын тулд сургалтын төлбөрийг төлөхийг зөвшөөрсөн ч удалгүй гэр бүлээ санхүүгийн хүндхэн байдалд орхин, нас баржээ.

Роберто сургуулиасаа гарч, өөрийгөө болон ээж, дүү хоёроо тэжээхээр ажил хийж эхлэв. Сургуулиа яаж төгсдөг юм билээ гэсэн бодол санаанд нь үргэлж байх болов.

Хэдэн долоо хоногийн дараа Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли (1910–2008) хөгжиж байгаа орнууд дахь залууст “өмнөх хэдэн үеэрээ туулж ирсэн ядуурлаас гарахад нь” туслах “зоримог санаачилга” болгон Боловсролын Тасралтгүй Санг зарлав.<sup>6</sup> Роберто өргөдөл гарган БТС-гийн зээлд хамрагдсанаар цаашид сургуульдаа суралцах боломжтой болжээ. Энэхүү боломж нь зөвхөн санхүүгийн тулгамдсан хэрэгцээг шийдвэрлэх төдийгүй гэрлэж, үүрд мөнхийн гэр бүлтэй болох итгэлд нь Робертод тусалжээ. Учир нь гэр бүлээ тэжээж чадна гэдгээ тэр мэдэж байв.

Роберто анагаах ухааны сургууль төгсөөд бишопоор үйлчилж байхдаа Доминиканы Анагаах Ухааны Сургуулиудын Үндэсний Зөвлөлийн бүрэлдэхүүнд орсон Сүмийн анхны гишүүн болсон аж. “Хамгийн сайн үр дүн нь гэр оронд минь гарсан юм. Манай гэр бүлд том өөрчлөлт гарлаа. Бид ядуурлаас бүрмөсөн гарах болно” гэж тэр хэллээ.

*“Энэ амьдралд бидний сурч мэдсэн бүх зүйл Амилуулалтаар бидэнтэй хамт сэргэх болно гэдэг нь үнэн юм. Бидний сурч мэдсэн бүх зүйл бидний үйлчлэх чадварыг нэмэгдүүлэх болно.”*

Тэргүүн Зөвлөлийн нэгдүгээр зөвлөх **Ерөнхийлөгч Хенри Б.Айринг** “Education for Real Life,” *Ensign*, 2002 оны 10-р сар, 21.”



**1939**

- Халамжийн Талбайд анхны агуулах, лаазалсан бүтээгдэхүүний үйлдвэр үйл ажиллагаагаа эхлэв.



**1940**

- Наймдугаар сарын 27: Ерөнхийлөгч Давид О.МкКей Халамжийн Талбайд дахь үр тарианы агуулахыг онцгойлон адислав. Үр тарианы агуулахыг барихад Сүмийн гишүүд 70,000 гаруй цагийг зарцуулжээ.

**1941**

- Дөрөвдүгээр сарын 20: Халамжийн Талбайд сүү боловсруулах анхны үйлдвэр үйл ажиллагаагаа эхэлжээ.





Зүүн цаад талд: ХҮГ оюутнууд өнөөгийн өрсөлдөөнт дэлхийд эрч хүч, чадвар, бэлтгэлтэй байхын төлөө эрдэм номд шамдан суралцаж байна. Зүүн талд: Дасгал болон сайн хоол тэжээл нь бид биедээ хүндэтгэлтэй хандаж, биеэ арчилж тордоход нэн чухал юм.

“Хүү маань миний амьдралаар амьдрахгүй болсонд би баяртай байдаг. Яагаад гэвэл бид ядуурлаас гарч чадсан шүү” гэж түүний ээж өгүүлэв.

Нэмэлт мэдээллийг [providentliving.org](http://providentliving.org) -ийн Education and Literacy хэсэгт орох буюу Хожмын Үеийн Гэгээнтэн залуучуудад дээд боловсролтой болоход бэлтгэхэд нь туслах [besmart.com](http://besmart.com) вэбхуудсаас үзнэ үү.

## 2. Эрүүл мэнд

Бид Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн учраас (Эхлэл 1:27-г үз) бидний бие ариун сүм бөгөөд бид биемахбоддоо хүндэтгэлтэй хандаж, анхаарал тавьж байх ёстой (1 Коринт 3:16–17-г үз).

Сургаал ба Гэрээ 89 дэх Мэргэн Ухааны Үг бол Их Эзэний эрүүл мэндийн хууль бөгөөд 1833 онд Иосеф Смитэд илчлэгдсэн юм. Мэргэн Ухааны Үг бид тэжээллэг хоол хүнс хэрэглэж, хортой бодисуудаас зайлсхийх ёстойг заадаг. Төлөөлөгчид, бошиглогчид тэр цагаас хойш бидний биемахбод, оюун ухаанд хортойгоор нөлөөлж, донтолт уруу хөтөлж болох бүх төрлийн бодис, дадал зуршлаас зайлсхийх ёстойг сургасаар ирсэн билээ.<sup>7</sup>

Фижийн Сейнимере Баленакаги өсвөр насандаа Сүмийн гишүүн бус найзынхаа хуриманд оролцож энэ сургамжийг мэджээ. Хуриман дээр олон хүн, түүний дотор Сейнимерегийн найз нар архи ууж, тамхи татан түүнийг архи уухыг ятгажээ. “Би бүх амьдралынхаа турш сайн мэдээний жишгүүдээр

амьдрах ёстой гэж заалгасан болохоор өчүүхэн ч эргэлзээгүйгээр тэдний саналаас татгалзсан” гэж Сейнимере яриу.

Мэргэн Ухааны Үгэнд үнэнч байснаас ирдэг адислалууд зөвхөн бие бялдрын эрүүл мэндээр хязгаарлагдадаггүйг тэр мэддэг ажээ: “Би Ариун Сүнсэнд ойр дотно байдаг учраас зөв сонголтууд хийж чадна гэдгийг мэддэг нь надад нэмэлт хамгаалалт болдгийг мэдсэн. Жишгүүд бидний эрх чөлөөг хязгаарладаггүй, харин эрх чөлөөг хязгаарлахад хүргэдэг үр дагавруудаас биднийг хамгаалдаг.”

Дэлгэрэнгүй мэдээллийг [providentliving.org](http://providentliving.org)-ийн Physical Health хэсгээс үзнэ үү.



Сейнимере Баленакаги Мэргэн Ухааны Үгийг дагаснаас ирдэг материаллаг болон сүнсний адислалудыг мэддэг.

*“Бидний бие үнэхээр Бурханы ариун сүм мөн. Тиймээс та бид ариун сүм дотроо юу оруулах дээр нь юу тавих, ариун сүмийнхээ талаар юу хийж түүнийг хэрхэн арчилж хамгаалахыг сайтар эргэцүүлэн бодох ёстой.”*

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын **Ахлагч Давид А.Беднар** “Ye Are the Temple of God,” *Ensign*, 2001 оны 9-р сар, 18.



**1948**

- Гуравдугаар сарын 1: Сүм бүс нутгийн ажил эрхлэлтийн албыг Солт Лейк хотод нээв.



**1960**

- Гуравдугаар сар: Халамжийн Талбай дахь сүү боловсруулах шинэ үйлдвэр баригдаж дуусав.

**1963**

- Халамжийн Талбай дахь гоймонгийн үйлдвэр, лаазалсан бүтээгдэхүүний шинэ үйлдвэр үйл ажиллагаагаа эхлэв.



Дээд талд: Мексик дэх ажил эрхлэлтийн албанд залуу эмэгтэйд тусалж байгаа нь. Дээд талд: Бразилын Сан Пауло дахь ажил эрхлэлтийн алба Осеиас Портинари: "ажилгүй гишүүдэд амьдралыг өөдрөгөөр харах үзлийг төлөвшүүлсэн юм" гэж хэллээ.

### 3. Ажил эрхлэлт

Ажил олох нь олон тойрог, салбарын гишүүдэд бие даах чадвартай болоход учирч байгаа хамгийн тулгамдсан асуудал байдаг Санваартны чуулгууд болон тойргийн зөвлөлийн гишүүд ийм гишүүдэд тусалж чадна. Тэд нийгмийн эх сурвалж болон ажлын боломжуудыг тогтоож, тусламж хэрэгтэй хүмүүст нэг бүрчлэн тусалж, нягт хамтран ажиллаж чадна ба ингэж ажиллах ёстой. Гишүүд, тусламж хэрэгтэй хүмүүсийг адислахын төлөө итгэлтэйгээр хамтран ажиллах нь хүч чармайлт гарган амжилтад хүрэхэд нь түлхэц болдог.

Сүм дэлхийн зарим бүсд ажил эрхлэлтийн албыг байгуулаад байна. Эдүгээ 56 оронд ажил

*"Юмсыг зөвхөн хамгийн сайнаар хийх төдийгүй их, бага ямар ч ажилд чадлаа бүрэн дайчилж ажиллахыг Тэнгэрлэг Эцэг биднээс хүсдэг билээ."*

Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх, Ерөнхийлөгч **Диетер Ф.Угдорф**, "Two Principles for Any Economy," *Лиакхона ба Ensign*, 2009 оны 11-р сар, 56.

мэргэжлийн сургалт, сүлжээний уулзалт, хүн бүрийн онцлогт тохирсон ажлын зөвлөгөө өгөх зэрэг үйлчлэл үзүүлдэг ажил эрхлэлтэд дэмжлэг үзүүлэх 300 гаруй төв ажиллаж байна. LDSjobs.org Сүмийн шинэ вэбхуудас бас ажил хайгч, ажил олгогчид болон Сүмийн удирдагчдад зориулсан эх сурвалжуудаар хангаж байна.

Бразилын Осеиас Портинари ажлаасаа гараад хоёр сар гаруй шинэ ажил хайжээ. Ажил олж чадсангүй тул Бразилын Сан Пауло дахь ажил эрхлэлтийн албанд сайн дураараа ажиллаж цагийг өнгөрүүлдэг байв. Ажил хайхад бусдад тусалдаг байсан нь Осеиаст ажлын талаар ярилцлага хийх болон ажил хайх ур чадварыг дээшлүүлсэн ажээ. Ажил мэргэжилтэй болох сургалтыг нэлээд хэдэн удаа явуулсны эцэст зааварлагч болсон гэнэ. Осеиас хичээл зүтгэл гарган бусдад тусалж байтал өөрт нь ажлын ярилцлагад орох урилга ирэхэд нь ихэд гайхсан аж.

Сүмийн эх сурвалжууд ажилгүй гишүүдэд амьдралыг өөдрөгөөр үзэх үзэл төлөвшүүлдэгт нь Осеиас талархалтай байдаг гэнэ. "Хэрэв бид хичээвэл Их Эзэн үүд хаалгыг нээж өгдгийг би мэднэ" гэж тэр хэлэв.

Нэмэлт мэдээллийг [LDSjobs.org](http://LDSjobs.org), [employment.lds.org](http://employment.lds.org)-г орж үзэх буюу хамгийн ойрхон байгаа ажил эрхлэлтийн албайас авна уу.

### 1973

- Сүм гэр бүлүүдэд туслахын тулд ХҮГ Нийгмийн Үйлчлэлийг бий болгов.



### 1976

- Халамжийн барилга байгууламжууд Нэгдсэн Улс, Канад даяар өргөжиж эхлэв.
- Гуравдугаар сарын 29: Халамжийн Талбайд бишопуудын шинэ агуулах баригдаж дуусав.

### 1978

- Сүм байгалийн гамшигт нэрвэгдсэн дэлхий даяарх сая сая хүнд туслахын тулд Онцгой байдлын хороог байгуулав.

#### 4. Гэр бүлийн үйлдвэрлэл ба нөөц

Сүм 2007 онд *All Is Safely Gathered In: Family Home Storage* нэртэй гэр оронд хүнс нөөцлөх энгийн арга хэлбэрийн тухай товхимол гаргасан билээ. Тэргүүн Зөвлөл дэлхий даяарх гишүүдийг үндсэн хэрэглээний хүнсний зүйлс, ус болон мөнгөн хадгаламжтай болохыг дэмждэг. Гишүүд хүнсний зарим бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх буюу худалдаж авахын хамт боломжийнхоо хэрээр долоо хоног бүр бага багаар мөнгө хадгалах замаар эхэлж болно. Гишүүд энэ байдлаар хүнсний болон хэрэгцээгээ хангах санхүүгийн нөөцтэй болж чадна.<sup>8</sup>

Венесуэлийн Валенсийн Лугогийн гэр бүл энэ зөвлөгөөг хэрэгжүүлснээр гэрийн нөөцөө бүрдүүлэхэд сүнслэгээр нөлөөлөгджээ. Тэднийхэн долоо хоног бүр бага багаар хүнс, ус, мөнгө хадгалж эхэлсэн гэнэ. Хэдийгээр тэдний нөөц хомсхон ч хэдхэн сарын дараа бага хэмжээний нөөцтэй болж чадсан байна. Тэр жил хожуухан Венесуэлд болсон ажил хаялт олон ажилчдыг ажилгүй болгосон аж. Ажилгүй болсон хүмүүсийн дунд Омар Луго ах байлаа.

Луго ах шинэ ажилтай болтол бараг хоёр жил өнгөрсөн гэнэ. Тэр үед Луго ах, гэрийнхнийхээ хамт хуримтлуулсан хадгаламж болон хүнсний нөөцөөрөө амьдарч байжээ. Луго ахынхан бэлтгэлтэй байсан учраас сорилтонд санаа амар, сэтгэл тайван байжээ. Тэд гэрийн нөөцийг алгуураар бүрдүүлэх зөвлөгөөг дагаснаар тодорхой биш ирээдүйг итгэлтэйгээр уртсан гэнэ.<sup>9</sup>

Нэмэлт мэдээллийг [providentliving.org](http://providentliving.org)-ийн Family Home Storage хэсгээс эсвэл *All Is Safely Gathered In: Family Home Storage* товхимлоос үзнэ үү.



Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улс дахь гэр бүлүүд шуулжийн ишийг хүнсэнд хэрэглэдгээс гадна үндсийг нь боловсруулан гурил хийж өдөр тутмынхаа хэрэгцээнд ашиглахаар урт хугацаагаар нөөцөлдөг ажээ. Тэд шуулж тарьж, ургуулахад хамтран ажилладаг.

*“Энэхүү шинэ [гэрийн хүнс нөөцлөлтийн] хөтөлбөрийг хүн бүр хэрэгжүүлж чадна. Анхны алхам бол ердөө л эхлэх. Хоёр дахь алхам нь үргэлжлүүлэх. Бид хэдий хэмжээний хүнсийг хэр зэрэг хурдан нөөцлөх нь хамаагүй харин боломжийнхоо хэрээр эхэлснээ үргэлжлүүлэх хэрэгтэй.”*

Тэргүүлэх Бишоп Х.Давид Бертон, “Family Home Storage: A New Message,” *Лиахона*, 2009 оны 3-р сар, 14; *Ensign*, 2009 оны 3-р сар, 60.



#### 1980-аад он

- Нэгдсэн Улсаас гадна Аргентин, Чили, Парагвай, Уругвайд анхны ажил эрхлэлтэд дэмжлэг үзүүлэх төв байгуулагдав.

#### 1981

- Сүм Халамжийн Талбай дээр Дезерет аж үйлдвэрийн дэлгүүр байгууллаа.



#### 1982

- Есдүгээр сарын 10: АНУ-ын ерөнхийлөгч Рональд Рейган Ютагийн Огден дахь халамжийн барилга байгууламжуудаар айлчлав.



Гэр бүлийн төсөв зохиодог нь санхүүдээ “чанд хяналт” тавихад нь тусалдаг гэж Девон Стефенс, Майкала Стефенс нар ярих.

### 5. Гэр бүлийн санхүү

Арвич хямгач амьдралын өөр нэг тал нь орлого, зарлагаа ухаалгаар тэнцүүлэн зарцуулах явдал. Тэргүүн Зөвлөл ийн зөвлөжээ:

“Хямгач байж, өр тавихаас зайлсхийхэд өөрсдийгөө сахилгажуулахыг бид та бүхнээс хичээнгүйлэн хүсч байна. . . .

“Хэрэв та өр төлбөрөө төлчихөөд цаана нь санхүүгийн бүр бага ч гэсэн нөөцтэй байвал та өөрөө бас гэр бүл тань илүү аюулгүй, амар

тайван байж, зүрх сэтгэлдээ агуу амар амгаланг мэдрэх болно.”<sup>10</sup>

Гэр бүлийн санхүү амжилттай байх нь аравны нэг болон өргөлүүдээ төлөхөөс эхэлдэг. Гишүүд амьдралдаа Их Эзэнийг нэгдүгээрт тавьсан үед өөрсдөдөө болон өрөөл бусдад илүү сайн анхаарал халамж тавьж чадна.

Мөнгөө амжилттай зарцуулах өөр нэг хүчин зүйл бол мөнгө таныг хянах биш, харин та орлого, зарлагадаа хяналт тавьж, тооцож байх явдал мөн. АНУ-ын Аризоны Девон Стифенс, Майкл Стифенс нар төсөв зохиож, сар бүр хэдий хэмжээний мөнгө зарцуулдаг тодорхойлжээ. Гэвч төсвийг төрөл зүйлээр хийсэн нь “бүтэх бүтэхгүй олон санаанаас өдөр тутмын бодит амьдралын хөрсөн дээр бууж ирэхэд” бидэнд тусалсан юм гэж Майкл хэллээ. “Бидэнд бодсоноос бага мөнгө байгааг мэдээд сэтгэл түгшсэн ч бүхнийг хяналтандаа авсандаа урамтай байсан шүү.”

Нэмэлт мэдээллийг [providentliving.org](http://providentliving.org)-ийн Family Finances хэсэгт орох буюу *All Is Safely Gathered In: Family Finances* товхимлоос үзнэ үү.

*“Бид өөрсдийгөө болон гэр бүлээ материаллаг болон сүнслэг байдлын хувьд хангах үүрэг хариуцлагыг хүлээдэг. Бид арвич хямгач амьдралын зарчмуудыг хэрэгжүүлэх ёстой. Нөөц боломжийнхоо хэмжээгээр өөдрөг өрнүүн амьдрах, байгаа юмандаа сэтгэл хангалуун байж, хэт их өр тавихаас зайлсхийн, ухаалгаар арвилан хэмнэж, хүнд үе болон онцгой байдалд бэлтгэлтэй байх нь үүнд орно.”*

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын **Ахлагч Роберт Д.Хейлс**, “Becoming Provident Providers Temporally and Spiritually,” *Лиакона ба Ensign*, 2009 оны 5-р сар, 8.

#### 1983

- Тэргүүлэх Бишопын Зөвлөл халамжийн хөтөлбөрийг удирдан зохион байгуулах болов.

#### 1985

- Сүмийн Хүмүүнлэгийн Тусламжийн хөтөлбөр үйл ажиллагаагаа эхлэв.



#### 1990-ээд он

- Дэлхий даяарх ядуурал болон байгалийн гамшигт нэрвэгдэгсдэд илүү хувцас, бусад бараа бүтээгдэхүүнийг ачуулах зорилгоор Хүмүүнлэгийн Тусламжийн төв байгуулагдав.

#### 1996 он

- Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн энэрлийн байгууллагыг зарим орныг сонгон хүмүүнлэгийн үйл ажиллагааг хөхүүлэн дэмжих засгийн газрын бус байгууллага болгон үүсгэн байгуулав.<sup>1</sup>
- Нэгдсэн Улсаас гадна Мексикт анхны бишопуудын агуулах болон гэрийн хүнсний нөөцлөлтийн төвийг байгуулав.
- Халамжийн Талбайн шинэчлэн засварлалт эхлэв.

## 6. Сүнсний хүч чадал

Сүнслэг байдал нь бидний материаллаг болон мөнхийн сайн сайханд амин чухал юм. Бидэнд хүнд сорилтууд тохиолддог. Сүнслэг байдлаа дээшлүүлэхийн төлөө хичээн чармайх нь сорилт бэрхшээлүүдийг амжилттай даван туулахад бидэнд тусалж, сайн сайхан цаг ирэх найдварыг төрүүлнэ.

Эдүгээ Францад амьдарч байгаа Мадагаскарын иргэн Нирина Жозефсон Рандриамихарисоа боловсролтой болох зорилгоо биелүүлж байна. Тэр анх ирээд ганцаардаж, гэрээ санажээ. “Залбирах, судар унших болон Ариун Сүнсний намуухан шивнээгээр дамжуулан амар амгаланг эрж хайдаг байлаа” гэж Нирина яриу. “Эдгээр зүйлс намайг Тэнгэрлэг Эцэг болон Аврагчид улам ойртуулж, би амар амгаланг мэдрэх болсон.”

Хэсэг хугацаа өнгөрөхөд Нирина найз нартай болж, Сүмийн үйл ажиллагаануудад оролцон, баяртай байх болжээ. Гэвч гэрээс нь ирсэн эмгэнэлт мэдээ түүнийг ихэд балмагдуулав. “Нэг өглөө ах минь нас барсан тухай мэдээ хүлээж авлаа. Тэрхүү эмгэнэлт мэдээг хүлээж аваад яах ч учраа олсонгүй. Дараагийн сар өдрүүдэд би ганцаардал, уур уцаар, цөхрөл гунигтай тэмцээдлээ. Бүр хамгийн энгийн юмсыг хийх нь ч их хэцүү болов.”

Хэдэн сарын дараа дотны нэг найз маань хорвоог орхив. Хэлж ирээгүй хийсч ирсэн энэхүү уй гашуу Ниринагийн сэтгэлийг улам эмзэглүүлжээ. Нирина сүмд явахдаа больдог ч юм уу гэж бодсоноо эхний үед мөн л иймэрхүү хүнд үе тохиолдоход түүнийг тулж дэмжсэн тэр зүйлс одоо ч түүнд урам дэм өгч буйг ухаарлаа.

“Би Францад анх ирээд залбирах, судар унших, Ариун Сүнсийг сонсох замаар тайтгарлыг эрж хайсан. Би чухам үүгээр дамжуулан Сүнс болон үүрд мөнхийн гэр бүлийн тухай сургаал бидэнд тайтгарал авчирдгийг, Есүс Христийн Цагаатгал бидний амьдралд бодитой нөлөө үзүүлдгийг улам хүчтэйгээр мэдэрч билээ” хэмээн тэр өгүүлэв.

“Бидэнд ямар ч хүнд сорилт тохиолдсон Их Эзэнтэй хамт байсан цагт түүнийг даван туулахад ‘мухардалд орно’ гэж байдаггүй юм. Түүний төлөвлөгөө бол аз жаргалын төлөвлөгөө.”

Бие даах чадвар болон арвич хямгач амьдралын тухай нэмэлт мэдээллийг [providentialiving.org](http://providentialiving.org) дахь *Providing in the Lord's Way: Summary of A Leader's Guide to Welfare* хэсгээс олон хэлээр үзэж болно.

## ЭШЛЭЛ

1. *Их Эзэний арга замаар хангах нь: Халамжийн талаарх удирдагчийн товч лавлах* (товхимол, 2009), 1.
2. Томас С.Монсон, “Guiding Principles of Personal and Family Welfare,” *Tambuli*, 1987 оны 2-р сар, 3; *Ensign*, 1986 оны 9-р сар, 3.
3. Х.Давид Бертон, “The Blessing of Work,” *Лиахона*, 2009 оны 12-р сар, 37; *Ensign*, 2009 оны 12-р сар, 43.
4. Роберт Д.Хейлс “A Gospel Vision of Welfare: Faith in Action,” *Basic Principles of Welfare and Self-Reliance* (товхимол 2009), 2.
5. *Teachings of Gordon B. Hinckley* (1997), 724.
6. Гордон Б.Хинкли, “The Perpetual Education Fund,” *Лиахона*, 2001 оны 7-р сар, 62; *Ensign*, 2001 оны 5-р сар, 52.
7. Жишээ нь: Рассел М.Нелсон, “Addiction or Freedom,” *Ensign*, 1988 оны 11-р сар, 6; М.Рассел Баллард, “O That Cunning Plan of the Evil One,” *Лиахона*, ба *Ensign*, 2010 оны 11-р сар, 108.
8. *All Is Safely Gathered In: Family Home Storage*, (товхимол, 2007)-г үз.
9. “Family Home Storage: A New Message,” *Лиахона*, 2009 оны 3-р сар, 12–13; *Ensign*, 2009 оны 3-р сар, 58–59.
10. *All Is Safely Gathered In: Family Finances* (товхимол, 2007).



Сайн мэдээний дагуу амьдрах нь хамгийн хүнд үед бидний сэтгэл санааг өргөдгийг Нирина Жозефсон Рандриамихарисоа мэджээ.

“Хүчирхэг гэрчлэл амар амгалан, тайтгарал, бат бөх итгэлийг бий болгодог. Аврагчийн сургаалуудыг байнга дагавал амьдрал сайхан, ирээдүй аюулгүй, замд хөндөлсөх сорилт бэрхшээлүүдийг даван туулах хүч чадалтай байх болно гэдэг итгэл үнэмшил бат бөх гэрчлэлийн үндсэн дээр бий болдог билээ. Залбирал болон судруудын сургаалыг тунгаан бодсоноос ирдэг үнэний мэдлэгийн ачаар гэрчлэл өсөн бэхждэг. Гэрчлэл нь эдгээр үнэнүүдээр итгэлтэйгээр амьдарсан үед амлагдсан адислалуудыг олж авах болно гэсэн баттай итгэл үнэмшлээр тэжээгдэн өсч хөгждөг.”

**Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Ричард Г.Скотт** “The Transforming Power of Faith and Character,” *Лиахона* ба *Ensign*, 2010 оны 11-р сар, 46.



### 1997 он

- ХҮГ Нийгмийн Үйлчлэл нэг жилд 629 хүүхэд үрчлүүлэхэд зуучилсныг бүртгэсэн нь XX зууны хамгийн өндөр үзүүлэлт юм.<sup>2</sup>



### 1999 он

- Гуравдугаар сар: Халамжийн Ерөнхий Хороо дэлхий даяар 50 ажил эрхлэлтийн албыг шинээр байгуулах санаачлагыг дэмжин батлав.
- ХҮГ Нийгмийн Үйлчлэлийг ХҮГ Гэр Бүлийн Төсөл болгон нэрийг нь өөрчилж, үйл ажиллагаагаа өргөжүүлэв.



## Аврагчийг дагаснаар өрөвч сэтгэлийн үйлчлэлээ өсгөн нэмэгдүүлэх нь

**“Хэн амиа аврахыг хүснэ, тэр нь амиа алдах болно. Харин хэн Миний төлөө амиа алдана, тэр нь амиа аварна”** (Лук 9:24) хэмээн Аврагч сургасан билээ.

Энэхүү анхааруулгын талаар Ерөнхийлөгч Томас С.Монсон ийн хэлжээ: “Хэрэв бид бусдад үйлчлэх талаар санаа тавихгүй бол бидний амьдралын зорилго өчүүхэн юм гэдгийг Аврагч бидэнд анхааруулсан хэрэг гэдэгт би итгэдэг. Зөвхөн хар амиа бодож амьдардаг хүмүүс эцэстээ уруудан доройтож, чухамдаа амиа алддаг бол бусдад үйлчлэхийн төлөө өөрийгөө умартдаг хүмүүс дэвжин хөгжиж амиа авардаг.”<sup>1</sup>

Гэр бүл, хөршүүд, тойрог буюу салбарын гишүүд, нийгэм хамт олон тэр ч байтугай огт танихгүй хүмүүст туслахад шаардлагатай цаг зав, эрч хүчтэй байх нь амаргүй байж болно. Ялангуяа бид бүгдээрээ цаг зав багатай байгаа үед хэзээ, яаж бусдад туслах вэ? Нөхцөл байдал бидний боломжийг хязгаарлаж байгаа үед бид хэрхэн үйлчлэх вэ?

Өөрийгөө дагахад биднийг урьдаг Аврагч Есүс Христ бол бидний даган дуурайх Үлгэр Жишээ мөн (Матай 4:19-ийг үз). Бид хэдийгээр Түүний

бурханлиг дуудлагыг хуваалцдаггүй ч үйлчлэлийг нь хуваалцаж чадна. Энэхүү үйлчлэлийг Төлөөлөгч Петр дүрслэн Есүс “сайныг үйлдэж явсан юм” (Үйлс 10:38) гэжээ.

**Есүс өвчтөнүүдийг эдгээж, зовж зүдрэгсдэд үйлчилж явлаа** (Матай 9:20–22; Марк 8:22–25-ыг үз). Нас барсан хүнийг амилуулах зэрэг Түүний үйлдсэнтэй адил гайхамшгуудыг бид үйлдэж чадахгүй ч хайртай нэгнээ алдаад гашуудаж буй хүмүүсийг тайтгаруулах арга замуудыг олж чадна шүү дээ.

**Аврагч идэх юмгүй хүмүүсийг гайхамшигтайгаар хооллож байв** (Матай 14:15–21-ийг үз). Бид мацгийн өргөлийг өгөөмрөөр өгч, хүнс үйлдвэрлэх Сүмийн халамжийн төслүүдэд үйлчлэн, тусламж хэрэгтэй хүмүүсийг хоолоход нийгэмдээ хувь нэмэр оруулж болно.

**Есүс хувь хүмүүсийн төлөө санаа тавьж, тэдэнд үйлчилдэг байлаа** (Лук 8:45–48-ыг үз). Бид Түүний үлгэр жишээг дагахыг хичээсэн үед зовж зүдрэгсэд, ганцаардсан, хаягдаж мартагдсан хүмүүсийг олж харахад Сүнс бидний нүдийг нээх болно. Ингэснээр бид тэдний хэрэгцээг шийдвэрлэхэд туслахаар удирдагдаж чадна.

### 2001 он

- Ажил эрхлэлтийн алба шинэ сургалт нэвтрүүлэв. Дараа жил нь хувиараа ажил эрхлэх сургалтын материалуудыг нэвтрүүлэв.
- Есдүгээр сарын 5: Халамжийн Талбайн шинэчлэн засварлалт дууссаны дараа дахин онцгойлон адислах ёслол болов.



### 2003 он

- Нэгдүгээр сарын 25: providentliving.org вэбхуудсыг нээв.
- Бишопуудын агуулахын тоог дэлхий даяар нэмэгдүүлэх ерөнхий төлөвлөгөөг батлав.
- Сүм дөрвөн чухал санаачилга: сул дорой төрсөн нярай хүүхдийг сэхээн амьдруулах сургалт, цэвэр усаар болон тэргэнцрээр хангах, нүдний харааг хамгаалах төслийг эхлүүлэв.

**Есүс бусдад туслахаар төлөвлөөгүй байсан ч** (Лук 24:29-ийг үз) **санаа тавих ёстой ажил** **Өөрт нь өдий төдий байсан ч** (Матай 14-ийг үз) хүмүүст зориулан цаг гаргадаг байв. “[Өөрсдөдөө] буй хүчнээс илүү хурдан гүйхгүй” (Мозая 4:27) байхын тулд ухаалгаар үйлчлэхийг бидэнд зөвлөдөг билээ. Гэвч заримдаа хамгийн таагүй үед бусдад үйлчилж, тэднийг адислах агуу боломж гарч ирдэг явдал бий. Аврагчийн нэгэн сургаалт зүйрлэлд сайн самари хүн аяны замдаа саатаж, гай зовлонд өртсөн хүнд тусалдаг билээ (Лук 10:30–37-г үз).

**Аврагч хэнийг ч ажиглахгүй өнгөрөхгүй бөгөөд Түүний хувьд гар сунган туслахад хэн ч дорд бус юм** (Матай 9:9–13-ыг үз). Бид Аврагчийн энгэн адил бусдыг хайрлан, тэднийг өргөн дэмжиж, илүү сайн арга замыг тэдэнд заан, Аврагчийн санал болгодог сэтгэл хангалуун амьдралд өөрсөдтэйгөө нэгдэхэд тэднийг урьж чадна.

Тэнгэрлэг Эцэг бидний хүн нэг бүрийн авьяас чадвар, нөхцөл байдал, хүсэл эрмэлзлийг мэддэг. Бид бусдыг адислахын тулд эдгээрийг хэрхэн ашиглаж болохыг Тэрбээр бас мэддэг. Бид Түүнд ойртох тусам хэнд, хаана, хэрхэн үйлчлэх вэ гэдгийг мэдэхэд Тэрбээр бидэнд туслах болно.

Сүм, нийгэм, хамт олон, номлолын салбарт үйлчлэх болон хүмүүнлэгийн үйлчлэлийн талаарх санаануудыг **LDS.org** вэб-хуудсын Service section-д орж үзнэ үү.

#### ЭШЛЭЛ

1. Томас С.Монсон, “What Have I Done for Someone Today?” *Иахона* ба *Ensign*, 2009 оны 11-р сар, 85.

*“Бидний Бурхан ба Эцэгийн өмнө цэвэр ариун бөгөөд бузартаагүй сүсэглэл бол зовж зүдрэх цагт нь өнчин хүмүүс, бэлэвсэн эхнэрүүдийг эргэж тойрон, өөрийгөө хамгаалан дэлхийгээс бохирдохгүй байх нь ажгуу” (Иаков 1:27).*



Зүүн цаад талд: Перугийн Чулу-канас салбарын Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхийлөгч Чирок багш нарын чуулгын гишүүн Алекстай хамт салбарынхаа бэртсэн хүмүүст зориулан суга таяг хийж байгаа нь.

Эдгээр диконуудын цуглуулдаг мацгийн өргөл тусламж хэрэгтэй хүмүүст туслахад амин чухал юм.

## Олны хүч оломгүй далай

### Мацгийн хууль

Их Эзэн Өөрийн хүмүүсийг адисалж, тусламж хэрэгтэй хүмүүсийг анхаарч халамжлах арга замаар хангахын тулд мацгийн хуулийг өгсөн юм. Тэрбээр “эд юмсаа ядуустай хуваалцах, . . . болон [үүнийг] ядуус хийгээд гачигдагсдад өгөхийн тулд . . . бишопын өмнө тавигдах ёстойг” (С ба Г 42:31, 34) гэгээнтнүүдэд зааварлажээ. Мацгийн өргөл бол Их Эзэний агуулахын үндсэн нөөц юм. Сүм, гишүүдээ мацаг барин доод тал нь дараалсан хоёр хоолны үнэтэй тэнцэх үнийг өргөл болгохыг уриалдаг. Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл (1895–1985) “бид боломжтой байгаа үедээ илүү бүр илүү, арав дахин илүү” өгч байхыг гишүүдээс хүссэн юм.<sup>1</sup>

Бид мацгийн хуулийг ойлгож, түүгээр амьдарснаар зовж зүдэрсэн хүмүүсийг улам хайрлаж, тэдэнд өрөвч энэрэнгүй сэтгэлээр хандах нь өсөн нэмэгдэх болно. Залбирч, мацаг барих нь жинхэнэ шүтлэг бишрэлийн нэг хэлбэр мөн. Бид мацгийн

#### 2009 он

- Зургадугаар сар: [ItsAboutLove.org](http://ItsAboutLove.org) гэсэн хүүхэд үрчлэхэд зуучлах шинэ вэбхуудас нээв.<sup>3</sup>



#### 2010 он

- Дөрөвдүгээр сар: Ажил эрхлэлтэд дэмжлэг үзүүлэх [LDSjobs.org](http://LDSjobs.org) вэбхуудсыг англи, испани, португаль хэлээр гаргав.
- Хүнс үйлдвэрлэлийг хүмүүнлэгийн үйл ажиллагаанд нэмж оруулав.

#### ЭШЛЭЛ

1. “Humanitarian Activities Worldwide,” [providentliving.org/content/display/0,11666,4600-1-2323-1,00.html](http://providentliving.org/content/display/0,11666,4600-1-2323-1,00.html)-ийг үз.
2. С.Росс Клемент, “LDS Family Services” (ХҮГ Тэр Бүмийн Төсөлд зориулан бэлтгэсэн нийтлэгдээгүй түүх, 2000 оны 5-р сарын 10)-ийг үз.
3. Кимберли Баувер, “LDS Family Services Launches New Web Site,” *Ensign*, 2009 оны 9-р сар, 78-ыг үз.



АНУ-ын Люизана дахь санваартан ах нар 2005 онд Катрина хар салхи үндсээр нь булга татан унагасан модыг зайлуулахад тусалсан нь хэрэв бид бусдад үйлчлэхэд хүчээ нэгтгэвэл хүч хэд дахин нэмэгддэгийн бэлгэдэл болсон ажээ.



Тоор жимс үйлдвэрлэх мэтийн төслүүд нь өлсгөлөнд өртөж болзошгүй хүмүүст тус нэмэр болж, амьдралыг нь гэрэл гэгээтэй болгох олон нэр төрлийн тэжээллэг хүнс үйлдвэрлэх боломжийг олгож байна.

хуулийг дуулгавартай дагаснаар сүнсний хүч чадалтай болж, материаллаг адислалуудыг хүртэн, бусдад үйлчлэх илүү их хүсэл эрмэлзэлтэй болдог. “Мацгийн өргөлийн тухай үзэл баримтлал нь: Исаиа хүмүүсийг мацаг барихад дэмжин, ‘өлсгөлөн нэгэнтэй талхаа хуваан, орон гэргүй ядуусыг гэртээ оруулдаг’ [Исаиа 58:7] байх тухай санаа нь бүр эрт үед бий болсон юм” хэмээн Ерөнхийлөгч Томас С.Монсон заасан билээ. Бошиглогч Иосеф ядуучуудад зориулан мацгийн өргөл цуглуулах ажлыг Огайогийн Көртландад, дараа нь Иллинойн Наувуд үндэслэн бий болгосон бөгөөд Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга ‘мацгийн өргөлийн зарчмыг’ тодорхойлсон ерөнхий агуулгатай захидлыг Сүмд бичсэн ажээ. Уг захидалд: ‘Мацгийн өргөл цуглуулах нь бүх гэгээнтнүүдэд үлгэр дууриал болтугай, тэгвэл хэзээ ч талхаар дутагдахгүй: Ядуучууд өлсөж байгаа үед, юмтай хүмүүс нэг хоног мацаг барьж, идэх байсан зүйлээ ядууст илүүчлэн бишоптоо

*“Хэрэв энэ сүмийн гишүүн бүр мацаг барьж, өгөөмрөөр хандивлах юм бол зөвхөн Сүмийн ядуучууд болон тусламж хэрэгтэй хүмүүс төдийгүй бусад олон хүн адислагдаж, хэрэгцээт зүйлсээрээ хангагдах болно.”*

Ерөнхийлөгч **Гордон Б.Хинкли** (1910–2008), “Rise to a Larger Vision of the Work,” *Ensign*, 1990 оны 5-р сар, 97.

өгөг, тэгвэл хүн бүр урт удаан хугацаанд элбэг хангалуун байх болно.’ . . . Гэгээнтнүүд бүх нийтээрээ энэ зарчмаар хэдий чинээ урт удаан хугацаанд чин сэтгэлээсээ баяр баясгалантайгаар амьдарна, тэд үргэлж элбэг хангалуун байх болно.”<sup>2</sup>

### Хүнсний үйлдвэрлэл

Өлсгөлөн хүмүүсийг хооллохын тулд хүнс үйлдвэрлэж, боловсруулах нь халамжийн төлөвлөгөө бий болсон үеэс хойш үндэс суурь нь болсоор байгаа билээ. Юта даяар тархсан ногооны талбайнууд дээр өрнөсөн хөдөлмөрийн төслүүд нь 1000 гаруй фермийг хамарсан сүлжээ болж, Сүмийн гадас, тойргууд хүнс үйлдвэрлэх төслүүдийг хэрэгжүүлж байна. Халамжийн фермүүд Хойд Америк, Европ, Австрали, Полинезид ажиллаж байна. 1980-аад онд эдгээр фермүүд бэхжин, үйл ажиллагаа нь өргөжиж, тоног төхөөрөмж нь сайжирчээ. Зарим жижиг төслүүдийг худалдсан байна.

Эдгээр фермүүдийг өнгөрсөн үеийнхтэй адилхан Сүмийн гишүүд сайн дурын хөдөлмөрөөрөө дэмжиж байна. Тусламж хэрэгтэй хүмүүсийг дэмжихэд ашиглах хүнсийг үйлдвэрлэх, боловсруулах болон хуваарилан хүргүүлэхийн тулд гишүүд жил бүр хэдэн зуун мянган өдрийн хөдөлмөрөөрөө хандив өргөж байна. Жил бүр 45 сая кг гаруй үр тариа, шош, мах, жимс, хүнсний ногоо болон бусад зүйлийг үйлдвэрлэж, тусламж хэрэгтэй хүмүүсийг дэмжихийн тулд бишопуудын агуулахад нийлүүлж





Хонг Конгийн залуу эмэгтэйчүүд хүмүүсийн эн тэргүүний хэрэгцээг хангах байнгын хүч чармайлтын хэсэг болгон саван болон эрүүл ахуйн бусад зүйлсийг байгалийн гамшигт нэрвэгдэгчдэд зориулан цуглуулжээ.



Бусдад үйлчлэх төслүүд нь бидний хэлхээ холбоог бэхжүүлж, Христийнхтэй адил занг төлөвшүүлэхэд бидэнд тусалдаг. Мексикийн залуу Хожмын Үеийн Гэгээнтнүүд орчноо тохижуулах болон орон байраа угаахад оролцдог ажээ.

байна. Бишопуудын агуулах байхгүй газруудад бишоп болон салбарын ерөнхийлөгчид тусламж хэрэгтэй хүмүүсийг бараа бүтээгдэхүүн, үйлчлэлээр хангахын тулд мацгийн өргөлийг ашигладаг.

### Их Эзэний агуулах

Халамжийн хөтөлбөрийг 1936 онд үндэслэн бий болгосноос хойш Сүмийн гишүүд тусламж хэрэгтэй хүмүүст тулгарч буй зовлон бэрхшээлийг нимгэлэхийн тулд хамтран хөдөлмөрлөж байна. Эдийн засгийн хямрал, байгалийн гамшиг, ажилгүйдэл, өвчин эмгэг, хөгжлийн бэрхшээл болон хүнд цаг үед Гэгээнтнүүд хэрэгцээг шийдвэрлэж, хувь хүмүүс болон гэр бүлүүдийг адислахын тулд санваартны удирдагчдын удирдлага дор мөр зэрэгцэн ажиллаж байна. Сая сая гишүүн Ерөнхийлөгч Монсонгийн хэлснээр “нэг хүний сул дорой байдлыг хамтдаа үйлчлэгч олон хүний хүчээр даван туулж” бусдыг адислан, тэдэнд туслахын тулд олон жилийн турш цаг зав, авьяас чадвараа зориулж ирсэн юм.<sup>3</sup>

Ерөнхийлөгч Хебер Ж.Грант 1936 онд халамжийн тогтолцооны тухай 1936 онд өгүүлэхдээ: “Сүмд энэ ажлыг хариуцах шинэ тогтолцоо шаардлагагүй, харин гадас, тойргийн байгууллагууд, санваартны чуулгууд, Нийгмийн Халамжийн бүлэг, түүнчлэн туслах бүлгүүдийн янз бүрийн байгууллагууд Сүмийн ерөнхий халамжийн ашиг сонирхлыг биелүүлэхэд үйлчлэлийн дийлэнх хэсгийг үзүүлэх болно” хэмээн угтан хэлжээ.<sup>4</sup> Ядуучууд болон тусламж хэрэгтэй

хүмүүсийг адислахад шаардлагатай байгууллага санваартны чуулгууд, Нийгмийн Халамжийн бүлгийг Их Эзэн аль хэдийнэ үндэслэн бий болгосон юм. Мөн Бурханы санваар дэлхийд байлаа.

Ажил хөдөлмөр, авьяас чадвараа өргөл болгодог Сүмийн гишүүд бол Их Эзэний агуулахын салшгүй хэсэг мөн. Түүнээс гадна Сүмийн мацгийн өргөлийн санд төлдөг мацгийн өргөлөөс гадна тусламж нэн чухал хэрэгтэй байгаа хүмүүсийг адислахын тулд санваартны удирдагчид нийт гишүүдийн цаг зав, авьяас чадвар, эрч хүчийг зохион байгуулан чиглүүлдэг.

Бид тусламж хэрэгтэй хүмүүст ядарсан цагт нь туслах боломжийг ашигласнаараа Бурхан болон Түүний хүүхдүүдийг хайрлах хайраа харуулдаг. Энэ бол халамжийн тогтолцооны голт зүрх бөгөөд үүнийг итгэлтэйгээр хэрэгжүүлэх нь өгөгч, авагч хоёрыг хоёуланг нь өргөмжилдгийг өнөө үеийн бошиглогчид сургасаар байгаа билээ.

### ЭШЛЭЛ

1. Спенсер В.Кимбалл, Conference Report, 1974 оны 4-р сар, 184.
2. Томас С.Монсон, “Be Thou an Example,” *Ensign*, 1996 оны 11-р сар, 44.
3. Томас С.Монсон, “Messages of Inspiration from President Monson,” *Church News*, 2010 оны 2-р сарын 6, 2.
4. Хебер Ж.Грант, Жеймс Р.Кларкийн эмхтгэл, *Messages of the First Presidency of The Church of Jesus Christ of Latter-day Saints*, боть 6. (1965–75), 6:19; том үгсээр бичих дүрмийг стандартын дагуу болгосон.



*“Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн халамжийн төлөвлөгөө Бүхнийг Чадагч Бурханаас сүнслэгээр нөлөөлөгдсөн юм шүү гэдгийг миний дуу хоолой хүрэх бүх хүнд би тунхаглаж байна. Их Эзэн Есүс Христ бол чухамдаа уг төлөвлөгөөний Уран Барилгач юм. ‘Харагтун. Би үүдэн дээр зогсоод тогшиж байна. Хэрэв хэн нэгэн нь Миний дууг сонсоод хаалгаа нээвэл, Би түүний дотор орно’ (Илчлэлт 3:20) хэмээн Тэрбээр хэлснээр та бүхэнд болон надад гэрэлт цамхаг болж байгаа билээ.*

*“Түүний дууг сонсож, зүрх сэтгэлийнхээ хаалгыг Түүнд нээж өгцгөө. Түүний хүүхдүүдэд үйлчлэхийг бид хичээсэн үед Тэрбээр бидний байнгын хамтрагч байх болтугай.”*

**Ерөнхийлөгч Томас С.Монсон**, “The Way of the Lord,” in *Basic Principles of Welfare and Self-Reliance* (товхимол, 2009), 12.

## Халамжийн зарчмуудыг амьдралынхаа хэсэг болгох нь

**Х**аламжийн зарчмуудаар амьдрах гэдэг нь: Бид Есүс Христэд итгэх итгэлээ үйлдэл болгож, шаардлагагүй өр зээл тавихгүй байж, боломжиндоо тохируулан амьдарч, гэр бүлийн нөөц болон мөнгөн хуримтлал бий болгох явдал мөн. Бидний итгэл оюун ухаан болон гараа хөгжүүлж, бие даах чадвартай байхын тулд амьдралынхаа өдөр бүр ажиллах явдал уруу хөтөлдөг билээ. Бид өөрсдийнхөө хэрэгцээг шийдвэрлэснээр амьдралаа өнгөтэй өөдтэй явч яван, бусдад үйлчлэх чадвартай болно. Зөвлөгөөг сайн дагаад зогсохгүй өөрсдөө *сайжрахын* төлөө тэмцэж зөвхөн *сайжраад зогсох* төдийгүй *бур илүү сайжрахын* төлөө дагагсаа.<sup>1</sup> Их Эзэний зөвлөгөөнд дуулгавартай байх нь материаллаг болон сүнсний адислагуудыг авчирдаг. Энэ нь амьдралд тохиолддог сорилт бэрхшээлүүдийг айдас, эргэлзээгээр биш зориг, итгэлээр даван туулах боломжийг бидэнд олгодог.

Ерөнхийлөгч Томас С.Монсон бусдыг өргөж, адислах бидний үүргийн тухай ийн сануулжээ:

“Ах эгч нар аа, ‘Би өнөөдөр хэн нэгний төлөө юу хийв’ гэсэн асуултыг бид өөрсдөөсөө асуудаг байя. Дууллын эдгээр танил үгс бидний зүрх сэтгэлд нэвтэрч, тэнд байнга орших болтугай:

*Өнөөдөр би энэ дэлхийд ямар нэг сайн юм хийв үү?*

*Тусламж хэрэгтэй хэн нэгэнд туслав уу?*

*Уйтгар гунигт автсан хэн нэгнийг би хөгжөөж, хэн нэгнийг баярлуулав уу?*

*Хэрэв үгүй бол би үүргээ биелүүлээгүй хэрэг.*

*Миний ачаар*

*хэн нэгний ачаа дарамт өнөөдөр хөнгөрсөн үү?*

*Өвчтэй болон зовж зүдэрсэн хүмүүст зохих*

*ёсоор тусалсан уу?*

*Тусламж хэрэгтэй газарт би байсан уу?*

“Бидний дуудагдсан үйлчлэл Их Эзэн Есүс Христэд үйлчлэх үйлчлэл мөн.”<sup>2</sup> ■

### ЭШЛЭЛ

1. Роберт Д.Хейлс “A Gospel Vision of Welfare: Faith in Action,” *Basic Principles of Welfare and Self-Reliance* (товхимол 2009), 1.
2. Томас С.Монсон, “What Have I Done for Someone Today?” *Лиакхона* ба *Ensign*, 2009 оны 11-р сар, 87.

### НЭМЭЛТ ЭХ СУРВАЛЖУУД

Эдгээр хуудсууд дээр ярилцсан сэдвүүдийн талаар илүү ихийг мэдэх сонирхолтой байна уу? Доорх товхимлууд, DVD, вэбхуудсууд болон бусад эх сурвалжууд та бүхэнд ашиг тустай байж болох юм. Нэмэлт мэдээллийг [75yearsofwelfare.org](http://75yearsofwelfare.org)-т орж үзнэ үү.



Түүний халамжинд Грег Өүлсен

*“Таван бор шувуу хоёрхон ассараар худалдагддаггүй гэж үү? Гэсэн хэдий ч тэдний нэг нь ч Бурханы өмнө мартагдахгүй.*

*Үнэндээ толгой дээрх үс бүр чинь ч тоологдсон. Бүү ай. Та нар үй олон бор шувуунаас ч эрхэм үнэтэй” (Лук 12:6–7).*



**1829** онд эртний Төлөөлөгчид болох Петр, Иаков, Иохан нар Иосеф Смит, Оливер Каудери хоёр дээр ирэн тэдэнд Мелкизедек санваар олгосон билээ. Сүмийн бүх эрэгтэй гишүүн томилолтын үйл явцаар дамжуулан Бурханы нэрээр үйлдэх эрх мэдэл-санваарыг авч, ашиглах боломжтой юм. Хуудас 14, 16, 19-ийг үз.